

Албан хэрэгцээнд

**"АВЛИГА ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ
БАЙДАЛД НӨЛӨӨЛӨХ НЬ"**

**CORRUPTION AS A THREAT TO
NATIONAL SECURITY**

Улаанбаатар 2014



The Asia Foundation

АЗИЙН САН

Азийн сангийн дэмжлэгтэйгээр

"АВЛИГА ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛД НӨЛӨӨЛӨХ НЬ"

Онол-Практикийн хурлыг зохион байгуулав.

Эмхэтгэсэн:

С.Эрдэнэчимэг, Д.Түвшинбилэг

Хянасан:

Д.Пунцаг

Хэвлэлийн хуудас:

8 х.х

УИХ-ын Тамгын газрын
Хэвлэх цехэд эхийг бэлтгэж хэвлэв.

ГАРЧИГ

ӨМНӨТГӨЛ	5
“АВЛИГА ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛД НӨЛӨӨЛӨХ НЬ” <i>УИХ-ын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санаачлагаар зохион байгуулсан онол-практикийн хурлаас гаргасан зөвлөмж</i>	8
“АВЛИГА ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛД НӨЛӨӨЛӨХ НЬ” <i>Онол-практикийн хуралд УИХ-ын дэд дарга Л.Цогийн хэлсэн үг...</i>	11
“АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ЗАМААР ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ БЭХЖҮҮЛЭХ НЬ” <i>Ц.Оюунбаатар-УИХ-ын гишүүн, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны даргын илтгэл</i>	13
“АВЛИГА ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛД НӨЛӨӨЛӨХ НЬ” <i>Судалгааны дүн</i>	21
“ӨНДӨР ТҮВШНИЙ АВЛИГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХЭД ИРГЭНИЙ НИЙГМИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮҮРЭГ” <i>В.Удвал-Эмэгтэй удирдагч сангийн Удирдах зөвлөлийн даргын илтгэл</i>	41
“МОНГОЛ УЛСЫН АВЛИГЫН ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭЖ БҮЙ ЗҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫГ ХБНГУ-ЫН ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТТАЙ ХАРЬЦУУЛАХ НЬ” <i>Б.Өнөрмаа-Улсын Ерөнхий Прокурорын газрын хяналтын прокурор, Хууль зүйн ухааны доктор</i>	45
“ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ: АВЛИГЫГ ҮЛ ТЭВЧИХ ҮЗЭЛ” <i>О.Очиржав-Аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албаны дарга</i>	53
ХУРЛЫН ФОТО ЗУРАГ	56

**“ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛД ӨНДӨР ТҮВШНИЙ
АВЛИГА НӨЛӨӨЛӨХ НЬ”**

О.Мөнхбат. Доктор, профессор МУИС-ийн Сургалт эрхэлсэн дэд захирал, С.Мөнхбат. Доктор, дэд проф МУИС-ийн Улс төр судлалын тэнхимийн эрхлэгч, М.Батбаатар. Докторант, МУИС-ийн Социологи, нийгмийн ажлын тэнхимийн багш 60

“ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ БА ӨНДӨР ТҮВШНИЙ АВЛИГА”

сэдэвт судалгааны дүн МУИС-ийн Улс төр судлалын тэнхим, МУИС-ийн Социологи, нийгмийн ажлын тэнхим 69

ӨМНӨТГӨЛ

/МӨХӨЛ СҮЙРЛИЙН ХАРАНГА ДЭЛДЭЖ БАЙНА/



Монголын ард түмний төлөөлөгчдийн дээд байгууллага-Монгол Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо санаачлан “Авлига үндэсний аюулгүй байдалд нөлөөлөх нь” сэдэвт онол-практикийн хурлыг зохион байгуулжээ.

Онол-практикийн энэхүү хурлыг ингэж нэрлэсэн нь авлига, хахуулиас болж Монгол төр хүч чадлаа алдаж, улс орны хөгжил дэвшил зогсож, ард түмний аж амьдрал доройтож, сэтгэл тэнүүн байдал улам бүр алдагдсаар байна гэсэн сэтгэл сэртхийлгэсэн санааг шууд илэрхийлжээ.

Тус Байнгын хорооны дарга, докторант Ц.Оюунбаатар тавьсан илтгэлдээ “Энхийг эрхэмлэсэн, эвсэлд үл нэгдэх, төвийг сахисан Монгол Улсад гадаад улс орны шууд аюул занал байхгүй. Харин дотроосоо авлигад идэгдэж, ард түмний татвараар бүрдсэн төсвийн мөнгийг завшиж байгаа авлигачид монгол орныг аюулд учруулж, гадныханд эх орон, газар шороо, баялгаа найр тавин өгөх аюултай” хэмээн маш ончтой онцолсон.

Манай улс дэлхийн хамтын нийгэмлэгийн салшгүй бүрэлдэхүүн хэсгийн хувьд Авлигын эсрэг НҮБ-ын конвенц /UN-CAC/-д нэгдэн орсон боловч түүнийг шударгаар, хэлбэрэлтгүй сахин мөрдөж чадаагүй л байгааг тус онол-практикийн хурлаас тэмдэглэсэн.

Алдарт аялагч Марко Поло “Чингис хааны засаглал шулуун шударга, хүн арддаа ээлтэйг үзэж мэдсэн бусад орны хүн ард түүнтэй өөрсдөө ирэн нийлэн нэгдсээр байв” хэмээн аян замын тэмдэглэлдээ бичсэн байдаг. Энэхүү аян замын тэмдэглэлийг Колумба, Америк тивийг нээх аялалдаа авч яван уншиж байсан гэх сонирхолтой баримтыг Германы эрдэмтэд дэлгэсэн юм.

Чингис хаан авлига, хахуулийг сүйрэл, доройтлын муу ёр шүглэсэн аюултай зүйл хэмээн үздэг байжээ. Энэ талаар их бичгийн хүн В.Инжаннашийн “Хөх судар”-даа бичсэн нэгэн баримтыг дурьдах нь их сургамж болох ач холбогдолтой хэмээн үзэв:

-Алтан улсын хааны элч төлөөлөгч Чингис хаанд бараалхах хүсэлтээ олон удаа цөхрөлтгүй гаргасан учир түүнийг хүлээн авч уулзахаас өөр аргагүй байдалд их хааныг оруулжээ. Бараалхалтын үеэр Алтан улсын хааны элч Чингис хааныг бүр тэнгэрт тултал магтаж, түүнд том цол олгож, асар их хэмжээний бэлэг сэлт хүртээх болсныг уламжлаад тэдгээрийг гардуулж өгөх гэхэд Чингис хаан санаа нь зовсон янзтай ихэд цааргалан, элч рүү яламгүй мушилзан:

-Надад эрдэм чадал үгүй, миний оюуны тэнхээ тамир мөхөс байтал юуны учир танай улсын эзэн хаан намайг хэтэрхий хүндлэн үзэж, эдгээр зүйлийн цол, өргөмжлөл, элдэв бэлэг сэлтийг илгээсэнд маш баярлан талархаж баршгүй. Манай улс гагцхүү шулуун шударгыг сахил болгодог тул энэ хоосон цол, цаасан өргөмж бидэнд тус болохгүй.

Манай улсад бат шулуун, чигч шударгыг баримталдаг тул улсын эзэн ийм үнэт бэлэг сэлт авах нь хатуу хориотой. Хэдийгээр хэн хүнд шар алт, өнгөт хоргой торго, гэрэлт сувт эдлэн хэрэглэхэд таатай боловч миний хувьд бусдаас авах нь цээртэй гэв.

Алтан улсын хааны элч өмнө газрын зангаар цол, алт, сувд эрдэнэс, хоргой торгоны хэр зэрэг үнэ цэнэтэйг Чингис хаанд тайлбарлан ойлгуулах гэж ихэд чармайхад тэрбээр дахин тасалдуулан,

-Манай улсад эдгээрийг хэзээд ч чухалд үздэггүй. Гагцхүү хичээх нь эзэн нь итгэмжтэйгээр энэрэх, ноёд нь чигчээр зүтгэх. Хэрэв эзэн нь хомхой, түшмэл нь залхай зусар болоод эрэх нь эд ашиг хүсэх нь зугаа цэнгэл болбоос юу болох билээ. Улсаа батжуулж, олноо амаржуулах, төрөө түвшитгөн, түмнээ жаргуулах үүрэг хариуцлага хүлээсэн надад цол, өргөмж, алт, сувд эрдэнэс, хоргой торго гай болно гэсэн гэдэг.

Одоо хүртэл манай зарим төрийн түшээд Чингис хаанаа олз ашиг хайсан их аян дайн хийсэн мэтээр олон нийтийн мэдээллийн хэрэгслээр үүх түүхээ нарийн судлалгүй ярьсаар байгаа нь түүний

Тэнгэрийн ивээлээр болсон

Мөрийг минь бүү мөшгөөгтүн

Бус /муу/ сэтгэлтний үгэнд орж

Мөхөсдүүлэн сэтгэвээс

Мөн зарлиг, засаг нь мөхөсдүүн" /Алтан товч/

хэмээсэн гэрээсийг уландаа гишгэсэн хэрэг юм. Морь, тэмээгээр тэр алс холоос хичнээн юм зөөхөв дээ. Монголчууд Та бидний идээшин бөөгнөрөн амьдарч байгаа Чингис хааны гал голомт болсон Монгол Улсын нутаг дэвсгэрт Их эзэн хаан харийн нутгаас тоон дээрэмдэж ирсэн нэг ч олдвор олдоогүй гэдгийг бүү мартацгаа.

Чингис хааны үед тогтоосон хахуульгүй, чигч шударга ёс яван явсаар санаад үл багтам хол орон зайд нэвтрэн, тал хээрийн нүүдэлчин ард түмнийг өдий төдий гүрэн, үндэстэн угсаатан, өөр өөр соёл иргэншилтэй улс түмэнд шударга ёсыг тогтоогчид болгон хувиргаж байсан билээ. Одоо монголчуудын энэ эрхэм чанар арилж, огтхон ч байгаагүй юм шиг санагдах болжээ. Хэрэв энэ нандин чанар сорви мэт эдгэчих юм бол Монгол Улс сүйрэл мөхлийн ирмэгт тулж очсон нь тэр.

Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос зохион байгуулсан “Авлига үндэсний аюулгүй байдалд нөлөөлөх нь” сэдэвт онол практикийн хурал ийм аюул нүүрлэсэн харангыг дэлдэж байна.

*Академич, ШУА-ийн философи, социологи,
эрх зүйн хүрээлэнгийн зөвлөх С.Нарангэрэл*

**УЛСЫН ИХ ХУРЛЫН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД
БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ САНААЧЛАГААР
ЗОХИОН БАЙГУУЛСАН “АВЛИГА ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ
БАЙДАЛД НӨЛӨӨЛӨХ НЬ” ОНОЛ-ПРАКТИКИЙН
ХУРЛААС ГАРГАСАН ЗӨВЛӨМЖ**

Авлигын өнөөгийн нөхцөл байдал улс орны хөгжлийг сааруулж, эрх зүйт төрийн бодлогод сөргөөр нөлөөлж, улс төр, эдийн засаг, хууль зүй, нийгмийн бүхий л хүрээнд нэвчин тархаж тогтолцооны шинжтэй болсон явдал манай улсын үндэсний аюулгүй байдал, тусгаар тогтнолд аюул учруулж байгаа тул авлига, хүнд сурталтай тууштай, үр нөлөөтэй тэмцэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Онол-практикийн хурлын хүрээнд Монгол Улсад авлига цэцэглэн “хөгжиж” байгаагийн шалтгааныг зөв тогтоох, түүнтэй тэмцэх арга замаа тодорхойлох зорилгоор авлигатай тэмцэх талаар мэргэшсэн шинжээчдийн судалгаа, дүгнэлт болон нийгмийн олон давхаргыг хамруулсан 500 гаруй хүнээс авсан санал асуулгын дүн, хуралд тавьсан илтгэлүүдэд дэвшүүлсэн зорилт, хуралдааны явцад эрдэмтэд, судлаачид, ажил хэрэгч хүмүүсийн гаргасан үнэтэй саналыг үндэслэн Улсын Их Хурал, Засгийн газарт хандаж доорх зөвлөмжийг гаргаж байна.

Эрх зүйн орчны хүрээнд:

1. Монгол Улсын Үндсэн хууль, Сонгуулийн багц хууль, Улс төрийн намын тухай хуулиудад өөрчлөлт оруулах замаар улс төрийн авлигын хамгийн түгээмэл хэлбэр болох сонгуулийн авлигыг хязгаарлан зогсооход чиглүүлж, сонгогчдын саналыг худалдан авдаг боломжуудыг бүрэн хаах, намын санхүүжилтийг ил тод, хөндлөнгийн хяналттай болгох, сонгуульд нэр дэвшигчид шударгаар өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх талаар дорвитой алхмуудыг хэрэгжүүлэх.
2. Авлигын гэмт хэргийн тодорхойлолт, хамрах хүрээ, хүлээлгэх хариуцлагыг нарийвчлан тодорхойлж, авлига түүний дотор өндөр түвшний авлигатай тэмцэх, хэргийг илрүүлэх, шийдвэрлэх ажиллагааг Гэмт хэргийн хуулийн төсөл, Авлигын эсрэг хууль болон бусад холбогдох хуулиудад тусгах,

3. Авлигын эсрэг НҮБ-ын конвенцид нийцүүлэн үндэсний хууль тогтоомжоо боловсронгуй болгох,
4. “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг шинээр боловсруулан Улсын Их Хурлаар батлуулах,
5. Төрийн албыг улс төрөөс хараат бус, мэргэжлийн байх хуулийн шаардлага, заалтыг хатуу баримтлан хууль бусаар хөрөнгөжих ашиг сонирхлын зөрчилтэй хүмүүсийг төрийн албанд томилж, авилгыг тэлж байгаа сөрөг үзэгдлийг таслан зогсооход төр, хууль, хяналтын байгууллагын үйл ажиллагааг чиглүүлэн, хүний эрх, эрх чөлөөнд хууль бусаар халдахгүйгээр зохистой шийдвэрлэдэг байх тодорхой зүйл, заалтыг Төрийн албаны тухай хуульд тусгах,
6. Төрийн өндөр албан тушаалтны халдашгүй байдлын талаарх хуулийн зохицуулалтыг өөрчлөх, Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүд зэрэг төрийн өндөр албан тушаалтан бусад төрийн албан тушаалтай нэгэн адил хуулийн өмнө тэгш эрхтэй байх зарчмыг хэрэгжүүлэх,
7. Өндөр түвшний авлигаас урьдчилан сэргийлэх цогц бодлогын хүрээнд хууль, тогтоомжийн төслүүдэд ил тод байдлыг хангах, авлигад өртөх эрсдлийн үнэлгээг мэргэжлийн шинжээчид хийдэг эрх зүйн зохицуулалтыг бий болгох,

Хууль сахиулах үйл ажиллагааны хүрээнд

1. Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй боловсруулан хэрэгжүүлж, авлигыг үл тэвчих үзлийг хэвшүүлэн, ёс зүйтэй шударга иргэн төлөвшүүлэх чиглэлд төрийн болон иргэний нийгмийн байгууллагуудын хамтын үйл ажиллагааг идэвхжүүлж, иргэдийг авлигын эсрэг тэмцэлд идэвхтэй оролцуулах,
2. Өндөр түвшний авлигатай тэмцэх арга, хэлбэрийг боловсронгуй болгож, авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, үр нөлөөтэй байнгын хяналт, шалгалтыг авлигын өндөр эрсдэлтэй байгууллага, албан тушаалтнуудыг хамруулах,
3. Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ, ашигт малтмалын тусгай зөвшөөрөлийн олголт, худалдан авах ажиллагааны шалгаруулалтад тавих төрийн болон иргэний нийгмийн хяналтын тогтолцоог боловсронгуй болгох,

4. Авлигын хэрэг үйлдсэн нь тогтоогдсон бол гэм буруутай этгээдэд хуульд заасан шударга шийтгэл ногдуулах, нийгэм, иргэдэд учруулсан хохиролыг заавал барагдуулж, олон нийтэд мэдээлэх,
5. Өндөр түвшний авлигатай тэмцэх, өндөр түвшний авлигын хор уршгийн талаарх олон нийтийн ойлголт, хандлагыг төлөвшүүлэх чиглэлээр хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллаж, эрэн сурвалжлах сэтгүүл зүйг хөгжүүлж, албан тушаалтны хууль зөрчсөн, ёс зүйгүй үйл ажиллагааг олон нийтэд хүргэх мэдээлэх нөхцөлийг бүрдүүлэх.

ОНОЛ-ПРАКТИКИЙН ХУРАЛД ОРОЛЦОГЧИД
2014 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр

**“АВЛИГА ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛД НӨЛӨӨЛӨХ НЬ”
ОНОЛ-ПРАКТИКИЙН ХУРАЛД
УИХ-ЫН ДЭД ДАРГА Л.ЦОГИЙН ХЭЛСЭН ҮГ**

2014.11.06

Энэ онол-практикийн хурал нь их ач холбогдолтой гэж үзэж байна. Авлигын асуудал өөрөө нийгмийн “хорт хавдар” болсон, энэ асуудалтай тэмцэх орчин цагийн одоогийн түвшний арга барилыг тодорхойлох, Монгол Улсын Их Хурлаас гарах хууль тогтоомжийн орчинг боловсронгуй болгоход ихээхэн ач холбогдолтой. Энэ хуралтай холбогдуулж АБГББХ, Авлигатай Тэмцэх газар, Азийн Сан, МУИС болон Эмэгтэй удирдагч сан зэрэг байгууллагууд хамтран санал асуулгын болон экспертын судалгаануудыг амжилттай хийж гүйцэтгэсэнд талархаж байна. Энэ судалгааны үр дүн бол хамгийн сүүлийн үеийн мэдээлэл тул өнөөдрийн хуралд илтгэл хэлбэрээр үр дүнгийн танилцуулах болно.

Авлигыг олон янзаар илрүүлж, олж харж болдог. Миний бие 15 жилийн өмнө Хууль зүйн сайд байхдаа АНУ-ын Нью-Йорк хотноо болсон Дэлхийн Хууль зүйн сайд нарын зөвөлгөөнд оролцсон бөгөөд тус зөвөлгөөнд дэлхий даяар авлигатай тэмцэх асуудлын талаар хэлэлцэж байсан. Тэр үед АНУ-ын Дэд Ерөнхийлөгч байсан ноён Гор хэлэхдээ “АНУ сүүлийн 10-20 жилд ардчилсан засаглалтай улс оронд туслалцаа дэмжлэг үзүүлэх чиглэлээр ажиллаж ирсэн бөгөөд үүнээс хойш ч гэсэн хэн авлигатай сайн тэмцэнэ тэр улс орныг бид дэмжиж ажиллана” гэж хэлсэн байдаг.

Авлига монгол төрийг сулруулж, нэр хүндрийг унагаж, төсөв, татварын мөнгөөр намын албан тушаал авсан цөөн хэдэн хүн дур зоргоороо ашиглаж завшсан байна. Та бүхний гаргасан судалгаа Авлигатай тэмцэх газар, цагдаагийн байгууллагаас олон тэрбум төгрөгийн хохиролтой авлига, албан тушаалын хэрэг илрүүлж /бараг 100 орчим тэрбум/ байгаа юм байна. УИХ болон орон нутгийн сонгуульд 100 тэрбум төгрөгийн үргүй зардал гарч, далд эдийн засгийн бохир мөнгө угаадаг юм байна.

Тэгэхээр Монгол Улсын өнөөгийн авлигын нөхцөл байдал үндэсний аюулгүй байдалд нөлөөлөх түвшинд очсон нь түгшүүртэй байна. Авлигатай тэмцэх асуудал нь бүх нийтийг хамарч, нийтийн

зорилго болж чадахгүй байна гэдэг дүгнэлтийг хийх ёстой. Цөөхөн байгууллага, хэдхэн хүний асуудал юм шиг хаяж болохгүй, цаашдын арга замын талаар өнөөдрийн хурлаар яригдана гэдэгт их олзуурхаж байна.

Монгол Улсын Их Хуралд авлигатай тэмцэх Мон-Пак УИХ-ын гишүүдийн албан бус бүлэг бий, энэ бүлгийн гишүүд хуралд идэвхтэй оролцох ёстой гэж бодож байна.

Хурлыг зохион байгуулах ажилд туслалцаа дэмжлэг үзүүлж байгаа Азийн Сангийн Монгол дахь суурин төлөөлөгч хатагтай Мелони Линдбергд онцгойлон талархаж байгаагаа илэрхийлмээр байна.

Авлигатай тэмцэх тэмцэл бол дэлхийг тойрсон асуудал. Нэг үеэ бодвол Монгол улс авлигатай тэмцэх асуудлаар тодорхой бүтэцтэй болж, эрх зүйн орчинтой болсныг хэлэхэд таатай байна.

Миний туршлагаас ярихад энэ тэмцэлд улс төрийн зориг хэрэгтэй байдаг юм.

Миний бие 1999 онд Хууль зүйн сайд байхад Улсын Их Хурлын 3 гишүүн авлигын хэрэгт холбогдож, тэдгээр гишүүдийг шалгуулах асуудал хөндөж тавьсныхаа төлөө огцорч байсан билээ.

Өчигдөр Монгол Улсын Ерөнхий сайд Алтанхуяг огцорлоо. Нэг л шалтгаан байсан-Монгол Улсын хууль, тогтоомжийг удаа дараа зөрчсөн, хуулийг нулимсан, уландаа гишгэдэг гэсэн дүгнэлттэй байсныг та бүхэн санаж байгаа байх. Шударга ёсны төлөө тэмцэл бол их хатуу, хэцүү хэрнээ тэмцэхгүй байж болохгүй ийм л том үзэгдэл шүү дээ. Ингээд та бүхэнд, энэ хурлын үйл ажиллагаанд амжилт хүсье, Монголын нийгэмд авлигыг ойлгуулах, соён гэгээрүүлэх чиглэлээр, эрх зүйн орчинг шинээр бүрдүүлэх чиглэлээр шинэ алхам хийхэд Та бүхэнд энэ хурал дэм болно гэдэгт найдаж байна. Анхаарал тавьсанд баярлалаа.

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ЗАМААР ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ БЭХЖҮҮЛЭХ НЬ

*Ц.Оюунбаатар -Улсын Их Хурлын гишүүн,
Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын
хорооны даргын илтгэл /товчлон нийтлэв/*

Монгол Улс дахь авлигын нөхцөл байдал ямар хэмжээнд байгаа энэ үзэгдэл нь үндэсний аюулгүй байдал, тусгаар тогтнолд нөлөөлөх хэмжээнд хүрсэн үү, хэрэв хүрчихсэн юм бол бид юу хийх ёстой вэ гэдгийг ярилцахаар цуглараад байна.

Эдийн засагт эрүүл бус орчин бий болгож, шударга ёс, тэгш байдлыг алдагдуулдаг нийгэм дэх хууль бус сөрөг үзэгдэл болох авлига, хээл хахууль нь улс орны эдийн засгийн хөгжлийг сааруулж, эрх зүйт төрийн бодлогод сөрөг нөлөө үзүүлж улмаар тухайн орны үндэсний аюулгүй байдал, тусгаар тогтнолд аюул занал учруулдаг гэж дэлхий даяараа хүлээн зөвшөөрдөг. Нийгмийн үзэгдэл гэдэг утгаар нь авч үзвэл авлига, хээл хахууль гэгч нийгмийн хөгжлийн аль ч үе шатанд ямар нэг хэмжээгээр байсаар байсан. Түүнийг хазаарлан зогсоож болно.

Өнөөгийн монгол оронд авлига нь улс төр, эдийн засаг, хууль зүй, оюун санааны хүрээнд гээд нийгмийн бүхий л салбарт нэвчин тархаж, тогтолцооны шинжтэй болсон авлига үндэсний аюулгүй байдал, тусгаар тогтнолын баталгааны дархлааг сулруулдгаараа хамгийн аюултай.

Онол практикийн хурал зохион байгуулах ажлын хүрээнд Монгол улс дахь авлигын өнөөгийн нөхцөл байдал болон авлига цэцэглэн “хөгжиж” байгаагийн шалтгааныг зөв тогтоох, түүнтэй тэмцэх арга замаа тодорхойлох зорилгоор нийгмийн олон давхаргыг хамруулсан ажил хэрэгч 500 хүний дунд сонирхолтой асуулга явуулж, эрдэмтэн, судлаачдын хүчийг ашиглан энэхүү судалгаагаар мэргэжлийн дүгнэлт гаргууллаа. Эндээс гарч байгаа дүгнэлт, санаа оноо та бидний хэлэлцэж буй асуудлын бодит байдлыг харуулна байхаа.

Монгол Улсын авлигын ерөнхий нөхцөл байдлын талаарх олон улсын байгууллагуудын үнэлгээ болон үндэсний хэмжээнд хийгддэг бусад судалгааг үндэслэн авлигын ерөнхий нөхцөл байдлыг тодорхойлсноос үзвэл 2013 оны судалгаанд 177 орныг

хамруулснаас Монгол Улсын хувьд авлигын төсөөллийн индексийн утга 38 гэсэн үнэлгээгээр 83 дугаар байрт оржээ. Өмнөх онуудын байдлаар харьцуулбал нааштай үзүүлэлт боловч манай орны авлигын хэмжээ, хүрээ огтхон ч хумигдаагүй өргөжин тэлсээр байгааг өнөөгийн судалгаа харуулж байна.

АТГ-аас мөрдөн байцаалт явуулсан хэргийг өмнөх онтой харьцуулан үзэхэд төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах хэрэг 38.5 хувиар, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан эрх мэдлээ урвуулах гэмт хэрэг 31.5 хувиар, хээл хахууль өгөх, зуучлах гэмт хэрэг 5-50.0 хувиар тус тус өсчээ. Хамгийн гол нь эдгээр хэргүүдийн гаралт, учруулсан хохирлын хэмжээ, аюул нь жил дараалан өсөөд байгаа тул хойшлуулашгүй хариу үйлдэл хийхийг шаардаж байна.

Судлаач А.П. Дубнов гэгч “Авлига бол төрийн хүчин чадал доройтож үүрэг, зорилтоо биелүүлэх чадваргүй болох явдал”¹ гэж үндэсний аюулгүй байдал, тусгаар тогтнолд нөлөөлж ямар үр дагавар бий болгодгийг товчхоноор тодорхойлсон байдаг.

Авлига улс орны хөгжилд саад тотгор болж улс төрийн тогтвортой байдал, эдийн засгийн эрчимтэй хөгжил, ардчилал, шинэчлэлийн үйл явцыг сааруулах, гадаадын хөрөнгө оруулалт, зээл тусламжийн үр ашгийг бууруулах, ажилгүйдэл, ядуурал нэмэгдэх хүчин зүйл болж байгаад нийтээрээ санаа зовниж байна. Авлига эдийн засагт үүрлэснээр нийгмийн баялгийн шударга хуваарилалтын зарчим алдагдаж далд эдийн засгийн нөлөө албан ёсны эдийн засгийнхаас хүчтэй болж баян, ядуугийн ялгаа ихсэж, нийгмийн хангамж, халамжийн бодлогыг сулруулна.

Ардчилсан нийгэмд хууль ёсыг дээдлэх зарчим үйлчилдэг бол авлигажсан нийгэмд хууль тогтоомжийг авлигачдын хүсэл сонирхолд нийцүүлэн гаргах, эсхүл нэгэнт гарсан хууль тогтоомжийг үл хэрэгсэн дур зоргоор авирлах явдал хэвийн үзэгдэл болон хувирсан байдаг бөгөөд авлига бий болох нөхцөл нь хөгжлийн тодорхой үе шатанд Засгийн газраас явуулж буй үйл ажиллагаанаас шалтгаалдаг гэж үздэг.

¹Дубнов А.П. Коррупция как глобальная проблема современности www.crime.vl.ru/from

Авлигыг “Итгэл үзүүлж, олгосон эрх мэдлийг хувийн ашиг сонирхолдоо урвуулан ашиглах” явдал гэж хамгийн ойлгомжтойгоор томъёолсон байдаг.

Тэгвэл намын харьяаллаар, сонгуулийн үр дүнгээр ажилд томилогдосод, ашиг завшаан хайж төрийн албанд шургалагсад, “төрлийн алба” хашигсад бидний итгэл, хүлээлтийг үл хэрэгсэн богино хугацаанд хөлжин хөрөнгөжих, ил далд бүхий л арга замыг маш идэвхтэй эрэлхийлж, өөрт ашигтай боломж бүхнийг ашиглах гэсэн сэтгэлгээтэй буй нь илт байна.

Сайн, муугийн тухай ёс суртахууны үнэлэмж өөрчлөгдөж авлигаар ажил бүтээхийг ердийн үзэгдэлд тооцож, хувийн зан суртахуун, албаны ёс зүйгээ гээсээр байна. Оюун санааны үнэт зүйлд нөлөөлж байгаа авлигын үр дагавартай холбоотойгоор нийгэмд хууль тогтоомжийг дээдлэх явдал аажмаар суларч түүний оронд шүүх болон хууль сахиулах байгууллагад үл итгэх, шударга ёсыг үгүйсгэх явдал газар авсаар байна.

Монгол оронд улс төрийн коррупцын хамгийн түгээмэл хэлбэр нь сонгуулийн авлига юм. Энэхүү авлигын компани ажил нь 4 жилд нэг удаа болдог бөгөөд хэмжээ, далайцаараа улс орныг бүхэлд нь хамарсан шинж чанараараа авлигыг хөгжөөн дэлгэрүүлж байгаагаараа онцгой юм.

Монгол улсын сүүдрийн эдийн засгийн гол цөм, мөнгөний эргэлт сонгуулиар илэрдэг бөгөөд бизнесүүд, албан бус секторын хар мөнгө сонгуульд өөрийн хүнээ, намын нэр дэвшигчээ дэмжих, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, ТВ-ийн сувгуудыг худалдан авах, ухуулагч нэртэй өөрийн төлөөний хүмүүсийг олон авар, зуугаар нь ажиллуулж, айл өрх, иргэдэд мөнгө тараах, төрийн болон сонгуулийн албан тушаалтыг худалдан авах, төрийн өндөр албан тушаал, тэр ч байтугай УИХ-ын гишүүний суудлыг 500 саяас 1 тэрбум төгрөгөөр худалдаж авах нь энгийн үзэгдэл болсон.

Нэгэнт хахуулиар сонгогчдын саналыг худалдан авч, УИХ-ын гишүүн, орон нутгийн хурлын төлөөлөгч болсноор цаашдын эрх мэдлийн нөлөө ихсэж, гаргасан зардлаа нөхөх, тендер авах албан тушаалд өөрийн хүнээ томилуулах боломжтой болдог. УИХ, болон орон нутгийн хуралд мөнгөөр орж ирснээр өөрөө дархлагдаж, хууль хяналтын байгууллагад халдашгүй эрх мэдэлтэй болж хувирдаг. Энэхүү системчлэгдсэн процедурийн гол субъект нь улс

төрийн намууд юм. Өнөөгийн эрх барьж байгаа АН, Сөрөг хүчин монгол ардын нам ч үүнд гаршсан. Энэ төрлийн авлигыг зохион байгуулагчид болдог бөгөөд энэ нь үндэсний аюулгүй байдалд хамгийн хохиролтой, эх оронч шударга иргэд сонгуульд оролцож, ялалт байгуулах ямар ч боломжгүй юм.

Та бүхэнд цөөхөн тоо баримт дурдъя. Улс төрийн буюу өндөр түвшний авлигаар жишээ авч үзье.

Нам эвслүүд Улсын Их Хурлын сонгуульд	2004 - 1,6 тэрбум
	2008 - 7,9 тэрбум
	2012 - 36 тэрбум

төгрөг тус тус зарцуулсан байна. Зөвхөн 2012 оны Улсын Их Хурлын сонгуульд АН-16,2 тэрбум, МАН-14,2 тэрбум төгрөг, Шударга ёс эвсэл 3 тэрбум төгрөг зарцуулсан дүнг Сонгуулийн Ерөнхий хороонд гаргаж өгсөн боловч нэр дэвшигчдийн хувиараа зарцуулсан мөнгө бүрэн тусаагүй, дал эдийн засагт эргэлдэж буй асар их бохир мөнгийг эргэлтэнд оруулах, иргэдийн саналыг худалдаж авах, реклам сурталчилгаанд 100 орчим тэрбумыг цацаж байна.

Улс орныг хэрсэн томоохон авлига газрын болон ашигт малтмалын лицензийн арилжаанд суурилсан авлига юм. 2003 онд газрын хууль батлагдсанаар монгол хүн газраа өмчлөх өмчлөх, өмчтэй болох сайхан боломж нээгдсэн ч нийслэл, ихэнх аймаг, хотын удирдлага, газрын албаныхан эрх мэдэл албан тушаалаа ашиглан гадаад, дотоод бизнесүүдэд газрыг худалдаж мөнгө босгох, хөрөнгөжих, түүний тодорхой хэсгийг өөрийн дээд удирдлага, нам, фракцдаа хандив болгож өгдөг. Гэтэл 0,07 га газрыг өмчилсөн иргэдийн тоо 10 хувьд хүрэхгүй байна. Нийслэл болон томоохон төв суурингийн бүх газрууд ийм замаар худалдагдаж хот суурингийн газрын нөөц дуусч, авлигач түшмэлүүд олон 100 тэрбум төгрөгийг халаасалсан. Сүүлийн үед малчдын малын бэлчээрийн газрыг, аймаг, сумын удирдлагууд гол төлөв гадаадын компаниудад 1 га газрыг 60-150 мянгаар худалдаж мөнгийг завшиж байгаа мэдээлэл ирж байна. Уул уурхай хөгжсөн аймаг сум, хилийн бүсийн газруудыг авлигачид олон арван тэрбум төгрөгөөр худалдсан. Манай Авлигатай тэмцэх газар, цагдаагийн байгууллага үүнийг анзаараагүй мэт өнгөрөөдөг. Газар худалдсан мөнгө дарга нарын карманд ордгийг

сумын иргэд гомдоллон ярьж байна. Ашигт малтмалын орд газрын лицензүүдийг эрх мэдэлтнүүд авлигаар авч цааш нь гол төлөв гадаадын компаниудад 5, 10, 20 сая доллараар худалдан борлуулж Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн газар түүний доорх баялаг ард түмний мэдэлд байх заалт тунхаг төдий болжээ. Үүнийг зохицуулах, боловсронгуй болгох, олон нийтэд ил тод, дуудлага худалдаа явуулж, татвар төлбөрийг хураах авлигыг хязгаарлах талаар төрөөс бараг юу ч хийсэнгүй. Авлига төрийн байгууллагуудад улам бүр нэвчиж авлигад өртөөгүй эсвэл авлига бага салбар бараг үлдсэнгүй.

Авлигын байдлыг хүн амын тоонд харьцуулсан судалгаагаар дэлхийд эхний 3 байрны нэгийг Монгол эзэлж байна. Авлига эх орны минь тусгаар тогтнол, аюулгүй байдалд бодитоор занал учруулж байна шүү дээ.

Саяхан Сантмарал төвөөс бизнес эрхлэлтийн орчинд авлигын байдал ямар байгаад 330 компани, аж ахуйн нэгжийн удирдлагаас санал асуулга явуулахад татвар, мэргэжлийн хяналтын байгууллага авлигад хамгийн өртөмтгий гэж 28-35,4 хувь нь үзсэн байна. Татварын ерөнхий газар 2008-2010 онд авлигыг хязгаарлах ил тод байдлыг хангах чиглэлээр бодлого боловсруулж, хэрэгжүүлж тодорхой үр дүнд хүрч тэр үед татвар гаалийн байгууллага эрх барьж буй намдаа сонгуулийн мөнгө босгож, бизнес эрхлэгчдийг рекетлэдэг үйлдлийг таслан зогсоох хэд хэдэн арга хэмжээ авч үр дүн гарч, Азийн сан зэрэг олон улсын байгууллагаас эерэг үнэлгээ авч байсан. Энэ нь МАНАН-ийн засгийн газарт таалагдаагүй, татварын салбарт авлигатай тэмцэх ажиллагааг захиргаадан зогсоож байсан нь бодит түүх юм. Татварын салбарт эрх баригч намуудын сонгуулийн зардлыг босгоход татвар, гаалийнхан гол үүрэгтэй оролцож өөрсдөө ч авилгад идэгдэж, нэр хүндээ алдагдуулж байна. 2012 оны УИХ-ын сонгуульд 36 тэрбум төгрөг цацаж 2008 оноос 4 дахин их хөрөнгө босгон зарцуулж, татварын албан тушаалтнууд олноороо АТГ, цагдаагийн байгууллагын хаалга татаж энэ салбарын нэр хүнд унаж буй нь туйлын харамсалтай.

Монгол дахь авлигын байдлын хэдхэн жишээг та бүхэнд тоймлон хүргэхэд ийм байна. Цөөхөн хүн амтай, өргөн уудам нутагтай монгол оронд авлига ямар байгаа, түүний цар хүрээ, хэмжээ, хор уршигт одоо та бүхэн дүгнэлт хийж буй байхаа. Улс ардын аж ахуйн бүх салбар, төрийн байгууллага улам бүр авлигад идэгдэж,

гадаадын томоохон компаниуд монголыг авлигач түшмэдээр дамжуулан худалдан авснаар гадаадын зарим орон манай улсын эдийн засагт хяналтаа тогтоож чадахаар болжээ. Татвар гаалийн байгууллагууд нь шударга ил тод тууштай ажилладаггүй, төр засаг нь хуулиа мөрддөггүй гэж гадаадын хөрөнгө оруулагчид нь эргэлзэх тээнэгэлзэх итгэл алдрахад хүрч байна. Монгол Улсын татварын байгууллага, өндөр албан тушаалтнууд гадныханы захиалгаар Оюу толгойн 100 сая доллар, Дачин тамсагийн 35 тэрбум төгрөгийн татварын өрийг чөлөөлсөн, монголын төрийн түшмэдтэй хуйвалдаж, гарыг нь хүндрүүлбэл энэ орны хууль, шударга ёсыг уландаа гишгэж болдог юм байна, энэ улсад хууль үйлчилдэггүй юм байна гэж дэлхий нийтээр мессеж болж очиж байна. Шударга хөрөнгө оруулагч ийм улс оронд хөрөнгө оруулах уу. Монголоос хөрөнгө оруулагчид дайжиж байгаа нэг шалтгаан бол энэ оронд газар авсан авлига, хүнд суртал мөн.

Авлига нь улс орны хөгжлийг боомилж, иргэд төрдөө итгэх итгэл алдарч улс орон, түүний баялаг гадныханд хямдхан хөнгөхөн зууш болж тусгаар тогтнол, улс орны нэгдмэл байдал алдагдаж эрхтэн дархтан дураараа авирлах нөхцөлийг бүрүүлдэг. Украйны авлигад идэгдсэн Януковичийн засгийн газар, түүнийг эсэргүүцсэн бослого, тэмцэл дараа дараагийн үйл явдал энэ орны тусгаар тогтнолд аюул учруулж, газар нутгаа алдаж, иргэний дайн дэгдэхэд хүргэсэн бодит жишээ байна. Авлигад идэгдсэн, эдийн засгийн ашиг сонирхлоор холбогдсон нам фракцаар хуваагдсан олигарх бүлэглэлүүд жирийн ард иргэдээ намаар талцуулж хооронд нь зөрчилдүүлж, айл гэр, ах дүүс, баг, сум хороодын иргэдийг хагалан хооронд нь зөрчилдүүлж байгаа нь үндэсний аюулгүй байдал тусгаар тогтнолд сөрөг үр дагавар авчирч байна. Цаашид ноцтой аюул учруулж болох юм.

Энхийг эрхэмлэсэн, эвсэлд үл нэгдэх, төвийг сахисан Монгол Улсад гадаад улс орны шууд аюул занал байхгүй. Харин дотроосоо авлигад идэгдэж ард түмний татвараар бүрдсэн төсвийн мөнгийг завшиж байгаа авлигачид монгол орныг аюулд учруулж гадныханд эх орон, газар шороо баялгаа найр тавин өгөх аюултай. Төр засгийн, аймаг сумдын түшмэдүүд, албан тушаалтнууд эх орон, газар шороогоо худалдсан авлигын мөнгөө гадаадад хадгалж офшор зонд байршуулж өөрийгөө монгол биш урд хөрш орны иргэн гэж олон нийтэд ойлгуулахыг оролдож байгаа тохиолдол ч гарлаа. Монгол

орноо авлигаас салгаж эрчимтэй хөгжүүлж баялгаа иргэн бүрт тэгш шударга хүргэж чадвал бид үсрэнгүй хөгжиж иргэн бүр, айл өрх бүр баян тансаг амьдрах боломжтой. Авлига иргэн таны орлогыг булааж, инфляцыг дэвэргэж, ажилгүйдлийг бий болгож улс орныг уруудан доройтуулж нийгмийг бүхэлд нь бухимдуулж байна.

Бид авлигаас ангид, шударга, эрүүл тунгалаг төрийн тогтолцоог иргэд, төрийн бус байгууллагуудын дэмжлэг, идэвхтэй оролцоотой байгуулах, нам төвтэй тогтолцооноос татгалзах, Үндсэн хууль, Улс төрийн намын хууль, Сонгуулийн хуулиндаа шинэчлэл өөрчлөлтөө улс төрийн зөвшилцөлийн зарчмаар хийж, хэрэгжүүлэх боломжтой.

Одоо юу хийх вэ?

1. Иргэн хүн та идэвхтэй байж авлигыг алхам тутам илчилж, хууль шударга ёсыг хамгаалж чадвал авлига эрс буурна. Бас огт алга болгох боломжтой. Үүний тулд хүн бүр тэмцэх бас дуу хоолойгоо нэгтгэх хэрэгтэй.
2. Төрийн байгууллагын бүхий л үйл ажиллагааг ил тод, нээлттэй болгож иргэний нийгэм, ард иргэдийн шууд хяналтад оруулья. Ерөнхийлөгчийн санаачилсан “Шилэн дансны тухай” хууль үүнд хувь нэмрээ оруулна гэж найдаж байна. Төрийн албан хаагчид улс төрөөс ангид байж 3 жил тутамд аттестатчлал явуулж, мэдлэг мэргэжил, сахилга хариуцлага, авилгад өртөх байдалд дүн шинжилгээ хийж байя. Жил бүр малын тоо толгойг тоолдог ард түмэн төрийн албаа 3 жилд 1 удаа хянаж шалгаж байя.

Түүнчлэн бидний хэсэг гишүүд “Мөнгөн гүйлгээг бүртгэлжүүлж иргэдэд урамшуулал олгох тухай” хуулийн төсөл өргөн барихаар бэлдэж байна. Мөнгөн гүйлгээг бүртгэлжүүлж, иргэд аж ахуйн нэгж шударгаар татвараа төлж түүндээ мөнгөн урамшуулал авдаг хууль хэрэгжснээр төсвийн орлого 1,5-2 дахин нэмэгдэж далд эдийн засаг хумигдаж, авлига алга болж шударга ёс тогтоох боломж бүрдэнэ.

3. УИХ болон бүх шатны сонгуульд хууль тогтоох байгууллагад ажиллах мэргэжлийн өндөр чадвартай, нэр цэвэр, шударга, өндөр мэргэжлийн хуульч, эдийн засагчдаас нэр дэвшүүлж

олон нийтийн өмнө хамтдаа мэтгэлцэж, сурталчилгаа хийж, элдэв хуурамч рекламнаас татгалзъя.

Нам, төрийн бус байгууллага, иргэд аливаа сонгуульд мөнгөтэйг биш шударга иргэнийг нэр дэвшүүлэх бөгөөд сонгуульдаа бүх нэр дэвшигч адил хэмжээний зардал гаргаж тэнцвэртэй байдлыг ханган хэвлэл мэдээлэл сурталчилгааг яг адил нөхцөлд зохион байгуулж, хамтдаа сонгогчдын өмнө мэтгэлцэх нөхцөлийг бүрдүүлснээр Парламент цэвэршинэ. Улсын Их Хурлын гишүүд Засгийн газрын гишүүнээр давхар ажиллахгүй байх нь онцгой чухал юм.

4. Юуны өмнө олон улсын жишигт хүрсэн 99-108 гишүүнтэй парламентыг байгуулах шаардлагатай. Хууль тогтоох дээд байгууллага нь бусдын нөлөөнд орохгүй дан хууль тогтоох ажлаа эрхэлж авлига, тендер зэрэг ашиг сонирхлын зөрчилгүй ажиллана. Хоёр шатны парламенттай байх нь улс төрд хууль, шударга ёсыг хангах баталгаа болох үзэл бодлыг дэмжиж байна.

Улс төрийн намууд хатуу гишүүнчлэлээс татгалзаж хаа сайгүй шударга ёсыг тогтооно. Эцсийн дүнд Үндсэн хууль, Сонгуулийн хууль, Улс төрийн намын тухай хуулиудад өөрчлөлт оруулж бодит шинэчлэлээ хэрэгжүүлэхийг улс төрийн намууд, төрийн бус байгууллагууд, иргэддээ уриалж байна.

“АВЛИГА ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛД НӨЛӨӨЛӨХ НЬ”
СУДАЛГААНЫ ДҮН

I. СУДАЛГААНД ОРОЛЦОГЧДЫН НИЙГЭМ,
ХҮН АМ ЗҮЙН МЭДЭЭЛЭЛ

СУДАЛГААНД ОРОЛЦОГЧДЫН НАСНЫ БАЙДАЛ		
	ТОО	ХУВЬ
19 хүртэлх настай	65	13.0
20-29 настай	147	29.4
30-39 настай	140	28.0
40-49 настай	62	12.4
50-59 настай	60	12.0
60-аас дээш настай	26	5.2
Нийт	65	13.0




ХҮЙСИЙН БАЙДАЛ		
	ТОО	ХУВЬ
Эрэгтэй	236	47.2
Эмэгтэй	264	52.8
Нийт	500	100.0



“АВЛИГА ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛД НӨЛӨӨЛӨХ НЬ”


БОЛОВСРОЛЫН БАЙДАЛ		
	ТОО	ХУВЬ
Бага, боловсролгүй	1	0.2
Суурь боловсролтой	3	0.6
Бүрэн дунд	160	32.0
Тусгай дунд	27	5.4
Дээд	309	61.8
Нийт	500	100.0



СУДАЛГААНД ОРОЛЦОГЧДЫН АЖИЛ ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ		
	ТОО	ХУВЬ
Төсвийн байгууллага	123	24.6
Төр засгийн байгууллага	94	18.8
Нам улс төрийн байгууллага	25	5.0
Төрийн бус байгууллага	22	4.4
Олон улсын байгууллага	3	0.6
Улсын үйлдвэрийн газар	2	0.4
Хувийн компаний	53	10.6
Хувиараа бизнес эрхэлдэг	22	4.4
Суралцдаг: оюутан, сурагч	122	24.4
Тэтгэвэр, группт	17	3.4
Эрхэлсэн ажилгүй	17	3.4
Нийт	500	100.0

II. АВИЛГА, ХЭЭЛ ХАХУУЛИЙН ТАЛААРХ ҮЗЭЛ БОДОЛ

ИРГЭД АВИЛГА ХЭЭЛ ХАХУУЛИЙГ ЮУ ГЭЖ ҮЗДЭГ ВЭ?		
	ТОО	ХУВЬ
Хаа сайгүй байдаг зүйл, одоо хэнд ч сонин биш	115	23.0
Аливаа улс орны хөгжлийг гацааж, ард түмний амьдрал доройтож байна	272	54.4
Огт байж болохгүй, сөрөг үзэгдэл, хатуу тэмцэл хийх ёстой	104	20.8
Мэдэхгүй	9	1.8
Нийт	500	100.0




МОНГОЛ УЛСАД АВИЛГА ХЭР ТҮГЭЭМЭЛ БАЙНА ГЭЖ ТА ҮЗДЭГ ВЭ?		
	ТОО	ХУВЬ
Бүх салбарт байдаг, хэвийн үзэгдэл болсон	335	67.0
Түгээмэл тохиолддоггүй ч тодорхой салбарт бий	148	29.6
Түгээмэл үзэгдэл биш, санаа зовох зүйлгүй	6	1.2
Мэдэхгүй	11	2.2
Нийт	500	100.0

“АВЛИГА ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛД НӨЛӨӨЛӨХ НЬ”




III. АВИЛГА ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛД НӨЛӨӨЛӨХ ҮҮ?

ТАНЫ БОДЛООР АВИЛГА ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛД НӨЛӨӨЛӨХ ХЭМЖЭЭНД ХҮРСЭН ҮҮ?		
	ТОО	ХУВЬ
Үндэсний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх хэмжээнд хүрсэн	224	44.8
Үндэсний аюулгүй байдалд зарим талаар нөлөөлж байна	238	47.6
Үндэсний аюулгүй байдалд нөлөө үзүүлэхгүй, байдаг л зүйл	12	2.4
Мэдэхгүй	26	5.2
Нийт	500	100.0




IV. ТӨР ЗАСГИЙН ИНСТИТУТЫН АВИЛГАТАЙ ТЭМЦЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНЭЛГЭЭ


ОДООГИЙН ТӨР ЗАСГИЙН ИНСТИТУТЫН АВИЛГАТАЙ ТЭМЦЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ҮНЭЛНЭ ҮҮ-ЕРӨНХИЙЛӨГЧ			
		ТОО	ХУВЬ
Valid	Мэдэхгүй	109	21.8
	Муу	125	25.0
	Дунд	167	33.4
	Сайн	99	19.8
	Нийт	500	100.0




ОДООГИЙН ТӨР ЗАСГИЙН ИНСТИТУТЫН АВИЛГАТАЙ ТЭМЦЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ҮНЭЛНЭ ҮҮ-УЛСЫН ИХ ХУРАЛ			
		ТОО	ХУВЬ
	Мэдэхгүй	103	20.6
	Муу	214	42.8
	Дунд	157	31.4
	Сайн	26	5.2
	Нийт	500	100.0




ОДООГИЙН ТӨР ЗАСГИЙН ИНСТИТУТЫН АВИЛГАТАЙ ТЭМЦЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ҮНЭЛНЭ ҮҮ-ЗАСГИЙН ГАЗАР, ЯАМД			
		ТОО	ХУВЬ
	Мэдэхгүй	106	21.2
	Муу	270	54.0
	Дунд	114	22.8
	Сайн	10	2.0
	Нийт	500	100.0




ОДООГИЙН ТӨР ЗАСГИЙН ИНСТИТУТЫН АВИЛГАТАЙ ТЭМЦЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ҮНЭЛНЭ ҮҮ-ШҮҮХ ТОГТОЛЦОО			
		ТОО	ХУВЬ
Valid	Мэдэхгүй	102	20.4
	Муу	225	45.0
	Дунд	146	29.2
	Сайн	27	5.4
	Нийт	500	100.0



ОДООГИЙН ТӨР ЗАСГИЙН ИНСТИТУТЫН АВИЛГАТАЙ ТЭМЦЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ҮНЭЛНЭ ҮҮ-АВИЛГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР			
		ТОО	ХУВЬ
Valid	Мэдэхгүй	90	18.0
	Муу	135	27.0
	Дунд	191	38.2
	Сайн	84	16.8
	Нийт	500	100.0



ОДООГИЙН ТӨР ЗАСГИЙН ИНСТИТУТЫН АВИЛГАТАЙ ТЭМЦЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ҮНЭЛНЭ ҮҮ-ХУУЛЬ ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГА-ЦАГДАА, ПРОКУРОР			
		ТОО	ХУВЬ
Valid	Мэдэхгүй	114	22.8
	Муу	222	44.4
	Дунд	139	27.8
	Сайн	25	5.0
	Нийт	500	100.0



ТӨР ЗАСГИЙН УДИРДЛАГУУДАД АВИЛГАТАЙ ТЭМЦЭХ ХҮСЭЛ ЗОРИГ ХЭР ЗЭРЭГ БАЙДАГ ВЭ?		
	ТОО	ХУВЬ
Хүсэл зориг бий, тэмцэж чадаж байна.	47	9.4
хүсэл зориг байгаа боловч, хэрэгжүүлэх, тэмцэх зөв менежмент байхгүй	318	63.6
Тэмцэх хүсэл зориг байхгүй	112	22.4
Мэдэхгүй	23	4.6
Нийт	500	100.0



V. АВИЛГЫН ШАЛТГААН, НӨХЦӨЛ

АВИЛГЫГ ҮҮСГЭЖ БҮЙ ШАЛТГААН НӨХЦӨЛ		
	ТОО	ХУВЬ
Төр засгийн нэр хүнд унаж, авилгатай тэмцэх чадваргүй болсон	124	24.8
Хууль хяналтын байгууллагын үйл ажиллагаа хангалтгүй	145	29.0
Төрийн албанд шударга ёс алдагдсан	191	38.2
Сонгууль, төрийн томилгоонд мөнгөний нөлөөлөл их байгаагаас	40	8.0
Нийт	500	100.0



VI. АВИЛГА ГАРЧ БҮЙ САЛБАРУУД/эрэмбэлсэн/

АВИЛГА АЛЬ САЛБАРТ ИЛҮҮТЭЙ ГАРЧ БАЙНА ВЭ?			
	ХАРИУЛТ		Тохиолдлын хувь
	ТОО	ХУВЬ	
Засгийн газар, төр захиргааны байгууллагад	221	20.4	44.2
Шүүх, хууль хяналтын байгууллагад	266	24.5	53.2
Гааль татварын салбарт	257	23.7	51.4
Эрүүл мэндийн салбарт	130	12.0	26.0
Боловсролын салбарт	65	6.0	13.0
Худалдаа, үйлчилгээний салбарт	6	0.6	1.2
Барилгын салбарт	26	2.4	5.2
Уул уурхайн салбарт	57	5.3	11.4
Бизнесийн салбарт	18	1.7	3.6
Аймаг, орон нутаг	18	1.7	3.6
Бусад	1	0.1	0.2
Дээрх бүгд	19	1.8	3.8
Нийт	1084	100.0%	216.8%




VII. АВИЛГЫН ТАРХАЛТ-ТҮВШИН/эрэмбэлсэн/

МАНАЙ УЛСЫН АЛЬ ТҮВШНИЙХЭН АВИЛГАД ИЛҮҮ АВТСАН БЭ?			
	ХАРИУЛТ		Percent of Cases
	ТОО	ХУВЬ	
Улс төрийн намын удирдлагууд	115	114	23.5
УИХ-ын гишүүд	103	102	21.0
Засгийн газрын гишүүд	111	110	22.7
Хууль, хяналтын байгууллагынхан	187	185	38.2
Гааль татварынхан	199	197	40.6
Төрийн албан хаагчид	108	107	22.0
Багш, боловсролын салбарын ажилтнууд	48	48	9.8
Эмч, эрүүл мэндийн ажилтнууд	82	81	16.7
Бизнес эрхлэгчид	17	17	3.5
Хэвлэл мэдээллийнхэн	21	21	4.3
Мэдэхгүй	19	19	3.9
Нийт	1010	100.0	206.1




VIII. АВИЛГЫН ТУХАЙ БОДОМЖ


1.ЭРХ МЭДЭЛ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ҮЙЛДЭЖ БҮЙ ДЭЭД ТҮВШНИЙ АВИЛГА ИЛЭРДЭГГҮЙ			
		ТОО	ХУВЬ
	Санал нийлнэ	426	88.0
	Санал нийлэхгүй	58	12.0
	Нийт	484	100.0
	Хариулаагүй	16	
Нийт		500	



2.ДЭЭД ТҮВШИНД ҮЙЛДЭГДЭЖ БУЙ ЭРХ МЭДЭЛТНҮҮДИЙН АВИЛГА БУСАД АВИЛГААС ИЛҮҮ ХОР ХӨНӨӨЛТЭЙ		
	ТОО	ХУВЬ
Санал нийлнэ	440	92.1
Санал нийлэхгүй	38	7.9
Нийт	478	100.0
Хариулаагүй	22	
Нийт	500	




3.ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ АВАХЫН ТУЛД ЧИРЭГДЭЛТЭЙ ТУЛГАРЧ, ХУГАЦАА АЛДАХЫН ОРОНД ШААРДСАН МӨНГӨ ТӨЛБӨРИЙГ ӨГДӨГ		
	ТОО	ХУВЬ
Санал нийлнэ	368	77.5
Санал нийлэхгүй	107	22.5
Нийт	475	100.0
Хариулаагүй	25	
Нийт	500	




“АВЛИГА ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛД НӨЛӨӨЛӨХ НЬ”

4.АВИЛГА ИХ, БАГА БАЙХААС ҮЛ ХАМААРЧ ШИЙТГЭЛ ҮЗҮҮЛЭХ ХЭРЭГТЭЙ			
		ТОО	ХУВЬ
Valid	Санал нийлнэ	388	81.9
	Санал нийлэхгүй	86	18.1
	Нийт	474	100.0
Missing	Хариулаагүй	26	
Нийт		500	



5.АЖИЛ ҮЙЛСЭЭ БҮТЭЭХИЙН ТУЛД ГАР ЦАЙЛГАХ, БЭЛЭГ ӨГӨХ НЬ БАЙХ ЗҮЙЛ			
		ТОО	ХУВЬ
	Санал нийлнэ	205	43.7
	Санал нийлэхгүй	264	56.3
	Нийт	469	100.0
	Хариулаагүй	31	
Нийт		500	



IX. ХАРЬЦУУЛСАН ХҮСНЭГТ, ГРАФИК

ОДООГИЙН ТӨР ЗАСГИЙН ИНСТИТУЦИЙН АВИЛГАТАЙ ТЭМЦЭЖ БАЙГААГ ҮНЭЛСЭН ҮНЭЛГЭЭ

		Сайн	Дунд	Муу	Мэдэхгүй	Нийт
Ерөнхийлөгч, түүний институт	Тоо	99	167	125	109	500
	Хувь	19.8%	33.4%	25%	21.8%	100%
Улсын Их Хурал	Тоо	26	157	214	103	500
	Хувь	5.2%	31.4%	42.8%	20.6%	100%
Засгийн газар, яамд	Тоо	10	114	270	106	500
	Хувь	2%	22.8%	54%	21.2%	100%
Шүүх тогтолцоо	Тоо	27	146	225	102	500
	Хувь	5.4%	29.2%	45%	20.4%	100%
Авлигатай тэмцэх газар	Тоо	84	191	135	90	500
	Хувь	16.8%	38.2%	27%	18%	100%
Хуул хяналтын байгууллага: Цагдаа	Тоо	25	139	222	114	500
	Хувь	5%	27.8%	44.4%	22.8%	100%

АВИЛГА ХЭЭЛ ХАХУУЛИЙГ ХҮЙСИЙН БАЙДЛААР ҮНЭЛСЭН БАЙДАЛ

		Авилга хээл хахуулийг хэрхэн үзэж байна вэ?				Нийт
		Хаа сайгүй байдаг	Авилга улс орны хөгжлийг гацаадаг	Огт байж болохгүй сөрөг үзэгдэл	Мэдэхгүй	
Хүйс	Эрэгтэй	60	130	43	3	236
		25.4%	55.1%	18.2%	1.3%	
	Эмэгтэй	55	142	61	6	264
		20.8%	53.8%	23.1%	2.3%	
Нийт		115	272	104	9	500
		23.0%	54.4%	20.8%	1.8%	100.0%

“АВЛИГА ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛД НӨЛӨӨЛӨХ НЬ”

АВИЛГЫН ТАРХАЛТЫГ ХҮЙСЭЭР ҮНЭЛСЭН БАЙДАЛ						
		Авилга хэр түгээмэл байна вэ?				Нийт
		Бүх салбарт хэвийн үзэгдэл	Түгээмэл тохиолддоггүй, зарим салбарт бий	Түгээмэл үзэгдэл биш	Мэдэхгүй	
Хүйс	Эрэгтэй	159	72	2	3	236
		67.4%	30.5%	0.8%	1.3%	100.0%
	Эмэгтэй	176	76	4	8	264
		66.7%	28.8%	1.5%	3.0%	100.0%
Нийт		335	148	6	11	500
		67.0%	29.6%	1.2%	2.2%	100.0%

АВИЛГА ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛД НӨЛӨӨЛӨХ ЭСЭХИЙГ ХҮЙСЭЭР ҮНЭЛСЭН БАЙДАЛ						
		ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ				Нийт
		ҮАБ-д сөргөөр нөлөөлж байна.	ҮАБ-д зарим талаар нөлөөлж байна	ҮАБ-д нөлөө үзүүлэхгүй, байдаг л зүйл	Мэдэхгүй	
Хүйс	Эрэгтэй	109	114	6	7	236
		46.2%	48.3%	2.5%	3.0%	100.0%
	Эмэгтэй	115	124	6	19	264
		43.6%	47.0%	2.3%	7.2%	100.0%
Нийт		224	238	12	26	500
		44.8%	47.6%	2.4%	5.2%	100.0%

"CORRUPTION AS A THREAT TO NATIONAL SECURITY"

АВИЛГА ХЭЭЛ ХАХУУЛИЙГ БОЛОВСРОЛЫН БАЙДЛААР ҮНЭЛСЭН БАЙДАЛ						
		Авилга хээл хахуулийг хэрхэн үзэж байна вэ?				Нийт
		Хаа сайгүй байдаг	Авилга улс орны хөгжлийг гацаадаг	Огт байж болохгүй сөрөг үзэгдэл	Мэдэхгүй	
Боловсрол	Бага	1	0	0	0	1
		100.0%	0.0%	0.0%	0.0%	100.0%
	Суурь	0	3	0	0	3
		0.0%	100.0%	0.0%	0.0%	100.0%
	Бүрэн дунд	51	80	26	3	160
		31.9%	50.0%	16.3%	1.9%	100.0%
	Тусгай дунд	6	17	4	0	27
		22.2%	63.0%	14.8%	0.0%	100.0%
Дээд	57	172	74	6	309	
	18.4%	55.7%	23.9%	1.9%	100.0%	
Нийт		115	272	104	9	500
		23.0%	54.4%	20.8%	1.8%	100.0%

АВИЛГЫН ТАРХАЛТЫГ БОЛОВСРОЛЫН БАЙДЛААР ҮНЭЛСЭН БАЙДАЛ						
		Авилга хэр түгээмэл байна вэ?				Нийт
		Бүх салбарт хэвийн үзэгдэл	Түгээмэл тохиолддоггүй, зарим салбарт бий	Түгээмэл үзэгдэл биш	Мэдэхгүй	
Боловсрол	Бага	1	0	0	0	1
		100.0%	0.0%	0.0%	0.0%	100.0%
	Суурь	2	0	0	1	3
		66.7%	0.0%	0.0%	33.3%	100.0%
	Бүрэн дунд	100	47	5	8	160
		62.5%	29.4%	3.1%	5.0%	100.0%
	Тусгай дунд	20	6	0	1	27
		74.1%	22.2%	0.0%	3.7%	100.0%
Дээд	212	95	1	1	309	
	68.6%	30.7%	0.3%	0.3%	100.0%	
Нийт		335	148	6	11	500
		67.0%	29.6%	1.2%	2.2%	100.0%

“АВИЛГА ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛД НӨЛӨӨЛӨХ НЬ”

АВИЛГА ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛД НӨЛӨӨЛӨХ ЭСЭХИЙГ БОЛОВСРОЛЫН БАЙДЛААР ҮНЭЛСЭН БАЙДАЛ						
		ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ				Нийт
		ҮАБ-д сөргөөр нөлөөлж байна.	ҮАБ-д зарим талаар нөлөөлж байна	ҮАБ-д нөлөө үзүүлэхгүй, байдаг л зүйл	Мэдэхгүй	
Боловсрол	Бага	1	0	0	0	1
		100.0%	0.0%	0.0%	0.0%	100.0%
	Суурь	2	1	0	0	3
		66.7%	33.3%	0.0%	0.0%	100.0%
	Бүрэн дунд	63	76	7	14	160
		39.4%	47.5%	4.4%	8.8%	100.0%
	Тусгай дунд	17	8	0	2	27
		63.0%	29.6%	0.0%	7.4%	100.0%
Дээд	141	153	5	10	309	
	45.6%	49.5%	1.6%	3.2%	100.0%	
Нийт		224	238	12	26	500
		44.8%	47.6%	2.4%	5.2%	100.0%

АВИЛГА ХЭЭЛ ХАХУУЛИЙГ НАСНЫ БАЙДЛААР ҮНЭЛСЭН БАЙДАЛ							
		Авилга хээл хахуулийг хэрхэн үзэж байна вэ?				Нийт	
		Хаа сайгүй байдаг	Авилга улс орны хөгжлийг гацаадаг	Огт байж болохгүй сөрөг үзэгдэл	Мэдэхгүй		
Нас	19 хүртэлх	20	36	8	1	65	
		30.8%	55.4%	12.3%	1.5%	100.0%	
	20-29	37	78	28	4	147	
		25.2%	53.1%	19.0%	2.7%	100.0%	
	30-39	35	66	37	2	140	
		25.0%	47.1%	26.4%	1.4%	100.0%	
	40-49	13	34	15	0	62	
		21.0%	54.8%	24.2%	0.0%	100.0%	
	50-59	8	39	11	2	60	
		13.3%	65.0%	18.3%	3.3%	100.0%	
	60-С дээш	2	19	5	0	26	
		7.7%	73.1%	19.2%	0.0%	100.0%	
	Нийт		115	272	104	9	500
			23.0%	54.4%	20.8%	1.8%	100.0%

АВИЛГЫН ТАРХАЛТЫГ НАСНЫ БАЙДЛААР ҮНЭЛСЭН БАЙДАЛ							
НАС		Авилга хэр түгээмэл байна вэ?				Нийт	
		Бүх салбарт хэвийн үзэгдэл	Түгээмэл тохиолддоггүй, зарим салбарт бий	Түгээмэл үзэгдэл биш	Мэдэхгүй		
19 ХҮРТЭЛХ 20-29 30-39 40-49 50-59 60-С ДЭЭШ	38	25	0	2	65		
	58.5%	38.5%	0.0%	3.1%	100.0%		
	94	42	6	5	147		
	63.9%	28.6%	4.1%	3.4%	100.0%		
	98	41	0	1	140		
	70.0%	29.3%	0.0%	0.7%	100.0%		
	47	14	0	1	62		
	75.8%	22.6%	0.0%	1.6%	100.0%		
	39	19	0	2	60		
	65.0%	31.7%	0.0%	3.3%	100.0%		
	19	7	0	0	26		
	73.1%	26.9%	0.0%	0.0%	100.0%		
	НИЙТ		335	148	6	11	500
			67.0%	29.6%	1.2%	2.2%	100.0%

АВИЛГА ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛД НӨЛӨӨЛӨХ ЭСЭХИЙГ НАСНЫ БАЙДЛААР ҮНЭЛСЭН БАЙДАЛ							
Нас		ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ				Нийт	
		ҮАБ-д сөргөөр нөлөөлж байна.	ҮАБ-д зарим талаар нөлөөлж байна	ҮАБ-д нөлөө үзүүлэхгүй, байдаг л зүйл	Мэдэхгүй		
19 хүртэлх 20-29 30-39 40-49 50-59 60-С дээш	15	45	1	4	65		
	23.1%	69.2%	1.5%	6.2%	100.0%		
	61	68	6	12	147		
	41.5%	46.3%	4.1%	8.2%	100.0%		
	63	73	1	3	140		
	45.0%	52.1%	0.7%	2.1%	100.0%		
	32	27	0	3	62		
	51.6%	43.5%	0.0%	4.8%	100.0%		
	30	23	4	3	60		
	50.0%	38.3%	6.7%	5.0%	100.0%		
	23	2	0	1	26		
	88.5%	7.7%	0.0%	3.8%	100.0%		
	НИЙТ		224	238	12	26	500
			44.8%	47.6%	2.4%	5.2%	100.0%

АСУУЛТ 9. БОДОМЖУУД

	Санал нийлнэ		Санал нийлэхгүй	
	тоо	хувь	тоо	хувь
Эрх мэдэл бүхий албан тушаалтны үйлдэж буй дээд түвшний авилга илэрдэггүй.	426	88%	58	12%
Дээд түвшинд үйлдэгдэж буй эрх мэдэлтнүүдийн авилга бусад авилгаас илүү хор хохиролтой	440	92,1%	38	7,9%
Төрийн үйлчилгээ авахын тулд чирэгдэлтэй тулгарч, хугацаа алдахын оронд шаардсан мөнгө төлбөрийг өгдөг	368	77,5%	107	22,5%
Авилга их, бага байхаас үл хамаарч шийтгэл үзүүлэх хэрэгтэй	388	81,9%	86	18,1%
Ажил үйлсээ бүтээхийн тулд гар цайлгах, бэлэг өгөх нь байх л зүйл	205	43,7%	469	56,3%

ӨНДӨР ТҮВШНИЙ АВЛИГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХЭД ИРГЭНИЙ НИЙГМИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮҮРЭГ

*В.Удвал-Эмэгтэй удирдагч сангийн
Удирдах зөвлөлийн даргын илтгэл*

Авлигаас ангид, шударга нийгмийг бүтээхийн төлөө иргэний нийгмийн байгууллагууд нэгдэж, “Шударга нийгмийн төлөө хамтдаа” уриан дор нийгмийн сайн сайхны төлөө чамгүй их ажлыг өөрсдийн санаачилгаар хийж байна. Өнгөрсөн хугацаанд Монгол Улсад хэрэгжсэн Засаглал ил тод байдлыг дэмжих төслийн хүрээнд Азийн сангийн дэмжлэгтэйгээр иргэний нийгмийн байгууллагууд авлигын асуудлаар шинжлэх ухааны байгууллагуудын хэмжээнд бодлогын судалгаанууд хийж, авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг чанарын шинэ түвшинд зохион байгуулж, нийгэмд эерэг хандлага бий болгоход зохих хувь нэмрээ оруулсаар байна.

1. Өндөр түвшний авлигын эсрэг үйл ажиллагаанд Монголын иргэний нийгмийн байгууллагуудын оролцоо

Авилгаас ангид нийгмийг бий болгоход Монголын иргэний нийгмийн байгууллагууд чухал үүрэг гүйцэтгэж, “Засаглал ил тод байдлыг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд олон ТББ-д бие даан, мөн “Ил тод байдлыг дэмжих түншлэл” хэлбэрээр сүлжээ үүсгэн авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг Авлигатай тэмцэх газартай хамтран хэрэгжүүлж, үр дүнд хүрч байна. Үүний нэг тод жишээ бол Эмэгтэй удирдагч сан ТББ, Авлигатай тэмцэх газартай хамтран “Өндөр түвшний авлигын ойлголт, мэдлэг” төслийг хэрэгжүүлсэн үйл ажиллагаа юм. Энэхүү төслийн зорилго нь өндөр түвшний авлигын асуудлыг институцийн болон ойлголтын талаас судлан олон нийтийн анхаарлын төвд оруулж, эрх зүйн зохицуулалтад хамааруулах хэрэгцээг хангах асуудал байлаа. Төслийн хүрээнд хуульчид, судлаачид, сэтгүүлчид, төрийн албан хаагчид\ХЗЯ, АТГ, олон улсын байгууллагын ажилтнууд, иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл гэх мэт 8 зорилтод бүлгээр “Өндөр түвшний авлигын ойлголт мэдлэг” “Өндөр түвшний авлигаас урьдчилан сэргийлэх нь” сэдвийг хэлэлцүүлж, өндөр түвшний авлигын талаарх буруу төсөөлөл болон

хоорондоо зөрөөтэй ойлголтыг нэгтгэх, цаашдаа тухайн асуудлыг эрх зүйн зохицуулалтад хамруулах боломжийн талаар олон чухал санал санаачлагуудыг хэлэлцэн нйгдсэн шийдэлд хүрэх боломжийг бий болгосон. Үндэсний хэмжээнд нэгдсэн хэлэлцүүлэг хийн, бодлогын хүрээнд зөвлөмж гаргажээ.

“Бодлогын түвшний авлига: ойлголт, олон улсын хандлага” нэртэй гарын авлага, ном гаргасан төдийгүй өдөр дутмын 5 сонинд Өндөр түвшний авлигын асуудлаар цуврал материал нийтлүүлсэн байна. Монголын үндэсний телевизээр өндөр түвшний авлигын ойлголт мэдлэгийг тогтоох, асуудал дэвшүүлсэн нэвтрүүлэг хийжээ. Өндөр түвшний авлигын ойлголт мэдлэгийг түгээхэд сэтгүүлчдийн үүрэг роль чухал болох үндэслэлээр 20 сэтгүүлчийн сургалтыг зохион байгуулсан юм. Энэ бүх ажлын үр дүнд өнгөрсөн хугацаанд олон нийтийн энэ талаарх ойлголт мэдлэг, хандлага өөрчлөгдөж байгаа нь мэдрэгдэж байна. Ийнхүү иргэний нийгмийн байгууллагууд өндөр түвшний авлигын ойлголт мэдлэгээс тухайн асуудлыг парламентаар хуульчлан зохицуулах хүртлэх процессыг санаачлан амжилттай зохион байгуулж байна.

1992 оны шинэ Үндсэн хуулиар хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгмийг эх орондоо цогцлоон хөгжүүлэх эрхэм зорилгыг хуульчлан тунхагласан манай оронд иргэний нийгмийн байгууллагуудын нийгмийн сайн сайхны төлөө санаачлан хийсэн нөр их ажлыг үр дүнд хүргэх механизм дутагдалтай байна.

2. Авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны эрх зүйн орчинд байгаа хийдэл\цоорхой\-ийг шийдвэрлэх шаардлага

1992 оны шинэ Үндсэн хуулийн иргэний нийгмийн үзэл санаа гарч, 1996 онд Авлигын эсрэг анхны хууль батлагдсан. 2002 онд Авлигатай тэмцэх Үндэсний хөтөлбөр батлагдаж 2010 он хүртэл хэрэгжиж дууссан бөгөөд дараагийн хөтөлбөр батлагдаагүй өнөөдрийг хүрчээ. 2005 онд Мянганы хөгжлийн үндсэн 8 зорилт дээр “Хүний эрхийг баталгаажуулах, ардчилсан засаглалыг хөгжүүлэх, авлигатай тэмцэх” 9 дэх зорилтыг нэмж баталсан ба 2005 онд Монгол улс Авлигын эсрэг НҮБ-ын конвенцид нэгдсэн билээ. 2006 онд Авлигын эсрэг хуулийг шинэчлэн баталж, 2007 онд Авлигатай тэмцэх бие даасан байгууллага байгуулсан байна.

Эрх зүйн орчины хувьд Эрүүгийн хууль \2002 он\, Авлигын эсрэг хууль \2006 он\, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль \2010\, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль \2011 он\, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль \2012 он\, Шилэн дансны тухай хууль \2014 он\ батлагдан хэрэгжиж байна.

Гэвч “өндөр түвшний авлига”-ын асуудал эрх зүйн зохицуулалтгүй \эрх зүйн хийдэлтэй\ байна. Хэдийгээр Олон улсын баримт бичиг бусад орны эрх зүйн практикт **Grand corruption, Political corruption, High level corruption** гэсэн нэр нэр томъёо тааралдах боловч манайд ойлголт нь тогтоогүй байна. Ийм хийдэл буюу эрх зүйн зохицуулалтгүй орчин байгаагаас:

- Шийдвэр гаргагч цөөн хүнд зориулагдсан бодлого тодорхойлогдох
- Хуулийг хувийн ашиг сонирхолдоо нийцүүлж сонголттой байдлаар хэрэгжүүлэх зэрэг гажуудал үүсч байна. Мөн төрийн өндөр албан тушаалтны халдашгүй байдлын талаарх одоогийн хуулийн зохицуулалтыг өөрчлөх шаардлагатай байна.

3. Цаашид бодлогын шийдэлд хүрэх алхамууд

- Өндөр түвшний авлигатай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх асуудлыг Авлигатай тэмцэх талаарх төрийн бодлогын баримт бичигт тусган батлаж, төрийн өндөр албан тушаалтнуудын үйлдэж буй үндэсний аюулгүй байдалд нэн хохиролтой өндөр түвшний, бодлогын, их хэмжээний авлигын тухай ойлголтыг нэг мөр цэгцлэн хуульчлах.
- Өндөр түвшний авлигыг өдөөгч эрх зүйн орчинд нухацтай дүн шинжилгээ хийж, улс төрийн намуудын санхүүжилтыг ил тод болгон, сонгуулийн зардлыг боломжит хамгийн бага түвшинд тогтоож, төсвөөс санхүүжүүлэх, төрийн өндөр албан тушаалтны халдашгүй байдлын талаарх хуулийн зохицуулалтыг өөрчлөн Авлигын эсрэг НҮБ-ын конвенцид нийцүүлэх зэргээр холбогдох эрх зүйн өөрчлөлтийг яаралтай хийх.

- Өндөр түвшний авлигатай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр төрийн байгууллагууд төрийн бус байгууллага, хувийн хэвшил, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай үр ашигтай хамтран ажиллах бүтцийг бий болгож, өндөр түвшний авлигын хор уршгийн талаарх олон нийтийн ойлголт хандлагыг төлөвшүүлэх.
- Өндөр түвшний авлигаас урьдчилан сэргийлэх цогц бодлогын хүрээнд УИХ-аар хэлэлцэгдэх хуулийн төслүүдэд ил тод байдал, авлигын эрсдлийн үнэлгээг мэргэжлийн шинжээчид хийдэг эрх зүйн зохицуулалтыг бий болгох
- Өндөр түвшний авлигатай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэхийн тулд Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Тэргүүн болон гишүүд, шүүх эрх мэдлийн байгууллагуудын хамтын ажиллагааг нэгтгэн, бодлого үйл ажиллагаагаа иж бүрэн үр дүнтэй явуулах.
- Өндөр түвшний авлигын гэмт хэргийн хариуцлагын асуудлыг шинээр боловсруулагдаж буй Гэмт хэргийн тухай хуулийн төсөлд суулгах

Дүгнэлт: Өндөр түвшний авлигатай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажилд иргэний нийгмийн байгууллагуудын оролцоог идэвхижүүлж, хийгдэж буй ажлуудын үр өгөөжийг нэмэгдүүлэх арга замыг тодорхойлон, өндөр түвшний авлигын эрсдлээс иргэдийг хамгаалах механизмыг яаралтай бий болгох хэрэгцээ шаардлага бий болсон байна.

**МОНГОЛ УЛСЫН АВЛИГЫН ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭЖ
БУЙ ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫГ ХБНГУ-ЫН
ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТТАЙ ХАРЬЦУУЛАХ НЬ**

*Б.Өнөрмаа-Улсын Ерөнхий Прокурорын газрын
хяналтын прокурор, Хууль зүйн ухааны доктор*

Монгол Улсын нийгэм, улс төрийн бүхий л салбарыг аалзны тор мэт сүлжин хэрж эдийн засгийн хөгжилийг чөдөрлөн иргэдийн төрдөө, төрийн алба хаагчдад итгэх итгэлийг алдруулж олон улсын түвшинд Монгол Улсын нэр хүндийг унагаж буй авлигатай тэмцэх тэмцлийг эрчимжүүлэх шаардлага бий болоод удаж байна. Гэвч Монгол Улсад өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж буй эрх зүйн хэм хэмжээ тэр тусмаа эрүүгийн эрх зүйн хэм хэмжээ дээрх гэмт хэрэгтэй тэмцэхэд тун хангалтгүй хэлбэр төдий байгаа нь амьдралд хэдийн батлагджээ. Иймд дэлхийд эрх зүйн хөгжлөөрөө тэргүүлж бас хүлээн зөвшөөрөгдсөн, олон улсад үлгэр дууриалал болж чадсан улсуудаас Герман улсын хээл хахуулийн гэмт хэрэгтэй тэмцэж байгаа байдлыг өөрийн улсын эрүүгийн эрх зүйн хэм хэмжээтэй харьцуулснаа хүргэж байна. Харьцуулалт хийхийн өмнө та бүхнийг Транспэранси Интернешнил олон улсын байгууллагаас жил бүр авлигын индексийг судлан зарладаг судалгааны дүнд анхаарлаа хандуулахыг хүсч байна. Уг судалгааны үр дүнгээс харахад 1999 онд Монгол улс 99 орноос 49 дүгээр байранд буюу дундаж үзүүлэлттэй байсан бол 2005 онд 158 орноос 85 дугаар байранд 2012 онд 174 орноос 94 дүгээр байранд орж үзүүлэлт нэлээд олон нэгжээр доошилж 2013 онд 175 орноос 83 дугаар байранд орсон үзүүлэлттэй байна. Авлигын нөхцөл байдлын индексийн дагуу 10 оноо авах ёстойгоос /авлигагүй бол/ дөнгөж 3.0 оноо авч байгааг тооцвол авлигын нөхцөл байдал даамжран хүндрэх чиглэлтэй байна.

ХБНГУ авлигын индексээр 1999 онд 99 орноос 14 дүгээр байранд орж байсан бол 2012 онд 174 орноос 13 дугаар байранд, 2013 онд 175 орноос 12 дугаар байранд орсон ба авах ёстой 10 онооноос 8 оноо авч олон улсын хэмжээнд авлигын гэмт хэрэгтэй тэмцэж буй эрх зүйн орчин, иргэдийн төрдөө болон нийтийн албан үүргийг хэрэгжүүлэгч субъектүүдэд итгэх итгэлээрээ тэргүүлэх байр сууриа тогтвортой хадгалсаар байна.

Герман улсын авлигатай тэмцэж буй байдлыг судлахад Эрүүгийн хуулийн тусгай ангийн 331-335 дугаар зүйлүүдэд албан тушаалтан болон албан хаагч нь албаны чиг үүрэг, бүрэн эрх, албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж албаны чиг үүргээ зориуд хэрэгжүүлээгүй эсхүл албан үүргээ хэрэгжүүлсэн мөн хэрэгжүүлээгүйн хариуд эсхүл хэрэгжүүлэхгүй байхын тулд, эсхүл гүйцэтгэх ёсгүй үйлдлийг хийсэн, эсхүл хийхийн тулд шууд болон шууд бусаар бусдад давуу байдал олгосон, эсхүл өөрөө болон бусдаар дамжуулан хээл хахууль авсан, эдийн болон эдийн бус давуу байдлыг олж авсан бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр хуульчилсан байдаг. 1997 оноос өмнө буюу эрх зүйн шинэчлэл хийхээс өмнө Герман улс Эрүүгийн хуулинд хээл хахууль болон эдийн болон эдийн бус давуу тал олох гэмт хэргийн бүрэлдхүүний объектив талыг тухайн албан тушаалтан болон албан хаагчийн гүйцэтгэж буй ажил үүргийн хүрээнд байхаар явцуу тодорхойлсон бөгөөд Холбооны эрүүгийн албаны судалгаанаас харахад авлигын төрлийн шинжтэй хэрэгт явуулсан мөрдөн байцаалт буюу шалгагдсан хэрэг нь 1994 онд Холбооны улсын хэмжээнд 258 байсан бол Эрүүгийн хуулиндаа өөрчлөлт оруулснаас хойш шалгагдсан хэргийн тоо тухайлбал 1999 онд 1034, 2003 онд 7,232 болж өссөн байдаг.

Тодруулбал албан тушаалтан, албан хаагч нь өөрөө шийдвэр гаргасан, шийдвэр гаргах эрхтэй эсэх, уг шийдвэр, үйлдэл хууль ёсны эсэхээс үл хамааран эрхэлж буй ажил, гүйцэтгэх үүргээ ашиглан бусдад хууль бусаар нөлөөлсөн, хээл хахууль, шан харамж, давуу тал олсон, бусдад давуу тал олгосон бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан нь ял завших, эрүүгийн хариуцлагаас мултрах явдлыг бууруулахад үр дүнд хүрсэн гэж дүгнэж болно.

Тэгвэл манай улсын Эрүүгийн хуульд байгаа хээл хахууль, шан харамжтай холбоотой заалтууд өнөөгийн нийгмийн шаардлагад нийцэхгүй төдийгүй 2003-10-31-нд Нэгдсэн Үндэстний байгууллагын Ерөнхий Ассамблейгаас баталсан Авлигын эсрэг конвенцтэй харьцуулахад хэт явцуу тэр тусмаа албан үүргээ урвуулан давуу тал олсон, олгосон тохиолдолд энэ нь гэмт хэрэгт тооцогдохгүй байгааг өөрчлөх шаардлага гарч ирж байна. Манай улс дээрх Конвенцид 2005 онд нэгдэн орсон бөгөөд уг баримт бичгийг үндэсний хууль тогтоомжийн нэгэн адил дагаж мөрдөх үүрэг хүлээсэн юм.

Уг Конвенцид “оролцогч улсын хууль тогтоох, гүйцэтгэх, захиргааны буюу шүүхийн байгууллагад байнга сонгогдсон, цалинтай буюу цалингүй ажилладаг хүмүүс, төрийн байгууллага буюу улсын үйлдвэрийн газарт төрийн чиг үүрэг гүйцэтгэдэг эсхүл төрийн үйлчилгээ үзүүлдэг хүмүүсийг албан тушаалаас нь үл хамааран төрийн албан хаагч” гэж үзэн авлигын субектэд хамааруулан, тэдгээрийг тус бүрд нь тайлбарласан байдаг.

Гэтэл манай улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 268 дугаар зүйлд субъектийг “албан тушаалтан” гэж оруулсан нь хэт явцуу болсон. Шийдвэр гаргах түвшинд ажилладаггүй ч эрхэлж буй ажлын давуу тал, нөлөөлөл үзүүлж болох бүхий л байдлыг ашиглаж бусдад ажил бүтээж өгөхөөр амладаг, амласнаа биелүүлснийхээ төлөө шан харамж, давуу тал олж авах үйлдлүүд мөн субъектүүд энд орхигдсон. Жишээ нь эмч, сургууль, цэцэрлэгийн багш, сувилагч г.м \Хүүхэд сургуульд, цэцэрлэгт оруулахад аливаа хэлбэрээр эцэг эхчүүдэд боломжгүй зүйлийг нь “бүтээн буян үйлдэж”, өвчтөнийг шилжүүлэх, эмнэлэгт хэвтүүлэхэд харъяалал, дараалал харгалзахгүй үйлчлэх, хэвтүүлж эмчлэх үүнийхээ төлөө бэлэг, мөнгө г.м шан харамж авах, “гарыг нь хүндрүүлсэн” “үйлчлүүлэгчдэд” давуу тал олгож тусгай үйлчилгээ үзүүлэх..\) гэх мэт. Төрөөс цалин авч, онцгой эрх эдлэн үүрэг хүлээж тангараг өргөсөн нийтийн албан хаагчдын нийтийн албыг ашиг хонжоо олох хэрэгсэл болгосны төлөө захиргааны хариуцлага хүлээх төдий өнгөрч байгаа нь зүйд нийцэхгүй. Дээрх салбарт Монгол улсын иргэний төрийн үйлчилгээг тэгш, шударга хүртэх эрх хамгийн их зөрчигддөг гэдэгтэй бүгд санал нийлэх болов уу.

НҮБ-ын конвенцийн 15 дугаар зүйлд нийтийн албан тушаалтан эрхэлж буй ажлаа ашиглан аливаа давуу тал олж авсан үйлдэл эс үйлдэл болгоныг гэмт хэрэгт тооцохоор заасан боловч Монгол Улсын эрүүгийн хууль тогтоомжид энэ заалт өнөөдрийг хүртэл тусгалаа олоогүй байна. Тодруулвал хээл хахуулийн гэмт хэргийн объектив талын бүрэлдхүүнийг “..... Албан тушаалтан хээл хахууль өгөгчийн ашиг сонирхлын үүднээс **албан үүргийн хувьд гүйцэтгэх үүргээ хэрэгжүүлэхгүй байх, эсхүл гүйцэтгэх ёсгүй үйлдлийг хийхээр.....**” гэсэн ерөнхий үйлдлээр хязгаарласан нь өндөр түвшний авлигыг илрүүлэх боломжгүй болгож хууль ёсны дагуу шийдвэр гаргаж, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлснийхээ

төлөө хахууль, шан харамж, эдийн болон эдийн бус давуу тал олж буй этгээдүүдэд ял завшуулах боломжийг бүрдүүлж байна. Иймд хуулийн дээрх заалтыг өөрчилж албан тушаалтан, нийтийн албан хаагч эрхэлж буй ажил, байр сууриа аливаа хэлбэрээр ашиглан эдийн болон эдийн бус давуу тал олж болох үйлдэл бүрт эрүүгийн хариуцлага хүлээлгэж байхаар өөрчлөх шаардлагатай.

Дээрхи заалтаар өндөр түвшний буюу бодлогын түвшинд үйлдэгдэж буй авлигын гэмт хэргийг шалгах боломжгүй болж байна. Ялангуяа албан тушаалтан эрхэлж буй албан тушаалын нөлөөгөө ашиглаж олсон эдийн болон эдийн бус давуу талууд гэмт хэрэгт тооцогдохгүй байгаа нь шударга бус бөгөөд авлигын эсрэг манай улс бүрэн тэмцэж чадахгүй байгааг харуулж буй бодит жишээ юм. Өндөр түвшний авлигыг судлаачдын тодорхойлсоноор нэгтгэн дүгнэхэд “Өндөр түвшний авлига гэдэг нь хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргах түвшинд бусдад давуу тал олгох эсхүл хууль бус нөлөөллийг хамтын шийдвэр нэрийн доор баталгаажуулах үүний үр дүнд удаан хугацааны туршид эсхүл зохион байгуулалттайгаар хууль бус ашиг, эдийн болон эдийн бус давуу тал олох бусдад олгох бүхий л хэлбэр” ба авлигын энэ төрөл нь төрийн болон олон улсын байгууллагын өндөр албан тушаалтан, томоохон аж ахуйн нэгж оролцсон, улс төрийн нөлөө, хууль бус лоббигоор дамжиж эсхүл тодорхой бизнесийг далд аргаар дэмжихэд чиглэгдсэн, авлигын төрөл нь ихэвчлэн үнэт цаас, хөрөнгө оруулалт, хөнгөлөлт, давуу тал байдаг бөгөөд хууль бусаар олсон зүйлийг эдийн засгийн эргэлтэнд оруулах буюу мөнгө угаах гэмт хэрэг давхар үйлдэгддэг. Хууль бус харьцаа нь удаан хугацааны эсхүл үргэлжилсэн шинжтэй байдаг ажээ.

Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-д *“албан тушаалынхаа бүрэн эрхийг хэрэгжүүлсний төлөө бусад байгууллага, аж ахуйн нэгж, иргэнээс мөнгөн шагнал, шан харамж зээл авах, төлбөргүй буюу хөнгөлөлттэйгээр үйлчлүүлэх зэрэг хууль бус бусад хангамж эдлэх”*-ийг хориглосон байдаг боловч манай улсад давуу тал олох нь авилгын зөрчил төдийд тооцогдож байгааг энд дурьдах нь зүйтэй болов уу.

3. Эрүүгийн хуулийн тусгай ангийн зарим заалтын талаар:

250 дугаар зүйл. Шүүхээс хууль бус шийдвэр гаргах

250.1. Шүүгч шунахайн болон хувийн бусад сэдэлтээр илт хууль бус шийдвэр гаргасан бол таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

248 дугаар зүйл. Илт гэм буруугүй хүнийг сэжигтнээр тооцох, яллаг-дагчаар татах, ял шийтгэх

248.1. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч шунахайн болон хувийн бусад сэдэлтээр илт гэм буруугүй хүнийг сэжигтнээр тооцсон, яллагдагчаар татсан, ял шийтгэсэн бол хоёроос таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Шунахайн сэдэлт гэдэг материаллаг буюу эдийн болон эдийн бус давуу тал олж авах хүсэл, сонирхол юм. Хуулийн дээрх заалтад дурьдагдсан субъектүүд хээл хахууль авч хуулиар олгогдсон онцгой эрхээ урвуулан шийдвэр гаргасан тохиолдолд шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэрэгт тооцож байгаа нь буруу бөгөөд дээрхи тохиолдолд албан тушаалын эсрэг гэмт хэрэгт тооцон эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр өөрчлөх мөн Эрүүгийн хуулийн 268 дугаар зүйлд дээрх субъектүүдийг тусгайлан нэрлэж өгөх шаардлагатай. Германы Эрүүгийн хуулийн тусгай ангийн 331, 332 дугаар зүйлүүдэд дээрх гэмт хэргийн субъектүүдийг албан тушаалтан, нийтийн албан хаагч гэж зааснаас гадна шүүгчийг тусад нь томъёолон заасан байдаг. Учир нь шүүгч шүүн таслах үйл ажиллагааг хэрэгжүүлэх онцгой эрхээ урвуулан хээл хахууль авсан, давуу тал олсон бол илүү хүнд ял шийтгэл оногдуулахаар заасан нь үндэслэлтэй. Харин манай улсын Эрүүгийн хуулийн 250 дугаар зүйлийн 250.1, 248 дугаар зүйлийн 248.1-д зааснаар хүлээлгэх хариуцлага буюу оногдуулах ял шийтгэл нь мөн хуулийн 268 дугаар зүйлд зааснаар хүлээлгэх ял шийтгэлтэй харьцуулахад хөнгөн, албан тушаал эрхлэх эрх хасах ялгүй байгаа нь ял завших боломжийг бий болгохоос гадна хуулийн шударга ёсны зарчимд нийцэхгүй байна. *Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч* нь төрийн онцгой чиг үүргийг хэрэгжүүлдэг, хуулийн хүрээнд бусдын эрхэнд халдах эрхтэй субъектүүд тул тэдгээрийн эдлэх эрхээс гадна хуулиар хүлээлгэх хариуцлага өндөр байх ёстой.

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 170 дугаар зүйлд "тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллагын ажилтан албан үүргийн

дагуу ажил гүйцэтгэж үйлчилгээ үзүүлэх үүргээ далимдуулан хясан боогдуулах замаар удаа дараа буюу их хэмжээний шан харамж авсан нь албан тушаалын гэмт хэргийн шинжгүй бол....” гэж заасан нь учир дутагдалтай байна. Өөрөөр хэлбэл төрийн чиг үүргийг хэрэгжүүлэн, нийтийн эрх ашгийг хамгаалах, хяналт тавих онцгой эрх бүхий субъектуудын хувьд жишээ нь улсын байцаагч /гааль, татвар, мэргэжлийн хяналт, эрүүл ахуй, газрын алба г.м/ чиг үүрэгтэй холбогдуулан хууль бусаар шан харамж, давуу тал олох ёсгүй. Дээрх хуулийн заалтаар нэг удаа бага бус эсхүл үлэмж хэмжээний шан харамж авсан бол захиргааны хариуцлага хүлээж, их хэмжээний шан харамж авсан бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр байгаа нь шударга бус юм.

Хууль тогтоогч авлигын хамгийн түгээмэл хэлбэр болох шан харамжийн авч болох хэмжээг тогтоон дээрх субъектүүдийг “их” хэмжээтэй л биш бол тодорхой хэмжээгээр албан тушаалаа ашиглан “боломжийн орлого” олж амьдралаа дээшлүүлэхийг хуулиар “зөвшөөрснийг” төрөөс бэлэглэсэн бэлэг гэж үзэхээс өөр яах билээ. Чанаргүй барилга, зам ашиглалтанд оруулах зөвшөөрөл олгох, хилээр хууль бус зүйл, их хэмжээний мөнгө зэргийг “анзааралгүй” оруулах, эрүүл ахуйн шаардлага хангаагүй нөхцөлд үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээдийг “сануулсан” болоод өнгөрөх цаашилбал тендер нэрийн доор хууль бус сонгон шалгаруулалт явуулах, төрийн тусгай хамгаалалттай газар барилга барих зөвшөөрөл олгох, цаасан дээр монгол хүний нэр бичигдэж цаанаа гадны эзэнтэй аж ахуйн нэгжид тогтоосон хууль, дүрэм зөрчин уул уурхай, хайгуул, олборлолтын зөвшөөрөл г.м тусгай зөвшөөрөл олгох гэх мэт жагсаалт хөвөрнө. Гэтэл ийм онцгой эрхтэй субъектүүдийн энэ эрхээ ашиглан ашиг олж байгааг “шан харамж” төдий ойлгон “толгойг нь илж” байгааг өөрчлөх цаг болжээ. Түүнчлэн их хэмжээний шан харамж гэдгийг хэдэн төгрөгөөр тооцох тухай Эрүүгийн хуульд байдаггүй ба зөвхөн гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг яаж тооцохыг Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 29 дүгээр зүйлд зохицуулсан байдаг. Практикт дээрх заалтыг барин хээл хахуулийн хэмжээг тооцож байгаа нь Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 3 дугаар зүйлд заасан хууль ёсны зарчмыг зөрчиж байна. Мөн 192,000 төгрөгний эд зүйл хулгайлсан иргэнд эрүүгийн хариуцлага хүлээлгэж байгаа нь дээрхи хуулийн заалттай харьцуулахад Монгол Улсын Үндсэн Хуульд заасан хүн бүр хууль, шүүхийн өмнө тэгш эрхтэй байх зарчим зөрчигдөж байгааг харуулж буй бодит жишээ юм.

Нийтийн албаны босго хатуу, шалгуур өндөр, онцгой эрх эдэлдэг шигээ хүлээх үүрэг хариуцлага жирийн иргэнээс хэд дахин өндөр байж нийтийн албыг мөнгө олох хэрэгсэл болгож буй бусармаг явдалтай жинхэнэ утгаар тэмцэж чадна.

Авлигын хэрэг шалгах бүрд давхар мөнгө угаах гэмт хэргийг шалгаж хэвших буюу мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэргүүдийг Эрүүгийн хуулинд тодорхой нэрлэх шаардлага зүй ёсоор урган гарч байна. Авлигын хэрэг ямагт ил далд аргаар үйлдэгдэхээс гадна уг гэмт хэргийг илрэхээс сэргийлэх зорилгоор гэмт этгээдүүд авлигаар авсан зүйл, эдийн болон эдийн бус давуу байдлыг дүрс, хэлбэр, байршил зэргийг нарийн зохион байгуулалттайгаар өөрчилж ингэхийн тулд бусдыг гэмт хэрэгт буюу мөнгө угаах гэмт хэрэгт татан оролцуулах нь олон улсын хэмжээнд төдийгүй манай улсын хар зах зээлд хэдийн байр сууриа олсон байна. Тухайлбал авлигын гэмт хэрэг үйлдэж олсон хувьцаа үнэт цаасны зах зээлд борлогдох, хөнгөлөлттэй зээл нэрээр банкны тогтоосон журмаас доогуур авагдсан зээл, бусдын нэр дээр авсан хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө зарагдах, түрээслэх хууль бус бэлэглэлийн гэрээгээр шилжих, аж ахуйн нэгжийн хувьцааг гэр бүл, найз нөхөд гэх мэт өөр хүний нэр дээр эзэмшүүлэн хувь хүртэх, гадаадад дансанд их хэмжээний мөнгө, валют байршуулах мөн үл хөдлөх хөрөнгө худалдан авч бусдын нэрээр эзэмших гэх зэргээр мөнгө угаах гэмт хэргийн энгийн элемент агуулагдсан үйлдлүүдэд анхаарлаа хандуулах цаг болжээ. Авлигын гэмт хэрэг үйлдэж олсон зүйлсийн дүрс, хэмжээ, гарал үүслийг нуух зорилгоор идэвхитэй үйлдэл хийсэн этгээдүүдийн үйлдлийг хууль зүйн үүднээс тайлбарлавал дараахь байдлууд ажиглагддаг.

1. Placement буюу байршуулах: Эхний үе шатанд хууль бусаар олсон үнэт цаас, мөнгө, эд зүйлс, хувьцаа, бусад эрхийн бичиг гэх мэтийг хаа нэгтээ байршуулдаг. Тухайлбал: Өөр хүний нэр дээр банканд хадгаламж болон харилцах данс нээлгэх, үнэт цаас, чек худалдан авах, алт үнэт зүйлсийг хадгалуулах г.м

2. Layering буюу нуун далдлах үе: Энэ үе шатанд дээр дурьдагдсан зүйлсийн гарал үүслийг нь нуун далдлах зорилгоор байршуулсан зүйлээрээ хөрөнгө оруулалт, хандив тусламж, хүүтэй зээл, бусдын нэр дээр объект, хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгө худалдан авах, асрамжийн болон буяны байгууллага, сан, компани, банк байгуулах, тэдгээрийг даатгуулах зэрэг үйлдэл хийгддэг.

3. Integration буюу эргэлтэнд оруулах үе Сүүлийн энэ үе шатанд гарал үүслийг нь нуусан мөнгө бусад зүйлийг хууль ёсны эдийн засгийн эргэлтэнд оруулдаг. Өөрөөр хэлбэл хөрөнгө оруулалт хийсэн газраа зарах, түрээслэх замаар ашиг олох, зээлсэн мөнгөнийхөө хүүг авах, компани, сангийн тодорхой хувь эзэмшигч болох, үүсгэн байгуулсан банкыг санаатай дампууруулж даатгалын байгууллагаас их хэмжээний нөхөн төлбөр авах гэх мэт. Дээрхи үйл явцаас харахад авлигын болон мөнгө угаах гэмт хэргийг тусад нь салгаж ойлгон, уг хэргийг шалгах ажиллгааг зэрэг явуулдаггүйгээс зөвхөн авлигын хэрэг үйлдсэн этгээдэд ял шийтгэл оноогоод орхих түүний хууль бусаар олсон их хэмжээний зүйлсийг олж тогтоохгүйгээр бусад этгээд хууль бусаар хөрөнгөжин улмаар эрүүл шударга зах зээлийн урсгалд ямар их хохирол учруулж болох нь харагдаж байна. Иймд ялангуяа гадны улс оронд хөдлөх үл хөдлөх хөрөнгө худалдан авах, дансанд мөнгө байршуулах үйл ажиллагааг хянаж тогтоохын тулд эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээтэй болон гэрээгүй орнуудтай Авлигын эсрэг конвенцийн 6 дугаар зүйлд заасны дагуу харьцах, өөр бусад хэлбэрээр хамтран ажиллах боломжийг бүхий л талаар судлан зохион байгуулах талаар конвенциор хүлээсэн үүргээ биелүүлэх ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байна.

Энэхүү илтгэлдээ авлигын эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн орчин нийгмийн шаардлагад нийцэхгүй, олон улсын гэрээ конвенцоор хүлээсэн үүргээ хангалттай биелүүлэхгүй байгааг жишээгээр дурьдахаас гадна олон зуун жилийн түүхтэй ХБНГУ-ын авилгатай хэрхэн үр дүнтэй тэмцэж байгааг товчилон хүргэхийг хичээлээ.

Мөн Гэмт хэргийн тухай хуулийн төслийн 22 дугаар бүлэгт авлигын гэмт хэргийг тусгайлан зааж уг гэмт хэргийн субъект, үйлдлийн арга хэлбэрийг дэлгэрэнгүй тусган хүлээлгэх хариуцлагыг чангатган Авлигын эсрэг НҮБ-ын конвенцид нийцүүлсэн нь авлигын эсрэг тэртусмаа өндөр түвшний авилгын хэргийг илрүүлэх шалгах тэмцэлд дэвшилттэй алхам бөгөөд одоо хүчин төгөлдөр Эрүүгийн хуулинд нэмэлт өөрчлөлт оруулахгүй гэвэл Гэмт хэргийн тухай хуулийг нэн даруй батлах шаардлагатайг тэмдэглэж байна.

Анхаарлаа хандуулсан та бүхэнд баярлалаа.

ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ: АВЛИГЫГ ҮЛ ТЭВЧИХ ҮЗЭЛ

О.Очиржав - АБЗ-ийн Ажлын албаны дарга

УИХ-ын 2010 оны 48 дугаар тогтоолоор батлагдсан Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал нь үндэсний аюулгүй байдал, түүнийг хангах нөхцөл, баталгаа, баталгаажилт, дархлаа, зарчмыг тодорхойлж, үндэсний аюулгүй байдлыг хангах арга замыг зааж, тогтолцоог бүрдүүлсэн үндэсний аюулгүй байдлыг хангах бодлогын гол баримт бичиг юм.

Авлига газар авсан нь үндэсний аюулгүй байдалд заналхийлж байна

Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд “Төрийн удирдлагын чадавхи сул, шудрага бус байдал, авлига газар авсан нь үндэсний аюулгүй байдалд заналхийлж байна” гэж заасан байдаг. Энэ бол авлига газар авсан байна, энэ нь үндэсний аюулгүй байдалд заналхийлж байна гэсэн бодлогын чухал дүгнэлт болно.

Авлига газар авсан нь үндэсний аюулгүй байдалд хэрхэн заналхийлж буйг товч авч үзвэл: (1) төрийн гадаад бодлого нэгдмэл байх, гадаад харилцаанд үндэсний ашиг сонирхлыг дээдлэх, хоёр хөрш болон бусад улстай тэнцвэртэй харилцах зарчмыг алдагдуулж байна; (2) төр аж ахуйн үйл ажиллагаанд хэт оролцоход хүргэж, чөлөөт өрсөлдөөнийг хумиж, зах зээлийн эдийн засгийн зарчмаас ухрахад хүргэж байна; (3) төсөвт орох татварын орлогыг багасгаж, төсвийн зарцуулалтыг үр дүнгүй болгож, төсөв, санхүүгийн салбарын аюулгүй байдлыг алдагдуулж байна; (4) улсын гадаад дүр төрхийг муутгаж, гадаадын хөрөнгө оруулалт буурахад нөлөөлж байна; (5) сүүдрийн эдийн засгийг хөгжүүлж, нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжилд гажуудал үүсгэж байна; (6) бараа, үйлчилгээний үнийг хөөрөгдөн, ядуурал буурахгүй байхын нэг үндэс болж байна; (7) ардчилсан тогтолцоонд заналхийлж, төрийн албаны чадавхийг сулруулан нэр хүндийг нь унагаж, хууль дээдлэх ёсонд хохирол учруулж, тэгш эрх, шудрага ёсыг алдагдуулж, нийгмийн тогтвортой байдлыг эрсдэлд оруулж байна; (8) мэдээллийн бүрэн бүтэн байдал, нууцлал, хүртээмжтэй байдлыг алдагдуулж байна; (9) мөнгө угаах

зэрэг эдийн засгийн болон зохион байгуулалттай гэмт хэрэгтэй холбогдож байна; (10) олон нийт авлигыг хэвийн үзэгдэл мэт ойлгодог болж, хариуцлагагүй байдал газар авч байна.

Дүгнэж хэлэхэд авлига газар авснаар үндэсний язгуур ашиг сонирхол зөрчигдөж, үндэсний аюулгүй байдлыг хангах нөхцөл, баталгаа, баталгаажилт алдагдаж, үндэсний аюулгүй байдлын дархлаа суларч, улмаар үндэсний аюулгүй байдалд заналхийлж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж “Авлига бол Монголын сайхан орныг муухай харагдуулдаг, ардчилал, эрх чөлөөний заналт дайсан, авлигатай тэмцэх ажлыг дээрээсээ эхэлж цэг тавих ёстой”, Нийслэлийн засаг дарга Э.Бат-Үүл “Авлига тусгаар тогтнолд заналхийлж байна”, Эмэгтэй удирдагч сангийн Удирдах зөвлөлийн дарга В.Удвал “Хөгжлийн дайсан – өндөр түвшний авлига”, Английн түүхч, улс төрч, зохиолч Лорд Актон “Эрх мэдэл авлигад өртдөг, хэмжээгүй эрх мэдэл хэмжээгүй авлигад өртдөг”, НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга асан Кофи Аннан “Авлига нь ардчилал, хууль дээдлэх ёсыг булшилж, хүний эрхийг зөрчиж, зах зээлийг бусниулж, амьдралын чанарыг муутгаж, зохион байгуулалттай гэмт хэрэг, терроризмыг цэцэглүүлдэг” гэж тус тус хэлсэн нь авлига үндэсний аюулгүй байдалд заналхийлдэгийг тодотгож байгаа билээ.

Авлигыг үл тэвчих үзлийг нийгэмд төлөвшүүлнэ

Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд “Авлигатай хийх тэмцлийг үндэсний хэмжээнд өрнүүлж, улс төрийн нам, иргэний нийгмийн байгууллагын идэвхтэй оролцоог хангана. Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг эрчимжүүлж, авлигыг үл тэвчих үзлийг нийгэмд төлөвшүүлнэ.” гэсэн бодлогын зорилтыг тавьсан.

Энэ зорилтын хүрээнд улс төрийн нам, иргэний нийгмийн оролцоог хангах, авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг эрчимжүүлэх талаар олон зүйлийг ярьж болох ч өнөөдрийн онол-практикийн хурлын зорилготой холбогдуулан хэдэн санал хэлье.

- Авлигатай тэмцэх бодлогын хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн “Ухаалаг төр”-ийн санаачилгыг

дэмжин хэрэгжүүлж, санал болгосон хуулиудыг нь батлан гаргах шаардлагатай гэж үзэж байна. Ялангуяа лиценз, тусгай зөвшөөрлийн тухай, төрийн аж ахуйн үйл ажиллагааг хязгаарлах тухай, төсвийн хөрөнгө оруулалтын тухай, төрийн бараа, үйлчилгээний худалдан авалтын тухай, төрийн байгууллага, албан тушаалтны шийдвэр, түүний бүртгэл хяналтын тухай, төрийн сонгогдсон болон томилогдсон албан тушаалтанд хариуцлага тооцох тухай хуулиудыг гаргах нь авлигатай тэмцэхэд чухал ач холбогдолтой болох юм.

- ❑ Үндэсний хууль тогтоомжийг Авлигын эсрэг НҮБ-ын 2003 оны конвенцод нийцүүлэх ажил 2006 оноос хойш хийгдээгүй явж ирлээ. Энэ ажлыг яаралтай хийх, тэхдээ дараах зүйлийг анхаарах шаардлагатай: (1) Конвенцийн холбогдох заалтуудыг гэмт хэргийн тухай болон авлигын тухай хууль тогтоомжид тусгах, (2) цаашид олон улсын конвенцид нэгдэн орохдоо үндэсний хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг хамтад нь боловсруулан УИХ-д оруулж байх, (3) авлигын гэмт хэргийн тодорхойлолт, бүрэлдэхүүн, хариуцлагыг Конвенцид зааснаар нь хүлээн зөвшөөрөх, уг Конвенцид 172 улс нэгдэн орж уг гэмт хэрэгтэй тэмцэх талаар олон улсын нэгдсэн хэм хэмжээ, стандарт тогтоож байхад Монголын онцлог өөр байх ёстой хэмээн зөрж давхих нь зохисгүй.
- ❑ Монгол 2010 оноос авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөхгүй явж байгаа тул иргэний нийгмээс боловсруулсан Шудрага ёсны үндэсний тогтолцоог бэхжүүлэх, авлигатай тэмцэх хөтөлбөрийг хэлэлцэж батлан гаргах саналыг дэмжиж байна.
- ❑ Улс төрийн санхүүжилтийг ил тод болгох, төсвийн зарцуулалт, төрийн өмчийн ашиглалтыг сайжруулах, төрийн албыг бэхжүүлэх, хэвлэлийн эрх чөлөөг хангахад чиглэсэн хууль тогтоомжийг сайжруулснаар авлигатай тэмцэх эрх зүйн орчинг сайжруулна.
- ❑ Авлигын эсрэг парламентчдын дэлхийн байгууллага (GOPAC) өндөр түвшний авилгыг хүн төрөлхтөний эсрэг гэмт хэрэг хэмээн хүлээн зөвшөөрч тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгааг дэмжиж идэвхтэй оролцох нь чухал болно.

Авлигыг үл тэвчих үзлийг нийгэмд төлөвшүүлэхэд хувь хүн бүр, нэн ялангуяа улс төрч бүрийн “үгүй” гэж авлигад хэлэх нь нэн чухал болно.

“АВЛИГА ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛД НӨЛӨӨЛӨХ НЬ”



**Зураг 1. “Авлига Үндэсний Аюулгүй байдалд нөлөөлөх нь”
Онол-практикийн хурлын нээлтийн үйл ажиллагаа**



Зураг 2. УИХ-ын дэд дарга Л.Цог хурал нээж үг хэллээ



Зураг 3. УИХ-ын гишүүн, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Ц.Оюунбаатар



Зураг 4. АНУ-ын Азийн Сангийн Монгол дахь суурин төлөөлөгч хатагтай Мелони Линдберг хуралд оролцож үг хэллээ



Зураг 5. Хурлын илтгэгч нар: /зүүн талаас/ Авлигатай Тэмцэх газрын хэлтсийн дарга Э.Амарбат, МУИС-ийн Сургалт эрхэлсэн дэд захирал О.Мөнхбат, Ерөнхий Прокурорын газрын хяналтын прокурор Б.Өнөрмаа нар



Зураг 6. Эмэгтэй Удирдагч сангийн Удирдах зөвлөлийн дарга В.Удвал



Зураг 7. Хурлын оролцогч нар



Зураг 8. Ажлын хэсгийн хурал

ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛД ӨНДӨР ТҮВШНИЙ АВЛИГА НӨЛӨӨЛӨХ НЬ

О.Мөнхбат. Доктор, профессор МУИС-ийн Сургалт эрхэлсэн дэд захирал, С.Мөнхбат. Доктор, дэд проф МУИС-ийн Улс төр судлалын тэнхимийн эрхлэгч, М.Батбаатар. Докторант, МУИС-ийн Социологи, нийгмийн ажлын тэнхимийн багш

Асуудлыг дэвшүүлэхүй: Авлигын асуудлаар хийсэн судалгааны дүнгээс үзэхэд сүүлийн арван жилд Монголд тулгарч буй асуудлын дунд “авлига” айргийн тавд баттай багтаж ирлээ. Авлигын хамрах хүрээг эрүүл мэнд, боловсрол, татвар зэрэг төрийн үйлчилгээ үзүүлдэг байгууллага, албан хаагчдаар хязгаарлан үзэх нь “ул” болж төрийн шийдвэр гаргагчид, бодлого боловсруулагчид, улстөрийн намын түвшинд архагшсан үзэгдэл болсон талаар олон нийт судлаач шинжээчид сэтгэл зовнин тэмдэглэх боллоо. Авлигатай тэмцэх үйл хэрэг мухардах тусам дараах хоёр хандлага илтэд ажиглагдаж байна. Үүнд: нэгдүгээрт, өргөн олон нийтийн дотор авлигатай тэмцэх нь боломжгүй зүйл юм байна гэсэн уруу үзэл тархаж, нэгэнт төрийн өндөр дээд албан тушаалтнууд ингэж дураар дургиж байгаа хойно хэн нэгний гар цайлгах, шан харамж өгөх нь юу ч биш гэсэн ойлголт батжин авлигыг цагаатгах, зөвтгөх хандлага давалгаалан түрэх болж байна. Хоёрдугаарт, авлигатай хууль ёсны хүрээнд тэмцэж болохгүйгээс хойш “хорыг хороор дарах” буюу авлигач улс төрч, өндөр дээд албан тушаалтныг олны өмнө өчиггүй цаазлах, төв талбай дээр дүүжлэх хэрэгтэй зэрэг туйлширсан экстремист хандлага өсөх хандлагатай байна.

Судалгааны зорилго, түүврийн бүлэг: Авлигатай тэмцэх чиглэлээр мэргэшсэн шинжээчид болон олон нийтийн санал бодлыг судалж, өндөр түвшний авлигын шинж чанар, илрэх хэлбэр, хамрах цар хүрээг тодорхойлон, үндэсний аюулгүй байдалд үзүүлж буй сөрөг үр дагаврыг шинжлэн, тэмцэх арга замыг судлахад судалгааны зорилго чиглэв. Судалгааг 2014 оны 10 дугаар сард иргэний нийгэм, төрийн бус болон төрийн байгууллага, олон улсын байгууллага, судалгааны байгууллагын 30 гаруй эксперт шинжээчид болон ард олны дунд явуулсан юм.

Өндөр түвшний авлига систем болох нь: хэлбэр, түвшин, үр дагавар: Авлига бүхэл нийгмийн тогтолцоог гажуудуулж, завхруулахын хэрээр улам бүр нарийсч засаглалтай хутгалдан, зохион байгуулалттай, системийн шинжтэй үзэгдэл болон хувирч байгааг судалгаанд хамрагдсан шинжээчид онцолсон байна.

Шинжээчид өндөр түвшний авлига гэдгийг тодорхойлохдоо:

1. Оролцогч талууд: Төрийн өндөр дээд албан тушаалтан, шийдвэр гаргадаг институци оролцдог, 2. Хөндөж буй эрх ашиг: Улс орон ард түмний нийтлэг эрх ашгийг хөнддөг, 3. Үр дагавар: Улс үндэсний тусгаар тогтнол, аюулгүй байдалд хор хөнөөл учруулдаг гэсэн үндсэн шалгуур үзүүлэлтүүдэд тулгуурлан тодорхойлж байна. Ингэхдээ авч өгч байгаа авлигын мөнгөний хэмжээгээр бус харин улс орны тусгаар тогтнол, аюулгүй байдал, ард олны амь амьдралд заналхийлж буй гэмт хэрэг гэдэг утгаар нь авч үзэх ёстой хэмээн шинжээчид хэлж байна.

Тэдний үзсэнээр авлигыг илрэх хэлбэр учруулж байгаа үр дагавраас нь хамааран дараах гурван түвшинд хувааж болох аж. Тухайлбал,

	ИЛРЭХ ХЭЛБЭР	ҮР ДАГАВАР
Өндөр	Авлигатай амжилттай тэмцэх хууль батлахгүй, эсвэл цоорхойтой хууль баталж, хийдэл үүсгэх замаар авлигын таатай орчин бүрдүүлэх	Улс орны аюулгүй байдал, бие даасан байдалд аюул занал учруулах Шударга ёс, хуулийн өмнө тэгш байх зарчмыг гажуудуулж, төр засгийн нэр хүндийг унагаж, гутранги үзлийг нийгэмд түгээн тархаах
Дунд	Хүнд суртал, чирэгдэл үүсгэх замаар авлига, хээл хахууль авах нөхцөл бүрдүүлэх Шийдэж буй асуудлын мөнгөн дүнгийн тодорхой хувийг урьдаас тохирон авах	Хуулийн хэрэгжилтийг завхруулан гажуудуулах
Доод	Гар цайлгах, шан харамж авах Хууль ёсны болон хууль бус үйлчилгээнд давуу байдал олгох, "тусгай" эрх эдлэх	Авлигыг хүлээн зөвшөөрөх сэтгэлгээ бий болох

Үүний зэрэгцээ өндөр түвшний авлига бол төрийн өндөр дээд албан тушаалтан оролцдог, хор хохирлын хувьд асар их, нарийн зохион байгуулалттай, голдуу хуулийн “хамгаалалтанд” орсон байдаг тул илрүүлэх, шалгах, хариуцлага тооцоход хүндрэлтэй байдгаараа онцлог юм.

Өндөр түвшний авлигыг нийгмийн системтэй харьцуулж болно.

Нийгмийн системийн гол шинж	Өндөр түвшний авлигын системийн шинж
Бүтэц зохион байгуулалт	Бүтэцжсэн, өндөр зохион байгуулалттай, үндэсний болоод үндэстэн дамнасан орон зайд үйлчилдэг.
Хүчирхэг нөлөөтэй тоглогч, оролцогч талууд	Хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх засаглал, улс төрийн нам болон бизнесийн нөлөө бүхий институт оролцдог
Дасан зохицох, гадаад орчинг өөрт ашигтайгаар өөрчлөх чадвартай	Хуулийн тусламжтай болон хууль бусаар давуу байдлыг бий болгож, шударга ёс, нийтийн “сонирхол”-оор бамбайлан хаацалдаг.
Гадаад орчноос өөрийгөө хамгаалах чадавхи/дархлаа/	Хууль бус зан үйлийг зөвтгөх, хуулийг завхруулах хүчирхэг хөшүүрэг, эрх мэдэл бүхий, шийдвэр гаргах түвшинд нөлөөллийн бүлгүүдтэй, “халдашгүй байдал” зэрэг эрх зүйн хамгаалалттай.

Өндөр түвшний авлигад оролцогч талууд нь авлигын системдээ дараах байдлаар үйлчилдэг байна. Тухайлбал,

Хууль тогтоох байгууллага: авлигад “ээлтэй” бодлого, хууль эрх зүйн орчин “бүрдүүлэх”, халдашгүй байдал гм “хамгаалалтын” нөхцөл бий болгох зэргээр үйлчилнэ.

Гүйцэтгэх байгууллага: Хуулийн хэрэгжилтийг гажуудуулан завхруулах, хууль бус давуу байдал олгох зэргээр үйлчилнэ.

Шүүх байгууллага: Хуулийн өмнө тэгш байх зарчим, шударга ёсыг алдагдуулж, “дуулгаваргүй”-г номхотгох, “халдашгүй”-г хамгаалах зэргээр үйлчилнэ.

Улстөрийн нам: Сонгуулийн дэмжлэгийн хариу барих, бодлого боловсруулах, томилгоо зэрэгт “эргэдэг хаалга”-ны зарчмаар үйлчилнэ.

Бизнесийн бүлэглэл: Улс төртэй хутгалдах замаар олигарх бүлэглэл үүсгэх, улс орны эрх ашиг, аюулгүй байдлыг хохироосон

бизнес төслийг хэрэгжүүлж, том хөрөнгө оруулалтыг хяналтандаа авах, байлгах зэргээр үйлчилнэ.

Хэвлэл мэдээлэл: олон нийтийн “Тархи угаалт”-ыг явуулж, “Хаалтын гэрээ” байгуулах зэргээр авлигачдыг хаацайлах үйлчилгээ үзүүлнэ.

Ийнхүү “ашиг сонирхлоор” нөхцөлдсөн өндөр түвшний авлигачид харилцан бие биедээ дэм үзүүлэх байдлаар чухамдаа “аалзны тор” мэт бат бөх сүлжээ үүсгэн оршин байдаг ажээ.

Үндэсний аюулгүй байдалд өндөр түвшний авлигын үзүүлэх нөлөө

Шинжээчдийн үзсэнээр үндэсний аюулгүй байдалд үзүүлэх өндөр түвшний авлигын нөлөөг дараах байдлаар эрэмбэлэн үзэж болох юм.

Эрэмбэ	Аюулгүй байдал	Нөлөө үзүүлэгч талууд	Илрэх хэлбэр, үр дагавар
1-р түвшин	Оршин тогтнохуйн аюулгүй байдал	Үндэстэн дамнасан корпораци, гадны улс орон, иргэн харьяат, худалдагдсан улч төрчид, албан тушаалтан	Сонгуулийн явцад нөлөөлөх, улс төрийн намыг санхүүжүүлэх. Улс орны баялаг, төрийн бодлогыг хяналтандаа байлгах үүднээс улс төрчид, эрх мэдэлтэй хүмүүсийг худалдан авч улмаар хэрэгтэй шийдвэр гаргуулах үүднээс шантаажлах, барьцаалах
2-р түвшин	Эдийн засгийн аюулгүй байдал	Үндэстэн дамнасан корпораци, гадны улс орон, иргэн харьяат, худалдагдсан улч төрчид, албан тушаалтан	Шударга бус гэрээ хэлцэл байгуулах. Эдийн засгийн хөгжил сул, ядуурал гаарч, хүн амын амьжиргаа доройтох, өмчийн хэт ялгаа үүсэх
3-р түвшин	Дотоод аюулгүй байдал	Үндэстэн дамнасан корпораци, гадны улс орон, иргэн харьяат, худалдагдсан улч төрчид, албан тушаалтан	Үймээн, самуун дэгдээх, засаглалд итгэх итгэлийг ганхуулах. Иргэд талцах, эв нэгдэлгүй болох, хууль, дэг ёс алдагдаж, дотоодын үймээн самуун дэгдэнэ

“АВЛИГА ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛД НӨЛӨӨЛӨХ НЬ”

4-р түвшин	Хүний амьдрах, хүрээлэн буй орчны аюулгүй байдал	Үндэстэн дамнасан корпораци, гадны улс орон, иргэн харьяат, худалдагдсан улч төрчид, албан тушаалтан	Амьдралын чанарын стандартыг хяналтандаа авах. Амьдрах орчин, хэрэглээний чанар стандарт алдагдан доройтох, агаар ус хөрс зэрэг байгалийн орчны бохирдол
5-р түвшин	Мэдээллийн аюулгүй байдал	Үндэстэн дамнасан корпораци, гадны улс орон, иргэн харьяат, худалдагдсан улч төрчид, албан тушаалтан, нөлөөлөлд автсан хэвлэл мэдээлэл	Тархи угаах, худал буруу мэдээлэл тараах. Иргэд албан ёсны мэдээлэлд итгэхгүй болж, цуу мэдээ хүчирхэгжих, төрд итгэх итгэл алдрах

Дээрх хүснэгтээс харахад өндөр түвшний авлига үндэсний аюулгүй байдлын тулгуур багана бүрд сөргөөр нөлөөлж байгаа талаар шинжээчид ийнхүү дүгнэжээ.

Шинжээчдийн дунд явуулсан ярилцлагатай зэрэгцүүлэн 500 иргэдийн дунд явуулсан санал асуулгын судалгааны дүнгээс үзэхэд өндөр түвшний авлига үндэсний аюулгүй байдалд зарим талаар болон, сөргөөр нөлөөлөх хэмжээнд хүрсэн гэж иргэдийн 92.4% нь үзжээ.

Энэхүү дүнгээс үзэхэд авлига нийгмийн бүх хүрээг хамран тэлэхийн хэрээр нийгэмд үзүүлэх сөрөг нөлөө нь улам бүр нэмэгдэж, цаашлаад үндэсний аюулгүй байдлыг алдагдуулахад хүрч болзошгүй гэсэн зовнил бүх нийтийг хамарч байна.

Өндөр түвшний авлига нь улс орны удирдлагын түвшинд, үндэсний аюулгүй байдалтай холбоо бүхий байгууллага, албан тушаалтны түвшинд, улс төрийн шийдвэр гаргах түвшинд шууд хамаатай тул олон нийтийн зүгээс нөлөө үзүүлэх, хяналт тавих боломж маш бага байдгаар бусад авлигаас ялгардаг байна. Түүнчлэн олон нийт дээд түвшний авлига бусад авлигаас илүү хор хөнөөлтэй (92.1%) байдаг, өндөр түвшний авлига бол эрх мэдэл бүхий хүмүүс оролцож, үйлдэж байдаг тул илэрдэггүй(88%) ба авлигыг их бага байхаас үл хамаарч шийтгэл үзүүлэх хэрэгтэй(81.9%) хэмээн үзсэн байна.

Авлига, өндөр түвшний авлигатай тэмцэх арга зам: Шинжээчид өндөр түвшний авлигатай тэмцэх хүсэл зориг эрх баригчдад тун сул гэж үнэлсэн олон нийт төр засгийн зүгээс авлигатай тэмцэх хүсэл зоригийг мөн л сөрөг үнэлсэн байна. Тухайлбал, хүсэл зориг байгаа боловч тэмцэх зөв менежмент байхгүй(63.6%), тэмцэх хүсэл зориг байхгүй(22.4%) гэж үзсэн ба арав хүрэхгүй(9.4%) хувь нь төр засгийн удирдлагуудад тэмцэх хүсэл зориг бий, тэмцэж чадаж байна гэж үзжээ.

Түүнчлэн олон нийтийн зүгээс авлигын эсрэг төр засгийн байгууллагуудын явуулж буй үйл ажиллагааг тааруу буюу муу(иргэдийн 54% нь Засгийн газар, яамдыг, 42.8% нь УИХ-ыг, 45% нь Шүүх тогтолцоог, 44.4% нь Хууль хяналтын байгууллагыг муу гэж үзсэн) болон дунд(иргэдийн 38.2% нь Авлигатай тэмцэх газрыг, 33.4% нь Ерөнхийлөгч, түүний институцийг дунд зэрэг гэжээ) хэмээн үнэлсэн нь анхаарал татаж байна. Авлига ба өндөр түвшний авлигыг хэрхэн ойлгож тодорхойлж байгаагаас хамааран тэдгээрийн авлигыг үл тэвчих, тэмцэх хэлбэр, арга зам илэрхийлэгдэж байна. Энэ талаарх шинжээчдийн өгсөн хариултыг багцлан үзвэл дараах хэлбэр, арга замаар авлигатай тэмцэж болох ажээ.

ТЭМЦЭХ ХЭЛБЭР

- Хуулийг боловсронгуй болгох, чангатгах болон урьдчилан сэргийлэх гм өргөн хүрээтэй, цогц болгох байдлаар
- Улс төрийн хүсэл зориг, эдийн засгийн хөшүүргийг ашиглах
- Засаглалын нэр хүнд, түүнд итгэх итгэлийг сэргээх
- Иргэний нийгмийн оролцоотой ил тод байдлыг хангах
- Хууль сахиулах байгууллагыг “хүчтэй” болгох

ТЭМЦЭХ АРГА ЗАМ

- Хууль эрхийг сахиулах, эрх зүйн зохицуулалт, орчинг боловсронгуй болгох
- Төрийн бодлого тодорхой, нэгдсэн үзэл хандлагатай байх.
- Ил тод, хараат бус, бие даасан байдлыг хариуцлага, ёс зүйтэй зөв хослуулах
- Иргэний нийгмийн байгууллагыг чадавхжуулан хөгжүүлэх, оролцоог үр өгөөжтэй болгох
- АТГ болон авлигатай тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагын хараат бус байлгах, боловсон хүчнийг чадавхижуулах

Нэгд. Хууль эрхийн хүрээнд төдийгүй илүү өргөн хүрээтэй тэмцэхийг санал болгож байна. Авлигыг зөвхөн гэмт үйлдэл төдийгөөр хязгаарлан эрүүгийн хууль, төрийн албан хаагчийн ёс зүй, үүрэг хариуцлагын хүрээнд шийдвэрлэхийг оролдох нь тийм ч өгөөжтэй арга зам биш аж. Шинжээчид, ихэнх хүмүүсийн ойлгодог шиг “авлигыг тогтсон хууль дүрмийг зөрчих төдийгөөр үзэж болохгүй” гэдгийг энд онцолсон юм. Учир нь өндөр түвшний авлигыг үйлдэгч нь хууль дүрмийг сайтар мэдэхийн сацуу, хуулинд тусгаагүй атлаа улсын эрх ашгийг “илэрхий зөрчсөн” үйлдлүүд гаргах нь олонтаа байдаг аж. Иймд эл түвшинд үйлдэгдэж буй авлигатай тэмцэхийн тулд нэр томьёог оновчтой болгохоос эхлээд зонхилон үйлдэгдэж буй хэлбэр, хор уршгийг тодорхойлох, урьдчилан сэргийлэх, тэмцэх ба илрүүлэх, зохицуулах арга замын талаар холбогдох хуульд зүйл заалт оруулах нь нэгэн чухал алхам болох юм.

Хууль эрхийн хүрээнд өндөр түвшний авлигатай тэмцэхдээ макро орчныг сайжруулж авлигыг үл тэвчих үзэл хандлагыг бий болгох, хууль дээдлэхийн зэрэгцээ биелүүлэх, нэгэнт тухайн этгээд авлигын хэрэг үйлдсэн нь тогтоогдсон бол шийтгэх ял тодорхой байх, ял шийтгэлийг чангатгах, эрүүгийн хуулийн зүйл заалтад оноох шийтгэлийг тодорхой тусгаж өгөх шаардлагатай байна. Түүнчлэн энэ түвшинд үйлдэгдэж буй авлигатай амжилттай тэмцэхийн тулд ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах, эрх зүйн цар хүрээ, тогтолцоог боловсронгуй болгох, улс төрийн намын санхүүжилт, олон нийтийн мэдээлэл авах боломж зэрэгт анхаарлаа хандуулах хэрэгтэй болохыг шинжээчид санал нэгтэй баталж байна.

Хоёрт. Улс төр, эдийн засгийн хандлагаар авлигатай тэмцэх шаардлагатай: Авлигатай тэмцэх хойшлуулашгүй чухал зүйл бол төрийн бодлого тодорхой, нэгдсэн үзэл хандлагатай, улс төрийн тогтолцоог шинэчлэх, өөрчлөх явдал хэмээн иргэний нийгэм, төрийн бус байгууллагын экспертүүд үзсэн байна. Улс төрийн тогтолцоог сайжруулахын тулд нэн тэргүүнд сонгуулийн тогтолцоог өөрчлөх, улс төрийн намын санхүүжилт, нам, нэр дэвшигчийн сонгуулийн төсөв зардлыг ил тод болгох, намын харъяаллаар талцах явдлыг арилгах, төрд алба хааж буй хүмүүсийг томилох томилгоо, улс төрийн намуудаас хэт хараат байдлыг багасгах зэрэг хэд хэдэн зүйлийг тэмдэглэжээ. Эцсийн дүндээ авлигаас үүдэн төр засаг “сульдаж”, “хүчгүйдэж” нэг ёсондоо аюулгүй байдлын үндэс

алдагдаж байдаг тул төрийг чадавхижуулахын тулд улсын хэвшлийн удирдлагыг өөрчилж, улс төрөөс хараат бус болгох, хувийн хэвшлийг аль болох нэмэгдүүлэх нь чухал болохыг шинжээчид тэмдэглэсэн болно. Түүнчлэн эдийн засгийн нээлттэй шударга өрсөлдөөнийг нэмэгдүүлэх нь авлигыг өөгшүүлэхгүй байхад ихээхэн тустай.

Гуравт. Төрийн албанд үр өгөөжтэй хяналт тогтоож, хариуцлага, дүрэм журмыг сахиулах байдлаар тэмцэх хэрэгтэй: Шударга ёсыг сахиулах, нэг ёсондоо ил тод, улс төрөөс хараат бус, бие даасан байдлыг хариуцлага, ёс зүйтэй зөв хослуулах нь ихээхэн чухал бөгөөд төрийн албанд дээрх нөхцлийг хангах нь авлигын эсрэг тэмцэлд ач холбогдолтой. Түүнчлэн авлигыг үл тэвчих уур амьсгалыг нийгэмд бүрдүүлэх, олон нийтийн хяналтыг сайжруулах, авлигачдын төрийн албанд ажиллах боломжийг хаах, зайлшгүй хянах ёстой албан тушаалтны жагсаалтыг гаргах нь авлигатай тэмцэхэд гойд нөлөөтэй хэмээн шинжээчид үзсэн.

Дөрөвт. Ёс зүйтэй, хариуцлагатай байдлыг бэхжүүлж, иргэний нийгмийн оролцоотойгоор төсөв санхүүгийн ил тод байдлыг хангах замаар авлигатай тэмцэх нь чухал байна.

Иргэний нийгмийг хөгжүүлж, бэхжүүлснээр улс төрийн хариуцлага сайжирдаг зүй тогтолтой. Улс төр, төрийн албан тушаал, эрх ямба эдэлж буй хүмүүсийн хариуцлага сайжирч, төсвийн зарцуулалт ил тод болох явдал бол авлигыг ихээхэн багасгаж болохыг экспертүүд онцолсон байна.

Дээрх саналд тулгуурлан авч үзвэл авлигын шинжээчид иргэний нийгмийн байгууллагыг хөгжүүлснээр нийгэмд ёс зүйг төлөвшүүлж, шударга ёсыг тогтоох боломжтой хэмээн үзэж байна. Албан тушаалтны хөрөнгө орлогын мэдүүлэг нь ёс төдий бөгөөд, авлигыг илрүүлэх, тэмцэх үндсэн аргачлал болж чадахгүй байгаа хэмээн экспертүүд дүгнэжээ. Иймд иргэний нийгмийг бэхжүүлж чадавхижуулах, төсвийн хуваарилалтыг баг, хороо зэрэг төрийн анхан шатны нэгжээс эхлээд дээд түвшинд хүртэл нээлттэй, ил тод болгох нь чухал ажээ.

Тавд. Өндөр түвшний авлигатай тогтолцоот хандлагаар, цогц хэлбэрээр тэмцэх.

Хэдийгээр Монголд авлигатай тэмцэх ажлыг эрх зүй бодлогын орчныг сайжруулахаас эхлээд төрийн албыг эрүүлжүүлэн, авлигатай тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагуудыг чадавхжуулж,

иргэд олон нийтэд авлигыг үл тэвчих үзлийг бэхжүүлж, хариуцлагын тогтолцоог нийгэмд бүхэлд нь хэвшүүлэх хэрэгтэй гэж шинжээчид үзэж байна

Тогтолцоот хандлагаар тэмцэнэ гэдэг нь авлигыг хамрах хүрээгээр нь, авч буй эздээр нь, илрэх хэлбэрээр нь, үйлдэгдэж буй түвшнээр нь нэгэн бүхэл систем хэмээн үзэж, тэмцэх хэлбэр юм.

“ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ БА ӨНДӨР ТҮВШНИЙ АВЛИГА”

I. СУДАЛГААНЫ ТАНИЛЦУУЛГА

1.1 СУДАЛГАА ХИЙХ ҮНДЭСЛЭЛ

Авилгын талаарх судалгаа нь ерөнхийдөө хоёр чиглэлээр хийгддэг бөгөөд эхнийх нь санал асуулгад тулгуурлан зөвхөн олон нийтийн төсөөлөлд энэ үзэгдэл ямар байдалтай байгааг илрүүлэхэд чиглэдэг¹ бол хоёр дахь нь экспертийн шинжилгээ зэрэг чанарын аргачлал, хэрэглэгдэхүүнээр уг үзэгдлийг илүү нарийвчлан судалдаг, учир шалтгаан, үр дагаварыг тайлбарладаг. /Corruption in today's world. New-York. 2002 p-56/

Харин энэхүү судалгааны хувьд авлига болон өндөрт түвшний авлигын нөхцөл байдал, тэдгээрийн үндэсний аюулгүй байдалд үзүүлэх нөлөөллийг тодорхойлох, тэмцэх арга замыг гаргахад чиглэснээрээ авилгын талаар өмнө нь хийгдэж байсан төсөөллийн/олон нийтийн ойлголтын/ судалгаанаас ялгаатай болно.

Ер нь авлига хэмээх эл ойлголтын мөн чанар төрөл хэлбэрийн талаар олон улсын хэмжээнд ч нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн нэг мөр тодорхойлолт байдаггүй. Авлига хэмээх ойлголтын доор гар цайлгалт, бэлэг сэлт, албан бус төлбөрөөс эхлээд хээл хахууль, улсын өмч завших, улсын хөрөнгө нөөцийг албан тушаалаа урвуулан ашиглах, ёс зүйгүй үйлдэл гаргах, албан тушаалын наймаа хийх зэрэг олон төрлүүдийг хамруулан үзэх нь бий.

Авлига хэмээх нэр томъёог утгын хувьд авч үзвэл С.Шагжийн тольд² “хээл, хахууль гэсэн үгээр орлуулан тодорхойлсон” бол Я.Цэвэлийн толь бичигт³ “ёсон бусаар шунаж авсан эд юм” гэжээ. Дэлхий нийтийн авлигын тайланд⁴ “авлига гэж итгэж олгосон эрх мэдлийг хэрэгжүүлэх буюу хэрэгжүүлэхгүй байх замаар хувийн ашиг сонирхолоо гүйцээх, ашиглах үйлдэл” хэмээн тун оновчтой тодорхойлжээ.

¹Эхний төрлийн судалгааг “Олон нийтийн ойлголт, төсөөллийн судалгаа” гэж нэрлэх нь бий.

²С.Шагж. Монгол үсгийн дүрмийн толь бичиг.6 дахь тал

³Я.Цэвэл. Монгол хэлний товч тайлбар толь. 16 дахь тал

⁴Транспэрэнси интернэшнл. Дэлхий нийтийн авлигын тайлан. 27 дахь тал

Өнөөгийн Монгол Улсын хуулинд corruption хэмээх англи үгтэй дүйцүүлэн хэрэглэж буй “авлига” хэмээх ойлголт англи хэлний “bribe” [хээл хахууль] гэсэнтэй ижил явцуу утгатайгаар тэмдэглэж, хэрэглэж байгаа нь монгол хэлний тайлбар толь болон өдөр тутмын хэрэглээнээс ч харагддаг. “Corruption” хэмээх ойлголт хахууль өгөх, авахыг илэрхийлсэн явцуу утгатай ойлголт боловч үүнээс илүү өргөн утгатай, зохистой оноолт нь ялзрал, завхрал гажуудал болохыг энэ чиглэлийн судлаачид⁵ тэмдэглэсэн байдаг. Харин өндөр түвшний авлига [grand corruption] хэмээх ойлголтын талаар Монгол хэлэнд нэг мөр болгон дүйцүүлсэн нэр томьёо байхгүй. Уг ойлголтыг улс орон бүрт харилцан адилгүй нэрлэж, ойлгож байна. Тухайлбал, орос хэлэнд “өндөр түвшний авлига” гэхийг зөвхөн шүүх болон засгийн газрын өндөр албан тушаалтнуудад хамааруулж ойлгодог. Харин хятадад авлигын их бага хэмжээнээс үл хамааран бүгдийг “авлига” хэмээн нэрлэдэг ажээ. Нэр томьёоны хувьд “их авлига”, “том авлига”, “өндөр түвшний авлига”, “дээд түвшний авлига” “үлэмж хэмжээний авлига”, “үлэг авлига” хэмээн янз бүрээр нэрлэж болох ч Монгол Улсад энэ түвшинд үйлдэгдэж буй авлигын талаар судалгаа, мэдээлэл байдаггүй байна. Үүнийг зарим судалгааны байгууллага⁶ нэгд энэ сэдэв, чиглэлээр мэдээлэл цуглуулахад хүндрэлтэй, хоёрт Монгол хэлэнд уг ойлголттой дүйх үг хэллэг байхгүй хэмээн тэмдэглэжээ.

Монголд хийгдсэн олон тооны судалгаа авилгад хандаж буй иргэд, олон нийтийн төсөөлөл хандлагыг судлахад чиглэсэн ба энэ хүрээнд өндөр түвшний авлигын асуудал дурдагдаж ирсэн⁷ боловч нарийвчлан судлаагүй.

Иймд МУИС-ийн Улс төр судлалын тэнхим, Социологи, нийгмийн ажлын тэнхим хамтран УИХ-ын Үндэсний аюулгүй байдлын байнгын хороо, Авлигатай тэмцэх газар, АНУ-ын Азийн

⁵Социологийн академи төв. НҮБХХ, Эрүүл мэндийн салбар дахь авлига ба шударга ёсны өнөөгийн байдал. УБ.2007. 60 дахь тал

⁶Сант марал төв. АНУ-ын Азийн сан. Авилгалын талаарх олон нийтийн ойлголт, мэдлэг тогтоох судалгаа. 2013 оны 03 сар. 11 дэх тал.

⁷ТЗУХИ-ийн судалгааны баг. Авилгын индексийн судалгаа 1995, 1997., МУИС-Социологийн Академи төв, Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэнд хийсэн мониторингийн судалгаа 2004, АНУ-ын Азийн сан, Сант Марал төв. Авилгалын талаарх олон нийтийн ойлголт, мэдлэг тогтоох судалгаа, 2006, 2012-2014

сан туслалцаатайгаар дээрх асуудлыг тусгайлан судалж үзлээ. Тус судалгааны хүрээнд уг асуудлаар мэргэшсэн, өмнө нь ажиллаж байсан туршлагатай, одоо ажиллаж байгаа, судалгаа шинжилгээ хийдэг, эрдэмтэн судлаач шинжээчдийн санал бодлыг харьцуулсны үндсэнд өндөр түвшний авилгын орчин, ойлголт төсөөлөл, тархалт, шалтгаан үр дагавар, хор хөнөөлийг харьцуулан судалсан.

Энэхүү судалгаа нь дараах онцлогуудыг тусгаснаараа шинэлэг бөгөөд ач холбогдолтой юм. Үүнд: 1. Өндөр түвшний авлига ба үндэсний аюулгүй байдлын асуудал, тэдгээрийн харилцан хамаарлыг тусгайлан авч үзсэн. 2. Төрийн болон төрийн бус иргэний нийгмийн байгууллага, олон улсын байгууллагад ажиллаж буй шинжээчид, эрдэмтэн судлаачдын санал бодлыг харьцуулан судалсан. 3. Нийгмийн судалгааны чанарын хандлагаар авлигын шалтгаан нөхцлийг авч үзэж тайлбарласан болно.

1.2 СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Уг судалгаагаар өнөөгийн Монгол дахь авлигын шинжээчид, практикт ажиллаж буй хүмүүс өндөр түвшний авлигын цар хүрээ, төрөл хэлбэр, үр дагаварыг хэрхэн үнэлж дүгнэж байгааг тодруулах, өндөр түвшний авлигатай хэрхэн тэмцэх талаар тодруулахыг зорьсон болно.

1.3 СУДАЛГААНЫ АСУУЛТЫН ЧИГЛЭЛ, БҮТЭЦ

Ярилцлагын сэдэв, чиглэл	Нарийвчилсан асуултууд
Хувийн мэдээлэл	Оролцогчийн: - нас - хүйс, - боловсрол, - мэргэжил, - ажлын туршлага, ажилласан жил
Үндэсний аюулгүй байдлын тухай	<ul style="list-style-type: none"> • Үндэсний аюулгүй байдлыг хэрхэн үздэг вэ? • Монгол Улсын үндэсний аюулгүй байдалд нөлөөлөх бодит аюул заналхийлэл таны бодлоор чухам юу вэ?/нэрлэнэ үү/ • Авлига хэмээх үзэгдэл үндэсний аюулгүй байдалд хэр зэрэг нөлөө үзүүлэх вэ, санал бодлоо хуваалцана уу?
Өндөр түвшний авлига(Grand corruption)-ын талаарх ойлголт?	<ul style="list-style-type: none"> • Авлига ба өндөр түвшний авлигын ялгаа юу вэ? • Өндөр түвшний авлига гэдэг ойлголтын доор чухам юуг ойлгож байна вэ?

“АВЛИГА ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛД НӨЛӨӨЛӨХ НЬ”

<p>Өндөр түвшний авлигын төрөл хэлбэр юу вэ?</p>	<ul style="list-style-type: none"> • Өндөр түвшний авлига хаана/ямар байгууллагад/ үйлдэгдэж байна вэ? • Өндөр түвшний авлигыг хэн/ямар албан тушаалтан/ үйлдэж байна вэ?, • Энэ төрлийн авлига чухам ямар хэлбэр, хэмжээтэй байдаг вэ? • Монголд өндөр түвшний авлига бий юу? • Ихээхэн тархсан, үйлдэгдэж буй хэлбэрүүдээс 3 хүртэлх өндөр түвшний авлигыг нэрлэнэ үү. • Өндөр түвшний авлига үйлдэгдэх шалтгаан, нөхцөл юу вэ?
<p>Өндөр түвшний авлигын хор хөнөөл, үр дагаварын талаар өөрийн саналаа хуваалцана уу?</p>	<ul style="list-style-type: none"> • Өндөр түвшний авлига улс орны болон үндэсний аюулгүй байдалд хэрхэн нөлөөлж болох талаар өөрийн санал бодлоо хуваалцана уу? • Өндөр түвшний авлигын хохирогч хэн байдаг вэ? • Өндөр түвшний авлигын нийгмийн хор хөнөөл/төр засаг, гэр бүл, хувь хүн гм/-ийн талаар ярина уу?
<p>Өндөр түвшний авлигатай хэрхэн тэмцэх вэ?</p>	<ul style="list-style-type: none"> • Өндөр түвшний авлигыг бууруулах, тэмцэх талаар улс орнуудад ямар туршлага байдаг вэ? • Өндөр түвшний авлигатай тэмцэх боломжтой эсэх, • Монгол Улсад хэрхэн тэмцэх ёстой вэ?, • Ямар байгууллага/ эсвэл хувь хүн тэмцэх ёстой вэ?, таны бодлоор тэмцэж чадаж байна уу? • Өндөр түвшний авлигатай үр дүнтэй тэмцэхэд юу саад болж байна вэ? • Өндөр түвшний авлига авсан албан тушаалтанд хариуцлага хүлээлгэж чадаж байна уу, чадахгүй бол яагаад? • Өндөр түвшний авлигатай тэмцэх тогтолцоог бий болгох шаардлагатай юу?, хэрхэн бий болгох вэ?
<p>Нэмэлт мэдээлэл</p>	<ul style="list-style-type: none"> • Судлаач жишээ болон нотолгоог асууж лавлах

1.4 СУДАЛГААНЫ МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХАД АНХААРАХ АСУУДЛУУД

Судалгааны мэдээлэл цуглуулж буй судлаачдад зориулан “Үндэсний аюулгүй байдал ба өндөр түвшний авлига” сэдэвт судалгааг хэрхэн хийх тухай аргачилсан зөвлөмж боловсруулсан ба судлаачийн зүгээс анхаарах ёс зүйн асуудлуудыг тусгасан.

СУДЛААЧИЙН ЗҮГЭЭС АНХААРВАЛ ЗОХИХ ЗҮЙЛС.

1. Хүний эрхийг дээдлэх зарчмыг судалгаанд баримтлах

Олон улсын гэрээ конвенцид тусгагдсан заалтууд болон бусад хууль тогтоомж, судалгааны ёс зүйн кодекст тусгасан хүний эрхийг дээдлэх зарчмыг судалгаа хийх явцдаа баримтлан ажиллах. Үүнд: нас, хүйс, үндэс угсаа, шашин шүтлэг, бэлгийн чиг баримжаа, гэр бүлийн байдал, нийгмийн байдлаар ялгаварлахгүй байх, хувь хүний ялгаатай байдлыг хүндэтгэх гм.

2. Респондентод хувийн үзэл бодлоо тулгахаас зайлсхийх

“Экспертүүд”, судлаачид, төрийн болон төрийн бус, олон улсын байгууллагын хүмүүс мэргэжилтнүүдтэй ярилцах явцдаа хувь хүний үзэл бодлоо илэрхийлэх эрхийг дээдлэхийн зэрэгцээ судалгааны асуулттай холбоотой үнэн зөв мэдээлэл, тайлбар өгөхөд анхаарна.

3. Мэдээллийн нууцлалыг чанд хадгалах, хамгаалах

Хувь хүний нууцын тухай хуулийн 2-р бүлгийн 5-р зүйлийн 4-т дурдсан “Хувь хүний нууцыг хуулийн дагуу болон итгэмжлэлээр олж мэдсэн этгээд бусдад задруулахыг хориглоно.” хэмээх заалтын дагуу мэдээллийн нууцлалыг чандлан хадгалах үүргийг судлаач биечлэн хүлээнэ.

4. Шаардлагатай мэдээллийг баталгаажуулах, баримтжуулах

Хэрэв шаардлагатай бол судлаач тухайн мэдээллийг баталгаажуулах ба баримтжуулалтын аливаа төрлийг ашиглахдаа судалгаанд оролцогчоос(судлаач, эксперт, ажилтан гм) зөвшөөрөл авсан байвал зохино. Мэдээллийг баталгаажуулах дараах төрлүүд байна.

- Тэмдэглэл хөтлөх
- Аудио бичлэг хийх
- Видео бичлэг хийх
- Фото зураг авах

5. Судалгааны ёс зүйн зарчмыг мөрдөх

Судлаач экспертийн судалгааг /Олон улсын ёс зүйн кодекс/ ёс зүйн дүрэм, журмын дагуу хийж гүйцэтгэхэд анхаарна. Энэхүү экспертийн судалгаа нь өндөр түвшний авлига ба үндэсний аюулгүй байдлын талаарх шинжээчдийн санал бодол, хандлагыг тодорхойлж, үндэсний түвшинд ашиглагдах мэдээллийн эх сурвалж бий болгох тул, энэ талаар тайлбарлан таниулах хэрэгтэй.

II. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, АРГАЧЛАЛ

2.1 СУДАЛГААНЫ ХАМРАХ ХҮРЭЭ, ТҮҮВЭРЛЭЛТ

№	Судалгаанд оролцох байгууллагууд	Судалгаанд хамруулахаар төлөвлөсөн тоо	Судалгаанд оролцсон экспертийн тоо
1	Төрийн байгууллага	15	6
1.1	УИХ-ын гишүүд	9	-
1.2	Шүүх, прокурор	3	3
1.3	НИТХ	3	3
2	Төрийн бус байгууллага	5	6
2.1	Зориг сан	1	2
2.2	Иргэдийн Альянс төв	1	-
2.3	Глоб Интернэшнл	1	-
2.4	Сонгогчдын боловсрол төв	1	1
2.5	Нээлттэй нийгэм форум	1	1
2.6	Судалгааны байгууллага	1	2
3	Олон улсын байгууллага	10	10
3.1	Нэгдсэн Үндэсний Байгууллага	1	1
3.2	Трансперенси интернэшнл Монгол	1	1
3.3	Эмнести интернэшнл	1	-
3.4	USAID	1	2
3.5	Дэлхийн банк	1	1
3.6	Азийн хөгжлийн банк	1	1

3.7	JICA	1	1
3.8	KOICA	1	1
3.9	TIKA	1	1
3.10	GIZ	1	1
4	Элчин сайдын яам	5	2
4.1	АНУ	1	1
4.2	ИХ БРИТАНИ	1	1
4.3	БНХАУ	1	-
4.4	ГЕРМАН	1	-
4.5	ЯПОН	1	-
5	Судлаач, эксперт	5	6
5.1	Судлаач	3	3
5.2	Багш, эрдэмтэн	2	3
Нийт		40	30

2.2 СУДАЛГААНЫ АРГА, АРГАЧЛАЛ

Монгол дахь авлига ба өндөр түвшний авлигын нөхцөл байдал, шалтгаан үр дагавар, тэмцэх арга замыг судлахдаа судалгааны мэдээлэл цуглуулах экспертийн сурвалжлагын аргыг ашигласан болно. Сурвалжлага нь авлигын талаарх ерөнхий ойлголт, төсөөллийг гаргахаас гадна тухайн үзэгдэлд нөлөөлж буй хүчин зүйлс, шалтгаан, мөн чанарын тайлбарыг бидэнд олгож буйгаараа тоон судалгааны үр дүнгээс давуу талтай юм.

Экспертийн сурвалжлага нь дараах хэдэн онцлогтой.

- Асуудлыг дэлгэрэнгүй судлах боломж олгохын дээр нарийвчилсан мэдээлэл цугладаг.
- Судалгаанд оролцогчийн хувийн санал бодлыг нээн илрүүлэх, шалтгаан нөхцлийг харьцуулах боломжтой.
- Ярвигтай асуудлыг судлахад илүү тохиромжтой.
- Цаг хугацаа ихээхэн ордог боловч дэлгэрэнгүй мэдээлэл цуглардаг.

Судалгаанд оролцсон шинжээчдийн нийгэм, хүн ам зүйн ерөнхий байдлыг авч үзвэл,

Насны байдал	Нийгэм хүн ам зүйн байдал	
	Тоо-30	Хувь-100
30 хүртэлх	4	13.3%
31-40	3	10.0%
41-50	13	43.3%
50-с дээш	10	33.3%
Хүйсийн байдал	Тоо-30	Хувь-100
Эрэгтэй	16	53.3%
Эмэгтэй	14	46.7%
Боловсролын байдал	Тоо-30	Хувь-100
Дээд	30	100%
Үүнээс:		
Бакалавр	6	20.0%
Магистр	8	26.7%
Доктор	16	53.3%
Мэргэжлийн чиглэл	Тоо-30	Хувь-100
Бизнес, эдийн засагч	6	20.0%
Эрүүл мэндийн	3	10.0%
Нийгэм, эдийн засаг	4	13.3%
Нийгэм судлал	11	36.7%
Олон улсын харилцаа	1	3.3%
Орчуулагч	1	3.3%
Техник, инженер	1	3.3%
Улс төр, хууль	3	10.0%
Ажиллаж буй байгууллага	Тоо-30	Хувь-100
Төрийн байгууллага	5	16.7%
Төрийн бус байгууллага	6	20.0%
Олон улсын байгууллага	7	23.3%
Элчин сайдын яамд	2	6.6%
Судлаач, эрдэмтэд	10	33.3%

2.3 СУДАЛГААНЫ ХЯЗГААРЛАГДМАЛ ТАЛ

Уг судалгааны үр дүнг авлигатай тэмцэх ерөнхий чиг, хандлага хэмээн үзэж болох ч эцсийн бөгөөд цорын ганц арга зам хэмээн судалгааны баг үзэхгүй байна.

Учир нь улс орон бүрт уг үзэгдлийг харилцан адилгүй ойлгож, ханддаг байдал нь авлигатай тэмцэх арга замыг ч олон талтай, ярвигтай асуудал болохыг илэрхийлдэг. Өнөөдөр авилга, гажуудал байна гэхээсээ илүү байгаа хэмжээ түвшнийг нь бодитой тогтоож, түүний нийгэм, улс төр, эдийн засгийн харилцан нөлөөллийг илрүүлэх, багасгаж болох арга механизмыг ойрын болон хэтийн төлөвтэй нь холбон маш тодорхой дэвшүүлэн тавьж, түүнийг бодлогод шууд тусган хэрэгжүүлэх явдал тулгамдаад байгаа билээ. Судалгааны багийн зүгээс уг судалгааны үр дүнг хэрэглэхдээ дараах хэдэн зүйлийг анхаарахыг санал болгож байна. Үүнд:

- хязгаарлагдмал тоотой түүвэрлэлт
- тодорхой хүрээнд гаргасан ярилцлагын чиглэлүүд
- сайн дурын оролцоонд тулгуурласан
- авлигын асуудлаар мэргэшсэн цөөн бүлэг хүмүүс
- оролцогчид өөрсдийн санал, төсөөллөөр асуултад хариулсан зэрэг нь уг экспертийн судалгааны хязгаарлагдмал тал болно.

III. СУДАЛГААНЫ ҮНДСЭН ҮР ДҮН

3.1 ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ БА АВЛИГЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Сүүлийн жилүүдэд авлигын асуудлаар төр засаг, төрийн бус байгууллагууд, эрдэмтэн судлаачид их ярьж, бичиж буй боловч түүнийг бий болгогч, түүнд нөлөөлөгч хүчин зүйлсийг тодруулах, урьдчилан сэргийлэх тал дээр ахиц дэвшил төдийлөн гарахгүй байна. Судалгааны байгууллагуудын хийсэн тоон болон чанарын судалгааны үр дүнгүүдээс⁸ харахад судалгаанд оролцогчид Монголд хамгийн ихээр тулгарч буй асуудлын эхний тавд авлигын асуудал тогтмол байраа хадгалсаар ирсэн нь үүнийг илтгэнэ. Нэг талаас авлигын талаарх иргэдийн мэдлэг, мэдээлэл хомс, нөгөө талаас авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажил хангалтгүй хийгдэж байгаа нь үүнд нөлөөлж байна. Энэ байдал ийм маягаар үргэлжилбэл нийгэмд авлига нь байх ёстой үзэгдэл мэт ойлголтыг нийтэд төрүүлж, түүнийг таслан зогсоох хүсэл сонирхолгүй болох, нийгмээрээ авлигад идэгдэх, цаашлаад үндэсний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх аюул нүүрлэх эрсдэлтэйг энэ чиглэлээр судалгаа хийдэг байгууллагууд, олон улсын шинжээч, судлаачид дүгнэн хэлж байна.

Иймээс авлигыг бууруулах, түүний үндэс суурийг таслахад чиглэсэн шат дараалсан олон талт бодлого, арга хэмжээг цаг алдалгүй авч хэрэгжүүлэх нь чухал байна. Байгалийн баялагт суурилсан бодлогыг ирээдүйн хөгжлийн суурь гэж үзэж буй манай орны хувьд гадаадын хөрөнгө оруулалт, уул уурхайд ноёлох гэсэн эдийн засгийн бодлого, тэдгээрийг дагалдсан мөнгөний их урсгалыг зөв залж, залуурдах явдал хамгаас чухал байна. Үүний нэг чухал хөшүүрэг бол уул уурхайн ил тод байдлыг сайжруулах, энэ салбарт

⁸“Авилгын талаарх олон нийтийн ойлголт, мэдлэг тогтоох судалгаа”. Сант Марал судалгааны төв. Монгол улсад засаглал, ил тод байдлыг дэмжих хөтөлбөр. УБ., 2013 “Хүмүүс, нийгэм, аж амьдрал” сэдэвт цуврал суурь судалгаа. (2011-2013). Нийгмийн Ардчиллын хүрээлэн.УБ, 2013. “Бизнес эрхлэлтийн орчин дахь авлигын нөхцөл байдал” Монгол улсад засаглал, ил тод байдлыг дэмжих хөтөлбөр. УБ., 2013. “Өндөр түвшний авлига ба Үндэсний аюулгүй байдал” сэдэвт судалгаа. МУИС. Улс төр судлалын тэнхим, Социологи,Нийгмийн ажлын тэнхим. УБ., 2014

орж буй хөрөнгө оруулалт, ашиглалт олборлолтын зөвшөөрөл зэрэгт хяналт тавьж ажиллах, иргэний нийгмийн оролцоог нэмэгдүүлэх, хөндлөнгийн хяналтыг сайжруулах явдал юм. Стратегийн томоохон орд газруудыг гадаадын хөрөнгө оруулалтаар эдийн засгийн эргэлтэд оруулж байгаа өнөө үед үндэсний аюулгүй байдлын асуудлыг ямагт бодолцож, үндэсний аюулгүй байдлаа бататган бэхжүүлэхэд чиглэсэн давхар бодлогууд хэрэгжиж байх учиртай. Ингэж эс чадвал үндэсний аюулгүй байдал алдагдахад хүрнэ.

Үндэсний аюулгүй байдлын талаарх шинжээчдийн санал бодол

Үндэсний аюулгүй байдлыг хангаж, хамгаалахад олон хүчин зүйлс чухал. Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд *Монгол Улсын үндэсний аюулгүй байдал гэж Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад, дотоод таатай нөхцөл бүрдсэн байхыг хэлнэ. Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхолд Монголын ард түмэн, соёл иргэншил оршин тогтнох, Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэр, хил хязгаарын халдашгүй байдал болон бүрэн бүтэн байдал, үндэсний эв нэгдэл, үндсэн хуульт байгууллын аюулгүй байдал, эдийн засгийн бие даасан байдал, экологийн тэнцвэрт хөгжил багтана*⁹ гэж заасан байдаг. Эндээс үзвэл үндэсний аюулгүй байдал нь тухайн улс орны бие даан оршин тогтнох, хараат бус тусгаар байх, хүн ам нь аюулгүй байдлын бүх үзүүлэлтүүдээр хангагдсан байх зэрэг маш олон хүчин зүйлсийг хамааруулан ойлгодог цогц ойлголт юм. Үүнийг Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 1.2.3-т заахдаа Монгол Улсын,

- Оршин тогтнохуйн аюулгүй байдал,
- Эдийн засгийн аюулгүй байдал,
- Дотоод аюулгүй байдал,
- Хүний аюулгүй байдал,
- Хүрээлэн байгаа орчны аюулгүй байдал,
- Мэдээллийн аюулгүй байдал харилцан уялдаатай хангагдсанаар үндэсний аюулгүй байдал баталгаажна¹⁰ гэснээс үзэхэд илэрхий байна.

⁹Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. УБ., 2010

¹⁰Монгол улсын Үндэсний Аюулгүй байдлын үзэл баримтлал. УБ., 2010

Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын дээрх заалтыг иш үндэс болгон дээрх 6 чиглэлийн аюулгүй байдлын баталгааг бий болгосноор үндэсний аюулгүй байдал цогц байдлаар хангагдана гэж үзнэ.

Бодит амьдралд эдгээр аюулгүй байдлууд хангагдаж чадаж байна уу? гэдэг асуулт зүй ёсоор тавигдаж байна. Аюулгүй байдлын баталгааг бий болгоно гэдэг нь тийм ч амар зүйл биш. Оновчтой, залгамж чанартай, хүний төлөө, нийгмийн төлөө гэсэн бодлого, үйл ажиллагааг төрөөс, улс төрчдөөс шаардаж байдаг. Юуны өмнө ард иргэдийн амьжиргааг дээшлүүлэх, орлогыг нэмэгдүүлэх, ажилгүйдлийг бууруулах зэргээр нийгэм эдийн засгийн баталгааг бий болгохоос эхлэх учиртай. Хөгжингүй улс орнуудад иргэдийнхээ ахуй амьжиргааг чинээлэг хангалуун амьдрах түвшинд хүргэх замаар нийгмийн хөгжлийн эдийн засгийн баталгааг нь хангаж, бие даасан байдлыг бий болгосноор улс орныхоо аюулгүй байдлын баталгаагаа бий болгосон байдаг.

Харин Монгол улсын нийгэм, эдийн засгийн хөгжил, ард иргэдийн ахуй амьжиргааны өнөөгийн дүр зураг үндэсний аюулгүй байдлыг баталгаажуулах хэмжээнд хүрсэн гэхэд эргэлзээтэй. Наад зах нь иргэдийнхээ эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдлыг хангаж чадаж байна уу? Ард иргэдээ дотоодын чанартай, баталгаатай хүнсний бүтээгдэхүүнээр хангах, гадаадаас импортоор оруулж ирж буй хүнсний бүтээгдэхүүнд тавих хяналт чанарын шаардлага хангаж байна уу? гэх зэрэг олон асуултад итгэл төгс, бүрэн дүүрэн эерэг хариултыг өгч чадахгүй байна. Энэ мэтчилэн үндэсний аюулгүй өнөөгийн нөхцөл байдлын талаар тоймтой судалгаанууд хийх шаардлага зүй ёсоор урган гарч байгаа билээ. “Үндэсний аюулгүй байдал ба өндөр түвшний авлига” сэдэвт шинжээчдийн дунд хийсэн бидний энэхүү судалгаа ч Монгол дахь авлигын талаарх иргэдийн санал бодол, тэр дундаа өндөрт түвшний авлига үндэсний аюулгүй байдалд хэрхэн нөлөөлдөг талаарх ойлголт, төсөөллийг тодорхойлоход чиглэсэн болно.

Шинжээчдийн дунд явуулсан энэхүү судалгаагаар¹¹ үндэсний аюулгүй байдал гэдгийг дараах байдлаар ойлгож, томьёолсон нь нийтлэг байна. Үүнд,

¹¹Өндөр түвшний авлига ба үндэсний аюулгүй байдал” сэдэвт социологийн судалгаа. МУИС. УБ., 2014

1. *Үндэсний аюулгүй байдал гэдэг нь оршин тогтнох цогц ойлголт, эдийн засгийн аюулгүй байдал, банк санхүүгийн аюулгүй байдал, соёл иргэншлийн аюулгүй байдал юм.*
2. *Газар нутаг, үндэс угсаа, соёл заншил, төрөлх хэл зэрэг өөрт хамаарах зүйлсээ бүрэн бүтэн хадгалж үлдэх тухай ойлголт юм.*
3. *Монгол улсын иргэний эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах болон улсын өмч хөрөнгө, газар нутгийн халдашгүй дархан байдал юм.*
4. *Улс орны тусгаар тогтнол, хэл соёл, зан заншил, газар нутгийн бүрэн бүтэн байдал зэргийг багтаасан ойлголт юм.*
5. *Хил хязгаарын бүрэн бүтэн байдал, хүн амын эрүүл мэндийн чанартай үйлчилгээ, хоол хүнсний хангамж, түүний баталгаат аюулгүй байдал, эдийн засгийн хүчин чадал, гадаад дотоодын худалдааны найдвартай байдал гэх мэт олон асуудлыг үндэсний аюулгүй байдалд оруулж ойлгоно.*
6. *Үндэсний аюулгүй байдал гэдэг нь Монгол улсын бүрэн эрхт байдал, хил хязгаарын аюулгүй байдал, ард түмний эв нэгдэл, тусгаар тогтнол, түүх соёл, ёс заншил язгуур эрх ашгийг хэлнэ.*
7. *Үндэсний аюулгүй байдал гэдэг нь тухайн улс орон өөрөө бие даан асуудлаа шийдэхийг хэлнэ.*
8. *Үндэсний аюулгүй байдал гэж Монгол Улсын эрх ашиг хөндөгдөхийг хэлнэ гэж үзэж байгааг анхаарууштай юм.*

Дүнгэвээс, судалгаанд оролцсон экспертүүд үндэсний аюулгүй байдлыг Монгол улсын хил хязгаар, газар нутгийн бүрэн бүтэн байдал, ард иргэдийн айх аюулгүй тайван амьдрал, эв нэгдэл, улс орны эдийн засгийн бие даасан байдал, тусгаар тогтнол, түүх, хэл соёл, ёс заншлаа хадгалах язгуур эрх ашиг, үнэт зүйлстэй холбон тайлбарлаж байгаа нь Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын утга агуулгатай нийцэж байна.

Үндэсний аюулгүй байдалд тулгарч буй асуудал, бэрхшээлүүд.

Шинжээч, судлаачдын дунд явуулсан судалгаагаар үндэсний аюулгүй байдлын өнөөгийн нөхцөл байдалд өгөх үнэлгээнд

судалгаанд оролцогчид нэлээд гутранги хандсан дүр зураг харагдав. Тухайлбал, Монгол улсын үндэсний аюулгүй байдалд заналхийлж, сөрөг нөлөө үзүүлж буй хүчин зүйлс юу вэ?¹² гэсэн асуултад судалгаанд оролцогчдын хариултыг дараах байдлаар багцлан харуулья. Үүнд:

Үндэсний аюулгүй байдлын төрөл	Үндэсний аюулгүй байдалд тулгарч буй асуудал бэрхшээл
Оршин тогтнохуйн аюулгүй байдал	<ul style="list-style-type: none"> • Монгол улсын газар нутагт заналхийлэх явдал уул уурхайгаар дамжин нэвтэрч байна. • Монгол үндэстний цус ихээр холилдож байна. • Гадаадын иргэд Монголын улс төрчид, эрх мэдэлтэй хүмүүсийг хахуульдан том том газрыг өөртөө авч ашиглаж байна. • Гадаадын иргэдэд зориулж ашигтай байхаар улс төрчид хууль гаргаж байна Монголчууд эв нэгдэлгүй байгаа явдал нь бусдад таатай нөхцлийг бүрдүүлж өгч байна. • Гадаадынхан Монгол улсад ихээр суурьшиж байна
Эдийн засгийн аюулгүй байдал	<ul style="list-style-type: none"> • Эдийн засгийн хувьд гадны улс орнуудаас бүрэн хамааралтай болж байна. • Санхүү эдийн засгийн хараат бус байдал алдагдаж байна. • Эдийн засаг 2 хөршийн хараат болчихсон. • Эдийн засаг хөгжөөгүй, хүн ам цөөн байна. • Эдийн засгийн өндөр ач холбогдолтой төсөл, бодлого цөөхөн, хэдхэн хүмүүсийн гарт төвлөрсөн байна. • Хүн амын амьжиргаа тааруу, ядуу байна.
Дотоод аюулгүй байдал	<ul style="list-style-type: none"> • Хэдхэн бүлэг хүмүүсийн өөрсдийн эрх ашгийг бодсон улс төрийн явцуу бодлого үйлчилж байна. • Эв нэгдэл задрах аюултай, хүмүүс үзэл бодлоороо маш их талцаж байна. • Архидан согтуурал, ажилгүйдэл, хээл хахууль их байна. • Монголын хүн ам эрлийзжиж буй үйл явц түгээмэл байна. • Үндэсний онцлогтой үйлдвэрлэл, технологи байхгүй болсон. • Монгол хэлээ ашиглахгүй янз бүрийн гадаад үг хэллэг оруулан хэрэглэж байна.

¹²“Өндөр түвшний авлига ба үндэсний аюулгүй байдал” сэдэвт социологийн судалгаа. МУИС. УБ., 2014

Хүний аюулгүй байдал	<ul style="list-style-type: none"> • Хүнсний баталгаат болон аюулгүй байдал алдагдсан. • Импортоор орж ирж буй хүнсний бүтээгдэхүүн ямар нэг халдварт өвчин тараах болон хүн амыг хордуулах түвшинд байнаХилээр орж ирж байгаа хүнсний бүтээгдэхүүнд хяналт тавьж чадахгүй байна.Өнөөдөр ард иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьд явах язгуур эрх ашиг хангагдаагүй байна.
Хүрээлэн буй орчны аюулгүй байдал	<ul style="list-style-type: none"> • Байгаль орчноо маш их сүйтгэж байна. • Уул уурхайн компаниуд нөхөн сэргээлтээ тааруу хийж байна. • Уул уурхайгаас болж хөрс, гол горхи ширгэж, бохирдож байна. • Утаа, агаарын бохирдол маш их байна.
Мэдээллийн аюулгүй байдал	<ul style="list-style-type: none"> • Гадны янз бүрийн байгууллагууд судалгаа шинжилгээ хийчихээд мэдээллээ урвуугаар буюу Монгол улсын нэр хүндийг олон улсын тавцан дээр унагах гэх мэтээр ашиглах боломжтой болоод байна. • Ард иргэдэдийг зөв мэдээллээр хангахгүй байна.

Судалгаанд хамрагдсан шинжээчид Монгол улсын үндэсний аюулгүй байдал түүнд тулгарч буй бэрхшээлийн талаар дээрх байдлаар үзэл бодлоо илэрхийлж сөрөг үнэлгээ өгсөн байгааг харж болно. Улс орны эдийн засаг дахь мөнгөний тэлэлт нь нийгмийн олон салбарт хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх боломжийг нээж буй боловч зөв оновчтой, урт хугацааны бодлоггүйгээс хүсэн хүлээж буй үр дүнд хүрэхгүй байгаа нь дээрх үнэлгээг өгөхөд хүргэжээ гэж дүгнэж болохоор байгаа юм.

Мөн шинжээчид Монгол улсын үндэсний аюулгүй байдлыг бүрэлдүүлж буй оршин тогтнохуйн, эдийн засгийн, дотоодын, хүний, хүрээлэн байгаа орчны болон мэдээллийн аюулгүй байдал харилцан уялдаатай хангагдаж чадахгүй байгааг онцгойлон анхааруулахын зэрэгцээ үндэсний аюулгүй байдалд тулгарч буй асуудал бэрхшээлүүд хийгээд шалтгааныг нийгэм эдийн засгийн зөв бодлого, үйл ажиллагаа явуулахгүй байгаатай холбон ойлгож байна. Мөн үүний цаана авлига, хээл хахуулийн шинжтэй том асуудлууд ч нуугдаж байж болзошгүй талаар ч тэд санал бодлоо илэрхийлж байгаа юм.

Үндэсний аюулгүй байдалд авлигын үзүүлэх сөрөг нөлөөлөл.

Дэлхийн томоохон судалгааны байгууллагууд, судлаачид авлига газар авсан улс орнуудын үндэсний аюулгүй байдал хэврэг байдаг талаар дүгнэсэн байдаг¹³. Дэлхийн цөөнгүй оронд ийм нөхцөл байдал бий болсоныг судлаад үүний цаана нийгмийн шударга бус харилцаа, түүнийг дагаж гарч ирдэг сөрөг үзэгдлүүд газар авсан байдгийг тогтоожээ.

Монгол улсад ч нөхцөл байдал амаргүй байна. Их дээд сургуулиуд, судалгааны төв, хүрээлэнгүүдээс явуулсан судалгаануудаас үзэхэд авлига нийгмийн бодит үзэгдэл болсон гэдэгтэй иргэд санал нэгдэж, эвлэрсэн байгаа талаар тайландаа дурьдсан байна. Тухайлбал, зарим нэг судалгааны үр дүнгээс үзвэл,

*Авлига нийгмийн нийтлэг үзэгдэл болсон гэдэгтэй та санал нийж байна уу?*¹⁴

	2006 он	2013 он
Санал нийлнэ	79.1%	67.6%
Тодорхой хэмжээгээр санал нийлнэ	13.3%	21.2%
Ер нь санал нийлнэ	4.8%	6.5%
Огт санал нийлэхгүй	2.8%	4.7%

Авлига нийгмийн бүх хүрээг хамран тэлэхийн хэрээр нийгэмд үзүүлэх сөрөг нөлөө нь улам бүр нэмэгдэж, цаашлаад үндэсний аюулгүй байдлыг алдагдуулахад хүрч болзошгүй талаар шинжээчид дүгнэн ярьж байна. Нэн ялангуяа нийгэмд учруулах хохирол, сөрөг үр нөлөөгөөрөө үндэсний аюулгүй байдлыг алдагдуулахад хүргэдэг өндөр түвшний (grand corruption) авлигын асуудал сүүлийн үед их яригдах боллоо. “Үндэсний аюулгүй байдал ба өндөр түвшний авлига” сэдэвт шинжээчдийн дунд явуулсан судалгаанд оролцсон ардчилал ил тод байдлыг дэмжих чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагад ажиллдаг шинжээчийн тэмдэглэснээр:

¹³Транспэрэнси интернэшнл олон улсын байгууллагын цуврал судалгаа.

¹⁴“Авилгын талаарх олон нийтийн ойлголт, мэдлэг тогтоох судалгаа”. Сант Марал судалгааны төв. Монгол улсад засаглал, ил тод байдлыг дэмжих хөтөлбөр. УБ., 2013.

“Авлига нь ҮАБ-д маш их сөрөг нөлөөтэй. Жишээ нь: улс орны эдийн засагт чухал нөлөө үзүүлэх орд газруудын ашиглалт, үүнд холбогдох гэрээ хэлэлцээрүүд авлигад тодорхой хэмжээгээр автсан гэдгийг олон улсад мэдээлж байсан. Ингэснээр Монгол Улсын эдийн засгийн тулгуур асуудлуудад авлига сөргөөр нөлөөлж болохыг харуулсан¹⁵”.

Авлига нийгмийн бодит үзэгдэл болж ард иргэдийн амьжиргаа, цаашлаад улс төр хийгээд төрийн бодлого, шийдвэрт сөрөг нөлөө үзүүлж байгаа талаар Дэлхийн банкны шинжээч онцгойлон анхааруулсан. Тэрээр:

“Авлига нь эдийн засгийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж байна. Өндөр түвшний хүрээнд авлига цэцэглэж байна. Гадаадын хөрөнгө оруулалт Монгол улсад ашигтай нь ашигтай гэхдээ тэдгээр хөрөнгө оруулалтын зарцуулалтыг төр ил тод биш далд явуулдаг учраас өөрөөр хэлбэл тодорхой бүлгийн эрх ашигт нийцүүлэн үйл ажиллагаа явуулж байгаа нь авлига цэцэглэх шалтгаан болж байна. Ер нь үндсэн хууль болон мөн намуудын хуулинд өөрчлөлт оруулах, сонгуулийн системд өөрчлөлт оруулах шаардлагатай. УИХ-д гарч ирсэн л бол энэ намын харъялалыг болилуулах хэрэгтэй. Тэгэхгүй бол тэд тодорхой нэг бүлэг болж тэр бүлгийн эрх ашгийн төлөө үйл ажиллагаа явуулж эхэлдэг. Тэр нь эдийн засагт сөргөөр нөлөөлдөг. Ядуурал буурахгүй байгаа гэр хороолол хумигдахгүй улам ихсэж байгаа нь авлига төр засагт байсаар байгаагийн шинж¹⁶”.

Сүүлийн жилүүдэд уул уурхайн салбарт гадаадын хөрөнгө оруулалт нэмэгдэж байгаатай холбогдон ашигт малтмалын лиценз олголт түүнийг дагасан нийгмийн хардалт, сэрдэлт улам бүр нэмэгдэж байгаа нь авлига нийгмийн мөн чанартай болж хувирах аюулын харангыг дэлдэж байна гэсэн дүгнэлтийг хийхэд хүргэж байгаа юм.

Тиймээс энэхүү судалгаанд Монгол дахь авлигын ерөнхий чиг хандлагыг тандахын зэрэгцээ өндөр түвшний (тус судалгаанд дээд түвшний гэж нэрлэсэн, англи хэлний “grand corruption”)

¹⁵“Өндөр түвшний авлига ба үндэсний аюулгүй байдал” сэдэвт социологийн судалгаа. МУИС. УБ., 2014

¹⁶“Өндөр түвшний авлига ба үндэсний аюулгүй байдал” сэдэвт социологийн судалгаа. МУИС. УБ., 2014

авлигын талаар тандах зорилгыг гол болгосон болно. Нэрлэж буй нэр томъёоны хувьд цаашид нэг мөр болгон ойлгох Монгол хэлний оновчтой үг хэллэгээр оноон нэрлэж хэвших шаардлага буй. Монгол хэл судлалын эрдэмтэд “үлэг авлига”, “үлэмж авлига”, “дээд түвшний авлига” гэх мэтээр олон янзаар утгыг нь дүйлгэн гаргаж ирж буй боловч аль нь яг оносон томъёолол болох талаар эцэслэн шийдвэрлэх тал дээр маргаантай байгааг энд онцлон тэмдэглэе.

Тиймээс энэхүү судалгаанд өмнө хийгдсэн судалгаануудад хэвшсэн байдлыг үндэс болгон мөн хэл шинжлэлийн эрдэмтэдийн санал болгож буй нэршлийн хувилбаруудыг харгалзан “grand corruption” гэдгийг өндөр түвшний авлига гэдгээр оноон нэрлэж хэрэглэлээ. Нөгөө талаар авлигын тухай ойлголт нь зөвхөн хээл хахуулиар хязгаарлагдахгүй илүү өргөн ойлголт учир судалгаанд дурьдагдсан авлигын өөр шинж чанар бүхий үг хэллэгийн тайлбарыг бий болгож байгааг цаашид анхаарах шаардлагатай болж байна.

Манай иргэд өндөр түвшний авлига гэдгийг “төрийн өндөр албан тушаалтнуудад холбоотой авлигын хэрэг”, “улс төрийн сонирхол бүхий авлигын хэрэг”, “дотоод, гадаадын том хэмжээний компаниуд холбогдсон авлигын хэрэг”¹⁷ гэсэн гурван утгаар ойлгож байна.

*Таны бодлоор өндөр түвшний авлига гэж юу вэ?*¹⁸

Хүснэгт. 1

2012 оны 11-р сар

Төрийн өндөр албан тушаалтнуудад холбоотой хэргүүд	21.3%
Улс төрийн сонирхол агуулсан хэргүүд	17.3%
Том хэмжээний дотоодын болон гадаадын компаниуд холбогдсон хэргүүд	11.8%
Улс орны хэмжээнд ихээхэн хохирол учруулж буй хэргүүд	9.9%
Хахуулын хэмжээ нь нилээд их хэргүүд	9.5%
Зохион байгуулалттай гэмт хэргийн шинжтэй хэргүүд	9.0%

¹⁷“Авилгын талаарх олон нийтийн ойлголт, мэдлэг тогтоох судалгаа”. Сант Марал судалгааны төв. Монгол улсад засаглал, ил тод байдлыг дэмжих хөтөлбөр. УБ., 2013.

¹⁸“Авилгын талаарх олон нийтийн ойлголт, мэдлэг тогтоох судалгаа”. Сант Марал судалгааны төв. Монгол улсад засаглал, ил тод байдлыг дэмжих хөтөлбөр. УБ., 2013.

Ер нь Монгол улсад авлига шийдвэр гаргах дээд түвшний өндөр албан тушаалтнуудын дунд их гардаг, гадаад улс оронтой харилцахдаа бүлэг хүмүүсийн эрх ашгийг дээгүүр тавьж ажиллах, өөрөөр хэлбэл улс орны эрх ашигт сөргөөр нөлөөлсөн шийдвэр гаргаж мөн асар их мөнгөнөөс болж цаашид гарах хор уршигийг зөв бодитой үнэлж чадахгүй байгаа нь асуудлыг улам бүр хүндрүүлж байна гэж дүгнэж болохоор байна.

3.2 АВЛИГА БА ӨНДӨР ТҮВШНИЙ АВЛИГА: ТӨРӨЛ ХЭЛБЭР, ҮР ДАГАВАР

Авлига, өндөр түвшний авлигын төрөл хэлбэр, үр дагаварын талаар судалгааны үр дүнд тулгуурлан өндөр түвшний авлигын талаарх ойлголтыг улс орны нийтлэг эрх ашиг, авлигын хэмжээ, байгууллага, албан тушаалтны түвшин, гарах үр дүн зэрэг асуудалтай холбон нэгтгэж авч үзэв. Мөн өндөр түвшний авлигын шалтгаан, нөхцөл, өндөр түвшний авлигын төрөл, хэлбэр, өндөр түвшний авлигын үр дагавар, хор хөнөөл зэрэг асуудлын хүрээнд экспертийн ярилцлагын дүнд үндэслэн авч үзэв.

Өндөр түвшний авлигын талаарх ойлголт

Өндөр түвшний авлигыг судалгаанд оролцогчид авлигын хэмжээ, төрөл, үйлдэгдэх түвшин, цар хүрээ зэргээс хамаарч харилцан адилгүй авч үзэж байгаа хэдий ч ерөнхийдөө үүнийг улс орны хөгжил, нийгэм, улс төр, эдийн засгийн амьдралд үзүүлэх сөрөг үр нөлөө, үр дагаварын хувьд авлигын маш ноцтой хэлбэр бөгөөд улс орны удирдлагын дээд түвшинд холбогдох авлига хэмээн санал нэгдэж байна. Өндөр түвшний авлигыг тодорхойлох, ойлгоход төвлөрч буй асуудлуудыг нэгтгэн авч үзвэл дараах дүр зураг харагдаж байна.

Өндөр түвшний авлига нь улс орны нийтлэг эрх ашгийг хөнддөг

Өндөр түвшний авлига улс орны эрх ашгийг хөндөж, түүнийг ноцтойгоор зөрчиж буйн гол илрэл нь газар, байгалийн баялаг,

ашигт малтмалын орд, тэдгээрийг эзэмших, ашиглах зөвшөөрөл, лиценз зэрэг эдийн засгийн төдийгүй улс орны тулгуур эрх ашигт холбогдолтой зүйлсийг худалдаж, зарж, үүнээс ашиг олж буйгаар илэрч байна гэж судалгаанд оролцогчид үзсэн. Өндөр хэмжээний авлига нь улс орны эрх ашгийг хөндөж байдаг нь улс төрийн ямар нэг сонирхол агуулж байдагтай холбоотой гэж үзэж байна. Төрийн байгууллагад ажиллаж буй экспертийн тэмдэглэсэнээр:

“Өндөр түвшний авлига гэж улс үндэстний нууцтай холбоотой бичиг баримтыг гадагш нь гаргах үйлдэл бөгөөд үүнд гэрээ хэлэлцээр ашигт малтмалын лиценз худалдаалах, зарах гэх мэт зүйлс ордог. Үүгээрээ өндөр түвшний авлига нь авлигын бусад түвшнээс ялгарна. Улс хооронд явагдаж буй уул уурхайд холбогдох тендер, гэрээ хэлэлцээр, төсөл, буцалтгүй тусламж, газар нутгийн худалдааг мөн өндөр түвшний авлигад хамааруулан үзэж байна. Учир нь тэдгээрийн цаана заавал улс төрийн болон бизнесмэнүүдийн тохиролцоо явагдаж байдаг”.

Өндөр түвшний авлига нь улс төрийн тохиролцоо хэлбэрээр хийгдэж буй тул улс орны эрх ашигт нийцэхгүй. Тухайлбал албан тушаалтнууд эрх мэдлээ ашиглах, улс орны хөгжил, эдийн засагт ашиггүйг нь мэдсээр байж өөрийн эрх ашигт нийцүүлэн бусдаас авлига авч буруу шийдвэр гаргахыг хэлнэ. Иймд өндөр түвшний авлига бол шууд хэлэхэд улс орноо мөнгө төгрөгөөр худалдаж байгаа хэрэг хэмээн судалгаанд оролцогчид үзэж байна.

Өндөр түвшний авлига нь үндэсний аюулгүй байдал, эдийн засаг, улс төрийн тогтолцооноос ашиг хайж буй этгээдэд буюу улс оронд чухал ач холбогдолтой салбарт, тодорхой хэсэг бүлэг хүмүүст ашиг тустай авлигыг хэлнэ. Иймээс өндөр түвшний авлигад авлигын мөнгөний хэмжээнээс илүү шийдвэрлэгдэж буй асуудлын түвшин, ач холбогдол чухал ажээ.

Өндөр түвшний авлига нь авлигын хэмжээтэй холбоотой

Өндөр түвшний авлигыг тодорхойлох нэг чухал зүйл бол авлигын хэмжээ хэмээн судалгаанд оролцогчид үзэж байна. Энэ нь өндөр түвшний авлигад хамаарагдах асуудлууд маш их мөнгөний хэмжээгээр хэмжигддэгээр тайлбарлагдах боловч, тэрхүү их

мөнгөний хэмжээг яг таг тодорхойлох нь боломжгүй зүйл байна. Өндөр түвшний авлигын хэмжээг нэгэн эксперт "... хэмжээний хувьд хэлэх хэцүү, гурав дөрвөн зуун сая доллар, тэрбумаар хэмжинэ", өөр нэгэн эксперт "ихэнхдээ тендер, албан тушаалын томилгоо, сонгуульд нэр дэвших зэрэгт хэдэн саяар нь хаяж байна" хэмээн үзсэн.

Өндөр түвшний авлигын хэмжээг төрийн байгууллагад ажиллаж буй экспертийн төсөөлж буйгаар илэрхийлбэл:

"Эдийн засгийн хөгжилд нөлөө үзүүлэхүйц хэмжээний өртгөөр үндэсний аюулгүй байдалд нөлөөлөх болов уу. Жишээ нь манай улсын дотоодын нийт бүтээгдэхүүн 10 гаруй тэрбум доллар дотор эргэлддэг гэвэл түүний 10 гаруй хувьтай тэнцэхүйц авлигын асуудал нь үндэсний аюулгүй байдалд бодитой сөрөг нөлөө үзүүлнэ. Иймд өндөр түвшний авлигад нэг болон түүнээс дээш тэрбум төгрөгийн асуудлууд орох байх".

Өндөр түвшний авлигын хэрэг үйлдэж буй хүмүүсийн цаана бүлэг хүмүүсийн томоохон эрх ашиг байдаг, мөнгө төгрөгний хэмжээ хэдэн арван тэрбумаар тоологддог, тэр утгаараа үндэсний аюулгүй байдалд нөлөө үзүүлэхүйц байдаг ажээ.

Өндөр түвшний авлига нь байгууллага, албан тушаалтны түвшинтэй холбоотой

Товчоор өгүүлэхэд бол өндөр түвшний авлига гэдэг нь нь өндөр, дээгүүр албан тушаалтнууд холбогдсон байдаг онцлогтой гэж судалгаанд оролцогчид санал нэгтэй үзэж байна. Үүнийг олон улсын байгууллагын экспертийн онцолсноор илэрхийлбэл:

"Монгол Улсад авлига дээгүүр түвшинд их гардаг, шийдвэр гаргах түвшний өндөр албан тушаалтнууд гадаад улс оронтой харилцахдаа хэсэг бүлэг хүмүүсийн эрх ашиг дээгүүр тавьж ажиллах, өөрөөр хэлбэл улс орны эрх ашигт сөргөөр нөлөөлсөн шийдвэр гаргах, мөн асар их мөнгөнөөс болж цаашид гарах хор уршигийг зөв бодитой үнэлж чадахгүйгээр шийдвэр гаргаж байна".

Эл чиглэлийг сонирхон судалдаг судлаач эксперт “Юуны өмнө эрх мэдэл, шийдвэр гаргах түвшинд ажиллаж буй хүмүүс үүнд хамаатай байх. Тэдгээр хүмүүс өөрсдийн эрх хэмжээгээ хэтрүүлэн төрийн их хэмжээний мөнгө төгрөгийг хувь амласан, эсвэл танил тал, хэн нэгэнд /хувь хүн, гадаадын компани гм/ өрсөлдөөнгүйгээр олгох, дундаас нь завших, зуучлахыг хэлж буй. Магадгүй тендэр, лиценз, зөвшөөрөл гээд олон зүйлийг энд ярьж болох байх. Тэгэхлээр энэ бол эрх мэдэлтэй, олон тэрбум төгрөгийг зувчуулж байгаа, төр болон нийгмийн аюулгүй байдалд ноцтой хор хохирол үзүүлэхүйц гэмт хэрэг” гэж үздэгээ илэрхийлсэн.

Өндөр түвшний авлигад зөвхөн Засгийн газрын эрх бүхий мэдэлтэй дээд албан тушаалтнууд холбоотой гэж илүү явцуу авч үздэгээ зарим эксперт илэрийлж байсан. Улс төр, бизнесийн бүлгүүдийн холбоотой байдал, олигархи, төрөөс төрсөн тэрбумтангууд зэрэг ойлголтууд ч үнэн хэрэгтээ өдөр түвшний авлигын асуудалтай холбоотой ойлголт хэмээн судалгаанд оролцогч зарим эксперт дүгнэж үзсэн.

Нэгэн экспертийн тэмдэглэснээр, “өндөр түвшний авлига нь уул уурхай, хөрөнгө оруулалт гэх мэт асуудлаар шийдвэр гаргагчдын түвшинд” байдаг ажээ. Мөн “өндөр албан тушаалтны хэрэг бол өндөр түвшний авлига” хэмээн өөр нэгэн эксперт товч тодорхойлсон.

Өндөр түвшний авлига нь өргөн хүрээндээ төрийн байгууллагын бүх шатанд, ялангуяа шийдвэр гаргах шатанд, явцуу хүрээндээ улс орны удирдлагын түвшинд, үндэсний аюулгүй байдалтай холбоо бүхий байгууллага, албан тушаалтны түвшинд, улс төрийн шийдвэр гаргах түвшинд шууд хамаатай тул олон нийтийн зүгээс нөлөө үзүүлэх боломж маш бага байдгаар өндөр түвшний авлига нь ялгардаг байна.

Өндөр түвшний авлига нь гарах үр дүнгээрээ ялгагдана.

Өндөр түвшний авлигыг түүнээс үүдэн гарах үр дүн, үр дагавараар ялган үздэгээ судалгаанд оролцогчид илэрхийлж байна. Судалгаанд оролцогч нэгэн эксперт үүнийг “... том түвшний авлигыг засаж залруулах бараг боломжгүй хохирол нь асар их” хэмээн онцлон тэмдэглэсэн.

Үр нөлөө их, цар хүрээ өргөн байх нь өндөр түвшний авлигын гол шинж ажээ. Учир нь өндөр түвшний авлига нь үр нөлөө, хор уршигаар тодорхойлогдоно. Өндөр түвшний авлига нь нийгмийн хөгжилд сөрөг нөлөө үзүүлэхүйц их хэмжээний, мөн гай түйтгэр авчирдаг болохыг судалгаанд оролцогчид дурдаж байсан.

Өндөр түвшний авлигын төрөл, хэлбэр

Өндөр түвшний авлигын тодорхой төрөл, хэлбэрийг нарийн тодорхойлж, зааглаж ялгах явдал экспертүүдийн хувьд ч төвөгтэй асуудлын нэг ажээ. Судалгаанд оролцогчдын тодорхой хэсэг нь өндөр түвшний авлигын төрөл хэлбэрийг тодорхойлон зааглаж мэдэхгүй хэмээж байсан. Гэвч улс төрийн эрх мэдэл бүхий албан тушаалтнууд хамаарах болов уу гэж ерөнхийд нь төсөөлж байна.

Өндөр түвшний авлигын Монголд тархсан түгээмэл хэлбэрүүдийг судалгаанд оролцогчид нэлээн өргөн цар хүрээнд ойлгодог нь ажиглагдсан. Өндөр түвшний авлигын төрөл хэлбэрийн олон янз байдлыг экспертүүд тэмдэглэхийн зэрэгцээ энэ нь эрх мэдэл бүхий өндөр албан тушаалтантай болон их хэмжээний мөнгөний хэмжээтэй шууд холбоотой гэж үзсэн.

Судалгаанд дурьдагдсан өндөр түвшний авлигын нийтлэг төрөл, хэлбэрүүдийг нэгтгэн авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

- Газрын наймаа, уул уурхайн салбар, тендер, барилгын ажлууд, ашигт малтмал, банк санхүү, албан тушаал, даргын суудал
- Зээл тусламжийн хэлбэрээр мөнгө угаах явдал
- Нууц бичиг баримт задруулах. Газар, ордын лиценз, авлига авч байгаа төсөл хөтөлбөр бүрийн цаана Монгол улсын нууцын асуудал хөндөгдөж байдаг.
- Гадны байгууллагынхан зөвхөн аудитийн байгууллагын дүгнэлтэнд итгэдэг тул бизнес эрхэлдэг байгууллага, хүмүүс аудитийн газраар хуурамч дүгнэлт үйлдүүлдэг
- Ихээхэн хэмжээний газар гадаадынханд зарах явдал
- Улаанбаатар хотын газрын асуудал. Ямар ч хот төлөвлөлт байхгүй, замбараагүй байшин барилга баригдсан байдаг нь үүний нэг илрэл.
- Албан тушаалтан эрх мэдлээ урвуулан ашиглаж авлига авах

- Төрийн өндөр албан тушаалтан өөрт ашигтайгаар шийдвэр гаргах
- Төрийн албанд ороход авлига авах
- Төр худалдан авалт хийхэд дундаас ямар нэгэн албан тушаалтан зуучлагч хийж авлига авах
- Газрын наймаа буюу лицензийн наймаа, тендер буюу төрийн байгууллагуудын худалдан авалт
- Албан тушаалыг, эрх мэдлийг, сонгогчдыг мөнгөөр авч байгаа хэлбэр бол өндөр түвшний авлигын хэлбэр
- Уул уурхай баялаг, гадаадын байгууллагуудын төсөл хөтөлбөр, эрх мэдэлтэй хүмүүсийн нууц тохироо
- Өндөр түвшний авлигын хэлбэр нь гадаадад офшор данс нээх, ойр дотны хүмүүст нь хувьцаа хэлбэрээр өгөх, эсвэл их хэмжээний бэлэн мөнгө, 1 сая доллараас доошгүй хэмжээгээр өгөхийг өндөр түвшний авлигад тооцож болно.
- Хэлбэрийн хувьд офшор дансны хэлбэр, хэмжээний хувьд төсөөлөх аргагүй
- Өндөр түвшний авлига гэрлийн хурдаар тархдаг гэж бодож байна. Маш богино хугацаанд өргөн цар хүрээтэй явагддаг.
- Өндөр түвшний авлигын хэлбэр, хэмжээний хувьд үндэстэн дамнасан корпорациуд улс төрийн засаглал нь сул дорой улс оронд очиж, өндөр ашиг хийчихээд явчихдаг. Байгалийн баялагийг нь аваад маш бага ашиг үлдээдэг.

Нэгэн иргэний нийгмийн байгууллагын экспертийн төсөөлж буйгаар өндөр түвшний авлигын төрөл хэлбэр нь:

“Өндөр түвшний авлигын төрөл хэлбэр гэхлээр надад байр суурь, өндөр албан тушаал төсөөлөгдөж байна. Төрийн өндөрлөгт ажиллаж байгаа хүмүүс энд яах аргагүй хамаатай. УИХ, шүүх, засгийн газар, мөн тэнд ажиллаж байгаа хүмүүс шийдвэр тушаалыг хэн нэгний эрх ашигт нийцүүлэн давуу тал, боломж олгож байгааг хэлэх байх”.

Энэ чиглэлээр судалгаа хийж буй судлаач экспертийн дүгнэж үзсэнээр өндөр түвшний авлигын онцлог нь:

“Өндөр албан тушаалтай хүмүүсийн холбогдсон хууль бус газар олголт, тендэр, зөвшөөрөл олгох, мөнгө угаах зэрэг олон

янз хэлбэртэй боловч илрэх нь цөөн байдаг. Цаад үйлдэгч нь баригддаггүй, наана нь нэг “утсан хүүхэлдэй” хэргийг нь хүлээсэн болоод өнгөрдөг” гэсэн байна.

Өндөр түвшний авлига хаана үйлдэгдэж, хэн үйлдэж байна вэ?

Энэ асуултыг өндөр түвшний авлигын цар хүрээг тодруулах зорилгоор судалгаанд оролцогчдоос асуусан. Хариултыг тоймлон авч үзвэл, Шүүх, Цагдаа, Прокурор, Засгийн газар, яам, аудитын байгууллага, парламент зэргийг өндөр түвшний авлигад холбоотой болов уу гэж төсөөлдөгөө судалгаанд оролцогчид илэрхийлсэн.

Ерөнхийдөө улс орны нэр барьж, улс орны нэрийн өмнөөс шийдвэр гаргадаг түвшний бүх байгууллага, түүний удирдах албан тушаалтан, тухайлбал яамдын сайд нарт энэ асуудал хамаарна гэдгийг судалгаанд оролцогчид илэрхийлэв. Экспертүүдийн үзэж буйгаар:

“дээгүүр албан тушаалтан, жишээ нь УИХ-ын гишүүд, яамдын сайдууд гэх мэт. Яамдын сайдууд л гэхэд өөрийн доор ажиллах албан тушаалтнуудаа танил тал харж, авлига авч ажилд авдаг”,

“авлига нь УИХ, яам агентлагын дунд, аймгийн засаг дарга нарын дунд шийдвэр гаргах болон төсвийн хуваарилалтанд нөлөөлөх, лиценз буюу газар наймаалцах мөн төрийн өмчийн худалдан авалт зэрэг асар их мөнгөний үйл ажиллагааны хүрээнд явагдаж байгаа”,

“... засаг солигдоход сайд солигдоно, үүнийг даагаад доор нь ажиллаж байгаа хүмүүс солигдоно, үүн дээр албан тушаалын тохиролцоо авлигын асуудал их гардаг. Эдийн засгийн хөгжлийн яам авлигад илүү өртөж байгаа гэж би боддог”,

“Өндөр түвшний авлигыг УИХ-ын гишүүд, үндэстэн дамнасан корпорацийн захирал, яамдын сайд нар, үндэсний томоохон компанийн удирдлага, түүнчлэн УИХ, Засгийн газрын гишүүдтэй ойр дотны хүмүүс авч өгөлцдөг гэж бодож байна”.

Мөн Монголын Олимпийн хороо, Монголын Хөлбөмбөгийн холбоо зэрэг байгууллагын талаар олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэгдэж буй мэдээлэлд үндэслэн төрийн бус байгууллагын статустай боловч авлигатай их холбогддог, авлигад автагдсан байгууллагууд гэж төсөөлдөгөө зарим эксперт илэрхийлсэн.

Монголд өндөр түвшний авлига байна уу?

Энэ асуултанд судалгаанд оролцогчид Монголд өндөр түвшний авлига

- *байна,*
- *байгаа нь ойлгомжтой,*
- *байгаа байх,*
- *байгаа гэж бодож байна,*
- *маш их байна,*
- *байдаг, үүнд огт эргэлзэхгүй байна,*
- *газар авч байна,*
- *нууц байдалтай байгаа,*
- *удахгүй илрэнэ гэх зэргээр хариулсан байна.*

Эндээс үзэхэд судалгаанд оролцсон экспертүүд Монголд өндөр түвшний авлига байдаг гэдэгтэй бүгд санал нийлж байгаа нь харагдаж байна. Нэгэн эксперт “Монгол Улсад байгаа болохоор хөгжихгүй байна” хэмээн үздэгээ илэрхийлсэн. Монгол дахь өндөр түвшний авлига бусад улсынхаас хэмжээ, тохиолдлын хувьд бага байж болох ч учруулах аюул, сөрөг хор нөлөө нь илүү их хэмээн үзэж байна.

Өндөр түвшний авлигын шалтгаан, нөхцөл

Өндөр түвшний авлигын шалтгаан нөхцөлд дараах асуудлуудыг судалгаанд оролцогчид нэрлэж байна. Үүнд:

Хийрхэл, эрх ашгийн төлөөх шунал, эрх мэдэл, ашиг сонирхол, амбиц, амин хувиа хичээсэн ёс зүйгүй байдал, шударга бус үйлдэл зэрэг нь авлигын нөхцлийг бүрдүүлж байна.

Өндөр түвшний авлига болон ер нь авлигад холбогдож буй хүмүүс боловсролын түвшин бага, мөнгө үзээгүй, хэрхэн яаж зөв зарцуулахаа мэдэхгүй. Өөрсдийн хүч хөдөлмөрөөр олоогүй учраас амар хялбар аргаар мөнгө олох сонирхолтой хувийн эрх ашигт хөтлөгдсөн хүмүүс байдаг.

Өндөр түвшний авлигын шалтгааныг судлаач эксперт нийгмийн нөхцөлтэй холбон авч үзэхдээ:

“Монгол Улс ардчилсан нийгэм биш капиталист нийгэм рүү явж байна. Тэр чигээрээ мөнгө хүүлэгч хөрөнгөтөн бий болж байна. Төрийн эрх мэдэлтэн ч бай, хэн нэгэн ч бай ямар ч арга замаар хамаагүй мөнгө олохын тулд юуг ч үл хайхарч байна” гэжээ.

Өндөр түвшний авлига үйлдэгдэж буй шалтгаан нь төрийн албан хаагчдын цалин багатай холбоотойгоос гадна, эрх мэдэлтэй боловч боловсрол муутай хүмүүсийн шунал хүсэлтэй холбоотой гэж үзэх хэсэг байна.

Улс төрийн болон сонгуулийн тогтолцоо, засаглалын хуваарилалт нь өндөр түвшний авлига үүсэхэд нөлөөлж байна. Хамгийн гол нь манайд үндсэн хууль дээдлэх, хуульт ёсыг удирдлага болгох явдал алдагдаж буй нь нөлөөлж байгааг экспертүүд тэмдэглэн хэлсэн. Өндөр түвшний авлига нь нэг хүний эрх ашгаар хязгаарлагдахгүй, улс төрийн тодорхой бүлэглэлийн эрх ашигтай холбоотой. Тэрхүү улс төрийн бүлэглэлийн эрх ашгийг хамгаалах, ашиг хонжоо олох зэрэг явцуу эрх ашиг нь өндөр түвшний авлигын гол нөхцөл юм.

Авилгын шалтгааны талаар Европын Комиссын 1999 оны илтгэлд: “Улсын хэвшилд ажиллагсдын бага цалин, эдийн засагт өргөн хэрэглэгддэг хүнд суртлын хяналтын тогтолцооны улмаас авилга өргөн тархаж, газар авсан. Эрх баригчдын авилгатай тэмцэх хүсэл зориг хомс байгаа нь олон оронд эхэлсэн авилгын эсрэг хөтөлбөрийг амжилт муутай болгож байна” хэмээн дурьдсан нь бий. [“Элсэх чиглэлд олсон ахиц дэвшлийг нэр дэвшигч орон тус бүрээр үзүүлсэн тайлан” хэмээх Европын Комиссын нэгдсэн илтгэл, 1999 оны 10 дугаар сар, 12 дахь тал]

Өндөр түвшний авлигын шалтгаан, нөхцөл нь хариуцах эзэн тодорхойгүй улс төрийн тогтолцоо, томоохон гэрээ хэлэлцээрүүдийг нууц байдалд байлгадаг явдал, мөн хэвлэл мэдээллийн хэрэгслүүд худалдагдаж буй байдалтай экспертүүд холбон үзжээ.

Өндөр түвшний авлигын үр дагавар, хор хөнөөл
Өндөр түвшний авлигын хор хөнөөл, үр дагавар

Өндөр түвшний авлигын хор хөнөөл, үр дагаварын талаарх судалгаанд оролцогчдын санал бодлыг дараах байдлаар тоймлон авч үзэж байна.

Өргөн хүрээнд авч үзвэл өндөр түвшний авлига нь улс орны ирээдүйн хөгжил, нэр хүнд, үндэсний аюулгүй байдалд хор хөнөөлтэй ажээ. Энэ талаар судалгаанд оролцогчдын хариултыг тоймлон авч үзвэл:

- Улс орны ирээдүй хойч үеэ бодолгүй зөвхөн хувийн эрх ашиг бодох нь улс үндэстэн мөхөх аюулд хүргэж хараат байдалд орох болно.
- Өндөр түвшний авлигын хор хөнөөлийг улс орон хөгжихгүй байна, нэр хүнд нь унаж байна, хувь хүн нь хөгжихгүй байна зэргээр тооцож болно.
- Монгол Улс мөнгө угаадаг орнуудын хар жагсаалтад орсон байснаа саяхнаас гарсан. Хэрвээ дахиад энэ жагсаалтад орвол Монгол Улсын нэр хүнд олон улсад нэгмөсөн унаж, ямар ч төсөл хөтөлбөр, хандив орж ирэх боломжгүй болно.
- Улс орны хөгжлийг хойш татаж байна. Зарим хүмүүс ажлаа бүтээхийн тулд авлига өгөхөөс өөр арга олсонгүй гэдэг. Энэ нь угтаа төрийн нэрийн өмнөөс амар хялбар мөнгө олохыг урьдал болгосон хүмүүсийг даврааж буй хэрэг л дээ.
- Монгол Улсын нэр хүнд унах, нийгмийн хүн ам маань маш ядуу байна үүний гол үндэс нь манай орны төрийн эрх бүхий албан тушаалтангууд хэт их авлигалд өртсөн явдал
- Өндөр түвшний авлига улс орны аюулгүй байдалд онцгой нөлөөтэй. Зөвхөн хувийн эрх ашгийг бодох, одоогийн нөхцлөө аргалах гээд ирээдүй хойч үеийнхээ өв баялгийг дээрэмдэх нь алс хэтээ бодоогүй үйлдэл.

Судалгаанд оролцсон олон улсын байгууллагын экспертийн дүгнэснээр:

“Өндөр түвшний авлига улс орны хөгжилд асар сөргөөр нөлөөлж байгаа. Өндөр албан тушаалтангууд асуудлыг өөрт ашигтайгаар шийдэж ард иргэдийн эрх ашгийг ихээхэн хохироож байна. Жишээ

нь: Олон улсын байгууллагын буцалтгүй тусламжийн дагуу мэргэжил дээшлүүлэхээр Солонгос улс руу явуулах тухай Эдийн засгийн хөгжлийн яаманд зарладаг гэвч яаманд ажилладаг нэгэн ажилтан цааш нь тараахын оронд хав дараад манайд явах хүн байхгүй гэх юмуу цагийг нь тулгаж байгаад өөрийн хүнээ буюу танил талаа шахдаг. Бид мэргэжил дээшлүүлэх сургалтанд явуулах зараа эргүүлж хүмүүст хэр хүрч вэ гэдгийг тагнан асуухад тийм зар тараагүй юм уу орон тоо дүүрсэн гэж хариулсан гэж байсан. Тэгээд гомдол мэдүүлж асуудлыг шийдвэрүүлэхийг хүссэн ч тэр ажилтанд ямар ч хариуцлага тооцоогүй л байна”.

Өндөр түвшний авлига нь ард иргэд, нийгэмд хор хөнөөлтэй талаар судалгаанд оролцогчид онцолсон. Тухайлбал:

- Өндөр түвшний авлигын нийгмийн хор хөнөөл нь ард иргэдийн ядуу байгаа байдал, нийгмийн эмх замбараагүй, хариуцлагагүй болсон явдал юм. Учир нь өндөр түвшний авлига авдаг хүмүүсийн ихэнх нь улс төрийн хүрээнийхэн. Тэдэнд ард иргэдээ ядуу байлгах сонирхол байдаг нь өөрсдийн хийсэн нууц гэрээ хэлцэл, луйврын наймаагаа нуун далдлах, халхлахад дөхөм болдог гэж үзэж байна. Иргэд боловсролгүй, ядуу байх нь өндөр түвшний авлига авдаг улс төрчдөд ашигтай байдаг бололтой.
- Өндөр түвшний авлигын нийгмийн хор хөнөөл нь ард иргэд ямар ч итгэл найдваргүй болох явдал.
- Өндөр түвшний авлигын хамгийн ноцтой хор хөнөөл нь улс үндэстэн мөхөхөд хүрэх явдал.
- Цөөхөн хэдэн хүмүүс хууль бусаар төрийн мөнгөөр баяжиж үлдэх хэсэг нь ядуу дорой нөхцөлд амьдарч байгаа нь энэхүү авлигын хор хөнөөл мөн.
- Өндөр түвшний авлигын хор хөнөөл нь нийгэмд, нийгмийн харилцаанд, хүмүүсийн сэтгэлгээнд өөрчлөлт оруулах маш сөрөг нөлөөтэй. Харин өндөр түвшний авлига ихсэх нь түүнийг нийгмээрээ жигшихэд хүргэж болох юм.

Өндөр түвшний авлигын эдийн засаг дахь нөлөөг судалгаанд оролцогчид мөн онцолж үзсэн. Үүнд:

- Эдийн засагт сөрөг нөлөөтэй. Авлига нь эдийн засгийн хөгжилд болон ард түмний амьдралд сөргөөр нөлөөлнө. Зөвхөн хэсэг бүлэг хүмүүст зориулан гаргасан шийдвэр нь татвар төлөгчдөд асар их дарамт шахалт болон ирдэг. Тийм шийдвэр нь яваандаа эдийн засгийн алдаатай бодлого болж иргэдийн амьдрал, эдийн засагт асар их нөлөө үзүүлнэ.
- Авлигын хор уршгаар улсын эдийн засгийн хөгжил асар удааширна. Мөн байгалийн баялагыг гадаад алдах. Ард иргэдийн боловсролын түвшин дорой, хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь авлигачдын гар хөл болсон байдаг нь тэд ард иргэдийг тархийг угаахад үүрэг их гүйцэтгэж байна.
- Монгол улсын нийгэм эдийн засгийн хөгжилд асар их садаа болж, хөгжлийг дор хаяж 5-10 жилээр ухрааж байна. Энэ нь ядуурлыг улам нэмэгдүүлж байгаа бөгөөд ядуурал нь нийгмийн олон янзын сөрөг үр дагаваруудыг бий болгож байна. Монгол улсын ядуурлын түвшин 29 хувь гэдэг нь маш ноцтой үзүүлэлт. Ядуу хүмүүс юу ч хийхээс буцахгүй болсон. Мөн аливаа ажлыг бүтээхэд заавал танил талаар дамжуулах, гар хүндрүүлэх зэрэг нь ёс, уламжлал мэт болсон нь хойч үеийг буруугаар хүмүүжүүлж бэлдэж байна. Бас монгол хүний сэтгэлгээг ядуурж байна, үнэнч байх үнэт зүйлс байхгүй болж байна мөн төрийн албан хаагчийн ёс зүй хэм хэмжээ алдагдсан зэрэг нийгмийн сөрөг уур амьсгал бий болж энэ нь үндэсний аюулгүй байдалд нөлөөлж байна.
- Мөнгө санхүүгийн хямрал, ард иргэдийн амьжиргаа ядуу дорой байгаа явдал нь ард иргэдэд үзүүлж буй авлигын бодит хор хөнөөл.

Өндөр түвшний авлигаас хэн хохирох вэ?

Өргөн хүрээндээ өндөр түвшний авлигаас болж улс орон, ард иргэд, улс орны цаашдын хөгжил, дэвшил, ирээдүй хойч үе хохирно гэж судалгаанд оролцогчид бүгд үзэж байна. Ард түмэн ядуу зүдүү, цаашдын амьдралдаа итгэлгүй, боловсролгүй байгаа энэ бүх байдал нь авлигын хор хөнөөлийн нэгэн хам хэлбэр болж байна.

“Өндөр түвшний авлигын хохирогч нь нийгмийн үйлчилгээ хүртэж чадахгүй байгаа, ядуурал зовлонд өртөж буй ард иргэд

байдаг” гэж нэгэн эксперт дурдсан нь үүний нэг илэрхийлэл юм. Монгол улсын нэр төр унах, бусад орны хувьд үнэлэмж буурах, хэн нэгний хараат байдалд орох зэргээр улс орон, төр засаг бүхэлдээ хохирно гэж үзэж байна. Авлигын асуудлаас болж ард иргэд төр засагтаа итгэхээ болино. Авлига, хээл хахуулаас болж төр засаг хэврэг, тогтворгүй, хямралтай болох үндэс тавигдах байх.

Цаашилбал, хувь хүн, гэр бүл, хамт олон зэрэг нийгмийн бүхий л гишүүд, бүхий л хэсэг бүлэгт авлига нь хор хөнөөлтэй юм. Тухайлбал, гэр бүлийн хувьд сэтгэл зүйн хямралд өртөх, амьдрал нь дарамттай болох, хувь хүн, өрх гэрийн амьжиргаанд авлига муугаар нөлөө үзүүлэх боломжтой ажээ.

Төрийн бус, иргэний нийгмийн байгууллагын нэгэн эксперт ярилцлагадаа:

“Авлигын хохирогчид ирээдүй хойч үе маань болж байна. Хотын утаа, дэд бүтцийн өнөөгийн байдал, хичээллэх орчин муудах зэрэг хүүхдийн эрх ашиг асар их зөрчигдөж байна. Жилд олон хүн эрсдэж байгаагаас олонх нь хүүхэд байна. Мөн ажилгүйдэл их болж байна. Жижиг дунд бизнес эрхлэгчид банкны зээл авахад нөхцөл их хүнд учир банкнаас зээл авч чадахгүй зэрэг авлигын хор уршгаас болж иргэн хүний амьдрах орчин байхгүй өөрөөр хэлбэл эрх чөлөөтэй ажиллаж амьдарч чадахгүй болж байна” хэмээн онцолсон.

Хожигч нь тухайн үеийн сайд, түшмэдүүд, хохирогч нь нийгмээрээ, бүгдээрээ байдаг. Өндөр түвшний авлига ихсэх, газар авсанаар улс орны цаашдын хөгжил хохирно. Энэ нь эцсийн дүндээ нийгмийн гишүүн бүр хохирно гэсэн үг хэмээн экспертүүд үзэж байна.

3.3 АВЛИГА, ӨНДӨР ТҮВШНИЙ АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ БОЛОН ШУДАРГА ЁСЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ НЬ

Судалгаанд оролцсон шинжээчдийн санал бодлоос үзэхэд “авлига, тэр дундаа өндөр түвшний авлига бол ард иргэдийг ядууралд хүргэн, улс орны хөгжлийг сааруулж, хямралд оруулахын зэрэгцээ төр засгийг чадавхгүй болгож байдаг нийгмийн аюултай үзэгдэл” болно.

“Авлига ба өндөр түвшний авлигын талаар Та юуг ойлгодог вэ?” гэсэн асуултад шинжээч, судлаачдын хариулсан байдлаас

харахад дараах ерөнхий хандлагууд тодорч байна. Юуны өмнө экспертүүд өндөр түвшний авилгыг **нэгд** улс орны эрх ашгийг хохироох хэмжээний мөнгө, эд зүйлсийг хувьдаа завших, бусдад хууль бусаар эзэмших боломж олгох, **хоёрт** төрийн албан хаагчийн ёс суртахуунгүй үйлдэл **гуравт** төрийн дээд албаны хүмүүс эрх мэдлээ буруугаар ашиглаж буй хэлбэр хэмээн харилцан адилгүй тодорхойлсон ба энэхүү авлигын улмаас үндэсний аюулгүй байдалд ноцтой хохирол учруулж болохыг тэмдэглэсэн. Авлига ба өндөр түвшний авлигыг хэрхэн ойлгож тодорхойлж байгаагаас хамааран тэдгээрийн авлигыг үл тэвчих, тэмцэх арга хэлбэр илэрхийлэгдэж байна.

Харьцуулалт. Авлига ба өндөр түвшний авлигын ялгаатай тодорхойлолт

Авлига	Өндөр түвшний авлига
<ul style="list-style-type: none"> • <i>Гар цайлгах явдал хаа саагүй л байдаг болсон.</i> • <i>Төрийн нэрийн өмнөөс үзүүлж буй үйлчилгээг хурдавчлуулах үүднээс албан бус хэлбэрээр өгөх төлбөр. Өөрөөр хэлбэл хийх ёстой ажлынхаа төлөө мөнгө авахыг хэлнэ.</i> • <i>Хүмүүс баярласан сэтгэлээ илэрхийлж байдаг нийтлэг зүйл.</i> • <i>Багахан хэмжээний бэлэн мөнгө, хоол, цайнд оруулах, чихэр, шоколад, жижиг бэлэг сэлт өгөхөөс эхэлдэг.</i> • <i>Танил тал, “арын хаалга” ашиглах хэлбэр</i> 	<ul style="list-style-type: none"> • <i>Эрх мэдэл бүхий хүмүүсийн хууль бус, гэмт үйлдэл мөн.</i> • <i>Өндөр албан тушаалтнууд хуулийг гажуудуулж, завхруулж буйгаас үүдэлтэй.</i> • <i>Тендэр болон бусад томоохон хэмжээний мөнгө төгрөгтэй холбоотой яригддаг зүйл.</i> • <i>Бүлэглэн үйлддэг зохион байгуулалттай гэмт хэрэг.</i> • <i>Үндэсний аюулгүй байдалд нөлөө үзүүлэхүйц их хэмжээний мөнгө төгрөгтэй холбоотой хэрэг.</i>

Авлига болон өндөр түвшний авлигатай хэрхэн тэмцэх талаар шинжээчдийн байр суурь харилцан адилгүй байгаа болно. Шинжээчид дараах хэд хэдэн түвшинд авлигатай тэмцэж болох талаар хариулт өгчээ.

Нэгд. Хууль эрхийн хүрээнд төдийгүй, түүнээс гадуур өргөн хүрээтэй тэмцэхийг санал болгож байна.

Авлигыг зөвхөн гэмт үйлдэл төдийгөөр хязгаарлан эрүүгийн хууль, төрийн албан хаагчийн ёс зүй, үүрэг хариуцлагын хүрээнд шийдвэрлэхийг оролдох нь тийм ч өгөөжтэй арга зам биш хэмээн дэлхий нийтийн хандлагад үзэх болсон. Судалгаанд хамрагдсан экспертүүд хууль эрхийн хүрээнд тэмцэх цогц бөгөөд тодорхой арга замуудыг санал болгожээ. Үүнд:

“Өндөр түвшний авилгатай тэмцэхийн тулд хууль эрхийн орчноо сайжруулах, хэрхэн тэмцэх талаар тодорхой үзэл баримтлалтай байх хэрэгтэй”.

“Хууль тогтоомжийг сайжруулах, өндөр албан тушаалтанд тооцох хариуцлагыг чангаруулах хэрэгтэй”.

“Улс орон бүхэн л авлигатай тэмцдэг байх гэхдээ Монгол шиг бага хүн амтай улсад хэцүү л дээ. Танил тал найз нөхөд гээд явчихна. Ийм нөхцөлд хууль эрх зүйн орчинд маш чанга байх хэрэгтэй яг Хятад шиг. Нөгөө талаас хувь хүний ёс зүйн асуудал чухал байна. Тэр дундаа төрийн албан хаагч. Хүн бүр авилгалын эсрэг хатуу зогсох хэрэгтэй”.

“Хууль зөрчсөн бол ямар ч албан тушаалтан шүүхийн өмнө очих хэрэгтэй, өнөөгийн Засгийн газар маш их хууль зөрчиж байна”.

“Миний бодлоор нэн тэргүүнд хууль эрх зүйн орчинг сайжруулах засах хэрэгтэй”.

“Хариуцлага хүлээлгэж чадахгүй байгаа. Цаашаагаа замхраад алга болдог. Авлигатай тэмцэх тогтолцоог бий болгох шаардлагатай ялангуяа прокурорын байгууллагын хяналтыг сайжруулж, чадваржуулах хэрэгтэй. Прокуророос очсон хэргийг шүүх арай зөөлрүүлээд байх шиг. Хэдэн арван тэрбумаар идсэн хэрэгтэн зүв зүгээр явж байна. Хэрэв баталгаа нотолгоотойгоор үнэн нь тогтоогдсон л бол улсыг хохиролгүй болгох ёстой. Үүн дээр прокурор сайн хяналт тавьж ажиллах хэрэгтэй болов уу”.

“Бид авилгыг хэрвээ хогийн ургамал гэж үзэх юм бол, ургаж гарч ирснийг нь л зулгааж хаячихаад сууж байх дан ганц тийм арга замаар бус, харин дахин шинээр ургах орчныг нь хязгаарлан хаах тийм арга замаар тэмцэх нь л илүү өгөөжтэй”.

Экспертүүд, ихэнх хүмүүсийн ойлгодог шиг “**авлигыг тогтсон хууль дүрмийг зөрчих төдийгөөр үзэж болохгүй**” гэдгийг энд онцолсон юм. Учир нь өндөр түвшний авлигыг үйлдэгч нь хууль дүрмийг сайтар мэдэхийн сацуу, хуулинд тусгаагүй атлаа улсын эрх ашгийг “илэрхий зөрчсөн” үйлдлүүд гаргах нь олонтаа байдаг аж. Иймд эл түвшинд үйлдэгдэж буй авлигатай тэмцэхийн тулд нэр томъёог оновчтой болгохоос эхлээд зонхилон үйлдэгдэж буй хэлбэр, хор уршиг, тэмцэх ба илрүүлэх, зохицуулах арга замын талаар холбогдох хуульд зүйл заалт оруулах нь нэгэн чухал алхам болох юм.

Хууль эрхийн хүрээнд өндөр түвшний авлигатай тэмцэхдээ макро орчныг сайжруулж авлигыг үл тэвчих үзэл хандлагыг бий болгох, хууль дээдлэхийн зэрэгцээ биелүүлэх, нэгэнт тухайн этгээд авлигын хэрэг үйлдсэн нь тогтоогдсон бол шийтгэх ял тодорхой байх, ял шийтгэлийг чангатгах, эрүүгийн хуулийн зүйл заалтад оноох шийтгэлийг тодорхой тусгаж өгөх шаардлагатай байна.

Түүнчлэн энэ түвшинд үйлдэгдэж буй авлигатай амжилттай тэмцэхийн тулд ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах, эрх зүйн цар хүрээ, тогтолцоог боловсронгуй болгох, улс төрийн намын санхүүжилт, олон нийтийн мэдээлэл авах боломж зэрэгт анхаарлаа хандуулах хэрэгтэй болохыг шинжээчид санал нэгтэй баталж байна.

Хоёрт. Улс төр, эдийн засгийн хандлагаар авлигатай тэмцэх шаардлагатай.

Авлигатай тэмцэх хойшлуулшгүй чухал зүйл бол **төрийн бодлого тодорхой, нэгдсэн үзэл хандлагатай, улс төрийн тогтолцоог шинэчлэх, өөрчлөх явдал** хэмээн иргэний нийгэм, төрийн бус байгууллагын экспертүүд үзсэн байна. Улс төрийн тогтолцоог сайжруулахын тулд нэн тэргүүнд сонгуулийн тогтолцоог өөрчлөх, намын харъяаллаар талцах явдал, төрд алба хааж буй хүмүүсийг томилох томилгоо, улс төрийн намуудаас хэт хараат байдлыг багасгах зэрэг хэд хэдэн зүйлийг тэмдэглэжээ.

-Нөгөө талаар нам, улс төрийн байгууллага бүлгээр үйлдэгдэж буй авлигын сүлжээний маш том хаалт, хамгаалалт болж байгаа гэдэгтэй хэн ч маргахгүй байх. Шууд хэлэхэд хуулиас дээгүүр эрх мэдэл, ба хуйвалдаан тэнд нуугдаж байгаа.

- Улс төрийн намын тогтолцоо нь маш хүчтэй аль нам гарна, дэмжиж байсан хүмүүс бүгд дагаад албан тушаал ахих жишээтэй. -Гол нь улс төрийн тогтолцоог боловсронгуй болгох хэрэгтэй. Хэрэв улс төрийн шударга тогтолцоотой байсан бол өндөр түвшний авлига гарахгүй байх байсан. Мөн хэвлэл мэдээллийн хэрэгслүүд худалдагдахгүй байх нь үүнтэй тэмцэх гол аргын нэг юм.

-Өндөр албан тушаалтнаас айх, нам улс төрийн холбоо аль нам улс төрийн эрх барьж байгаагаас шалтгаалаад тухайн намын албан тушаалтаны ойр төрлийн хүмүүс төрийн албыг хашна гэсэн үг.

-Манайд намын талцлыг болиулах хэрэгтэй, нэг нам гарахад бүх хууль шүүх нь солигддог. Энэ байдал чинь тэр хүмүүсээ өмгөөлөөд хамгаалаад байна, өөрөөр хэлбэл намайг ажилд авсан хүнийг би шүүхийн өмнө дуудах уу чадахгүй ш дээ, үүнийг болиулах хэрэгтэй. Ялангуяа томилгооны асуудал дэндүү авлигалтай байна .

"Үндсэн хуулинд өөрчлөлт оруулах шаардлагатай. Ерөнхийлөгчийн засаглалтай болох, мөн Засгийн газрын яамдыг цөөлөх, сонгуулийн хуулиа өөрчлөх, мажоритар системтэй болох нь чухал байна".

-Нэгдсэн үзэл стратеги, бодлоготой болох хэрэгтэй байна тэгэхгүй бол Сангийн яам юм уу, Хөдөө аж ахуй яам нь өөр өөрсдийн амбиц хөөсөн өөр өөр зүйлсийг ярьдаг. Энэ нь их буруу ер нь нэгдсэн үзэл бодолтой буюу төрийн бодлого нь тодорхой бүх улс төрийн хүчин үүнийг нь хүлээн зөвшөөрсөн байх хэрэгтэй.

-Магадгүй улс төрийн намд үйлчилдэг биш харин хууль ёсны хэрэгжилтийг хангадаг эрх ашиг байвал тэмцэх боломж гарах байх.

Эцсийн дүндээ авлигаас үүдэн төр засаг "сульдаж", "хүчгүйдэж" нэг ёсондоо аюулгүй байдлын үндэс алдагдаж байдаг тул төрийг чадавхижуулахын тулд улсын хэвшлийн удирдлагыг өөрчилж, улс төрөөс хараат бус болгох, хувийн хэвшлийг аль болох нэмэгдүүлэх нь чухал болохыг экспертүүд тэмдэглэсэн болно.

Иргэдийн дунд "хавтгайрсан" хэмээн тооцогдож буй дунд болон доод түвшний авлигыг багасгах нэгэн арга зам бол эдийн засгийн бодит боломжид тулгуурлан төрийн албан хаагчдын

цалин хангамжийг нэмэгдүүлэх явдал юм. Түүнчлэн эдийн засгийн өрсөлдөөнийг нэмэгдүүлэх нь авлигыг өөгшүүлэхгүй байхад ихээхэн тустай. Үүнд макро эдийн засгийн тогтвортой байдал чухал. **Дан ганц авилгалтай өөртэй нь тэмцэх бус харин макро орчныг сайжруулах замаар бүхий л түвшний авлигатай тэмцэх явдал чухал хэмээн экспертүүд үзсэн.**

-Авлигад өртөх магадлал ихтэй ажлын байрны цалинг нэмэх, ажлын орон тоог ихэсгэх, хууль эрх зүйн орчинг сайжруулах шаардлагатай. Авлигад өртсөн тохиолдолд ял шийтгэлийг нь чангаруулах хэрэгтэй. Хууль тогтоомжийг олон нийтэд сайтар таниулж ухуулан сурталчлах, гаргасан хуулиа сайтар хэрэгжүүлэх хэрэгтэй.

-Санхүүгийн нэрийн систем тогтоох хэрэгтэй бүхэл үйл ажиллагаа ил тод болгох хэрэгтэй тунгалаг гэж ярьдаг, хүмүүс олон нийтэд мэдээлж байх хэрэгтэй.

Олон улсын практикаас үзэхэд хууль эрхийн болон улс төрийн авлига нь харилцан бие биенээ нөхцөлдүүлж байдаг. Авлигад өртсөн, хээл хахууль өгсөн нь тодорхой болсон ч, “улс төрийн хамгаалалт” бүхий этгээдэд шүүх, хуулийн байгууллага зарим тохиолдолд хариуцлага тооцож чаддаггүй. Энэ байдал нь улс төр, төрийн албанд ажиллах үнэнч шударга иргэдийг шантрах, зайлсхийхэд хүргэдгээрээ цаашилбал хялбар аргаар мөнгөтэй болох гэсэн хүмүүсийг “өдөөж” байдгаараа ихээхэн хор уршигтай, нөгөө талаар авлига авах сонирхол бүхий этгээдийг төрийн албанд орж ирэх “гүүр” болдгоороо үндэсний аюулгүй байдалд заналхийлэл учруулах нэгэн нөхцөл болдгийг үгүйсгэх аргагүй юм.

Гуравт. Төрийн албанд захиргааны хяналт тогтоож, хариуцлага, дүрэм журмыг сахиулах байдлаар тэмцэх хэрэгтэй.

Шударга ёсыг сахиулах, нэг ёсондоо ил тод, хараат бус, бие даасан байдлыг хариуцлага, ёс зүйтэй зөв хослуулах нь ихээхэн чухал бөгөөд төрийн албанд дээрх нөхцлийг хангах нь авлигын эсрэг тэмцэлд ач холбогдолтой гэдгийг экспертүүд тэмдэглэж байна.

“Энд эрүүгийн хуулийн заалтуудыг төрийн захиргааны хяналттай хослуулах замаар тэмцэх шаардлагатай”.

“Байгууллагын дотоод хяналтын системийг сайжруулах. Өөрөөр хэлбэл авлигад өртөх эрсдэлийг олж мэдэх түүнээс урдчилан сэргийлэх үйл ажиллагаа сайн явуулах. Аливаа нэг шийдвэр гаргахдаа авлигын нөхцөл байдал үүсэх эсэхийг сайтар магадлан мэдэх шаардлагатай. Ер нь төрийн албан хаагч хуулийг сайтар мөрдөж сурах хэрэгтэй. Хэрэв холбогдвол шууд огцорч хариуцлагаа үүрэх ёс зүйг сургах хэрэгтэй”.

“Төрийн албан хаагч өөрийн гүйцэтгэх үүрэг хариуцлагыг сонгож тодорхойлох боломжтой учраас авилгалын эсрэг ямар нэг хэмжээгээр дархлаатай байдаг. Авилгалтай тэмцэх хамгийн сайн арга бол “дархлаа бүхий” албан хаагчдыг бий болгох явдал юм”.

Учир нь аливаа улс орны төр засагт ажиллаж буй хараат бус байдал ард иргэдийн зүгээс түүнд итгэх итгэлд үндэслэдэг жамтай. Нөгөөтэйгүүр **ард түмэн төр засагт итгэхээ болих, авлигыг төрийн албанд, дээд түвшинд, эрх мэдэлтнүүд ихээхэн авдаг хэмээх “сэрдлэг” нь авлигыг нийт нийгэм даяар “дэврээж”, улмаар “хүн бүр байх ёстой ердийн зүйл” хэмээн хүлээн авахад хүргэдэг** үндсэн хүчин зүйл болж байгааг тэмдэглэх нь зүйтэй.

Хяналтын системийг ил тод байлгах олон нийтийн хяналтыг сайжруулж, нийгэмд үл тэвчих уур амьсгалыг бий болгох, нэгэнт илэрсэн тохиолдолд тууштайгаар энэ хэргийн үнэн мөнийг олохоос гадна цаашид тухайн хүнийг төрийн албанд орох эрхийг нь хаах хэрэгтэй.

Төрийн байгууллага дотроосоо өөрчлөгдөх хэрэгтэй үүнийгээ төрийн өндөр албан тушаалтан өөрөө хүлээн зөвшөөрсөн байх хэрэгтэй байна.

Зайлшгүй хянах 1000 гаруй хүнийг сайтар хяначихад хангалттай байх. Ер нь энэ авлигад холбогдоод байгаа хэргийг үнэн мөнийг эхнээс нь аваад дуустал нь явж олох. Төр засаг ард түмэндээ нэр хүндээ буцаан олж авах тал дээр дорвитой зүйлс хийх хэрэгтэй.

Түүнчлэн авлигыг үл тэвчих уур амьсгалыг нийгэмд бүрдүүлэх, олон нийтийн хяналтыг сайжруулах, төрийн албанд ажиллах эрхийг нь хаах, зайлшгүй хянах ёстой албан тушаалтны жагсаалтыг гаргах нь авлигатай тэмцэхэд гойд нөлөөтэй хэмээн экспертүүд үзсэн.

Дөрөвт. Ёс зүй, иргэний нийгмийн ил тод байдлыг хангах замаар авлигатай тэмцэх нь чухал.

Иргэний нийгмийг хөгжүүлж, бэхжүүлснээр улс төрийн хариуцлага сайжирдаг зүй тогтолтой. **Улс төр, төрийн албан тушаал, эрх ямба эдэлж буй хүмүүсийн хариуцлага сайжирч, төсвийн зарцуулалт ил тод болох явдал бол авлигыг ихээхэн багасгаж болохыг** экспертүүд онцолсон байна.

“Улсын нэрийн өмнөөс хийгдэж байгаа тендер болон санхүүгийн асуудал, шийдвэрийг олон нийтээр хэлэлцүүлэх, ил тод нээлттэй байлгах хэрэгтэй, өөрөөр хэлбэл олон түмний хий хардалтыг багасгах арга хэмжээ авах хэрэгтэй. Ер нь бол төрийн байгууллага аливаа шийдвэр гаргахдаа олон нийтэд заавал танилцуулж байх ёстой”.

“Ер нь төр засгийн засаглал, мэдээллийг нээлтэй байлгах хэрэгтэй шилэн дансны хууль гэх мэтээр. Мөн манай иргэдийн оролцоо маш сул тул иргэдийн оролцоог идэвхжүүлэх хэрэгтэй. Японд л гэхэд Сангийн яам, Үндэсний аудитын газар нь тайлангаа вэб сайтад нээлттэй гаргаж тавьсан байдаг. Иймэрхүү юман дээр анхаарах хэрэгтэй байна”.

Дээрх саналд тулгуурлан авч үзвэл **авлигын шинжээчид иргэний нийгмийг хөгжүүлснээр нийгэмд ёс зүйг төлөвшүүлж, шударга ёсыг тогтоох боломжтой** хэмээн үзэж байна. Экспертийн ярилцлагын үр дүнгээс үзэхэд төрийн албан хаагчдын ёс зүй, зан харьцаа тааруу, тэдний цалин хөлс бага байгаа болон ёс зүйн гажуудал нь албан тушаалаа урвуулан ашиглах, хувийн ашиг хонжоо эрэлхийлэх, албан бус төлбөр авах зэрэг эдийн засгийн шунахай сэдлээр дээрх үйл ажиллагаанд оролцоход түлхэж байна. Үүний зэрэгцээ авлигатай тэмцэх тухай хуульд заасан албан тушаалтайн **“хөрөнгө орлогын мэдүүлгийг(ХОМ)” хянан шалгах ажлыг зохион байгуулах ажил нь ёс төдий бөгөөд, авлигыг илрүүлэх, тэмцэх үндсэн аргачлал болж чадахгүй** байгаа хэмээн экспертүүд дүгнэжээ.

“Гадаад орнуудад бол төрийн албаны ёс зүй, хариуцлагын тогтолцоо нь маш хүчтэй. Төрийн өндөр албан тушаалтны буруугаас болсон бол хүлээлгэх шийтгэл нь ч, үүрүүлэх

хариуцлага нь ч тодорхой. Манайд бол бүрхэг. Төр засагт ажиллаж буй албан тушаалтнуудаас хөрөнгө орлогын мэдүүлэг гэж авч байна. Гэтэл эхнэр нөхрийн, үр хүүхдийнхээ нэр дээр баахан орлого олчихсон. Өөрөө цалингаас өөр орлого байхгүй, бараг сайд, гишүүн болоод орлого буурчихлаа гээд л мэдүүлж байдаг. Ер нь бол тэнэг хүн хуурч байгаа мэт инээдэмтэй л зүйл".

Төрийн албаны аль ч шатанд үүрэг хариуцлагын тогтолцоо алдагдаж байгаа нь тэдний цалин орлогын хүрэлцээ муу, эргэж тайлагнах зарчим үйлчилдэггүйтэй холбоотой болохыг судалгаанд оролцогчид тэмдэглэсэн. Иймд **иргэний нийгмийг бэхжүүлж чадавхижуулах, төсвийн хуваарилалтыг баг, хороо зэрэг төрийн анхан шатны нэгжээс эхлээд дээд түвшинд хүртэл нээлттэй, ил тод болгох нь чухал ажээ.**

Тавд. Өндөр түвшний авлигатай тогтолцоот хандлагаар, цогц хэлбэрээр тэмцэх хэрэгтэй.

Хэдийгээр Монголд авлигын эсрэг Авлигатай тэмцэх газар үйл ажиллагаагаа явуулж байгаа боловч нэг болохоор Ерөнхийлөгчийн ажил мэт, нэг болохоор Авлигатай тэмцэх газрын нэг ажилтны ажил мэт харагдсаар удаж байна. Үнэндээ өндөр түвшний эрх мэдэлтний үйлдэж буй авлигыг илрүүлэх систем, тогтолцоо одоохондоо байхгүй байна. Үнэхээр тэмцэе гэвэл **төрийн дээд өндөрлөгөөс дунд, доод шат хүртэл, хууль эрх мэдлээс ёс зүй, дүрэм журмыг хэрэгжүүлэх хүртэл, төрийн байгууллагаас төрийн бус иргэний нийгэм хүртэл, авлигыг үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх хүртэл, гадаад улс орны туршлагаас өөрийн орны онцлог хүртэл бүхий л түвшин, хүрээнд цогц хэлбэрээр тэмцэх хэрэгтэй** байна. Тогтолцоот хандлагаар тэмцэнэ гэдэг нь авлигыг хамрах хүрээгээр нь, авч буй эздээр нь, илрэх хэлбэрээр нь, үйлдэгдэж буй түвшнээр нь нэгэн бүхэл систем хэмээн харж, тэмцэх хэлбэр юм. Энэ талаар хэд хэдэн экспертийн илэрхийлсэн үндсэн санаануудыг цухас эшлэе.

“Авлига бол бага түвшнээс дээд түвшин хүртлээ уялдаатай явагдаж байгаа эд. Доод түвшинд авсан авлигачид дунд түвшинд байгаа авлигачиддаа өргөл барина, харин дунд түвшинд ажиллаж байгаа хэсэг нь дээд түвшинд ажиллаж буй хүмүүстээ өргөлөө барина. Дээд түвшинд ажиллаж буй эрх мэдэлтнүүд нь доод, дунд түвшний түшмэдээ томилно, бөөцийлж хамгаална. Иймд авлигатай бүх түвшинд тэмцэх тогтолцоо бий болгох шаардлагатай”.

“Өндөр түвшний авлигатай байгууллага, тогтолцоо тэмцэх ёстой. Авлигалтай тэмцэхэд бүх нийтийн оролцоо хэрэгтэй. Авлигатай тэмцэхэд бүр суурь боловсролын шатнаас нь сургаж, авлигыг үл тэвчих үзлийг суулгаж өгөх хэрэгтэй”.

“Тогтолцоо бий болгох хэрэгтэй, энэ маш чухал бүхэл бүтэн системийг нь өөрчлөх хэрэгтэй. Хөгжил дэвшил, улс төрийн тогтолцоо нь боловсронгуй байх тусам, нээлттэй байх тусам өндөр түвшний авлига байх боломж хязгаарлагдана. Түүнчлэн тэмцэх хүсэл эрмэлзлэл байх хэрэгтэй. Манайд тэмцэх хэрэгцээ нийгмийн шаардлагаар гарч ирнэ гэж итгэдэг”.

Чухамдаа авлигыг улс төрийн тогтолцоон дотор үйлдэгдэж буй уялдаа бүхий дэд тогтолцоо хэмээн үзвэл энэхүү үзэгдлийн оролцогчид болох төрийн албан тушаалтан, тэдгээрийн мөн чанарыг сая ухаж, цогц хэлбэрээр тэмцэх боломжтой юм.

Зургаа. Дагнасан мэргэжлийн байгууллага, түүний үйл ажиллагааг “хүч”-тэй, “далайц”-тай болгох замаар тэмцэх хэлбэр байж болно.

Экспертүүд авлигатай тэмцэх чиг үүрэг бүхий төрийн байгууллагыг энд онцолж байна. Авлигын төрөл хэлбэр, хор хөнөөл, үр дагаварыг бууруулахад тухайн асуудлыг хариуцаж буй байгууллагын үйл ажиллагаа хангалтгүй, хүч сул байгааг экспертүүд санал нэгтэй баталжээ. Тухайлбал экспертүүд,

- АТГ жижиг авлигыг илрүүлж байгаа боловч өндөр түвшний авлигыг илрүүлж чадахгүй байна,

---Авилгатай тэмцэх газар тодорхой хэмжээний жижиг авилгалыг илрүүлж байгаа боловч "хүч хүрэхгүй сул" байна. Ихэнхдээ Өндөр түвшний авлигын хэргийг илрүүлж чадахгүй байна.

Монгол Улсад АТГ үйл ажиллагаагаа явуулж байгаа боловч яг цаад жинхэнэ эздийг олж чадахгүй байна. Зүгээр л наад жижиг сажиг авлигалыг илрүүлж байна.

Өндөр түвшний авлигатай хувь хүн тэмцэж чадахгүй. Авлигалтай тэмцэхэд тодорхой хэмжээний "хүчтэй" байгууллага хэрэгтэй. Манай АТГ-ын хүч, хяналт сул байна. Нөгөө талаар энэ газар маань хүний эрхийн асуудлыг маш өндөр түвшинд баримтлах хэрэгтэй.

Судлаач эрдэмтэнтэй хийсэн экспертийн ярилцлагаас

- Өндөр түвшний авлигын хэргүүд замхарч байна,

Хариуцаж, тэмцэж буй байгууллага нь нийтэд ил болсон хэргүүдийг хэрхэн шийдвэрлэхээ, шийдвэрлэж байгаа бол гэм бурууг нь хэрхэн тогтоож буйгаа хүмүүст мэдэгдэж байх хэрэгтэй байх. Боловсролын сайд Ё. Отгонбаярын хэрэг гээд л яриад байдаг. Маш их мөнгө авлигад авсан гэж байгаа хэрнээ түүнд ямар нэгэн хариу шийдвэрлэсэн, гэм бурууг нь тогтоосон, эсвэл гүтгэсэн эсэх нь тодорхойгүй л байдаг. Г.Баярцогт гишүүн хэдэн сая доллар гадаадын банкинд хадгалуулсан л гэдэг. Түүнд ямар шийтгэл оноох, эсвэл тэрхүү мөнгөө хөрөнгө орлогын мэдүүлэгтээ хэрхэн олсон тухай мэдээлэл бас л алга. Иймэрхүү хэргүүд тэгээд л замхардаг. Ард иргэдийн төр засагт итгэх итгэл ч буурсаар л байна.

Судлаач, ИНБ-ын төлөөлөлтэй хийсэн экспертийн ярилцлагаас

- АТГ-ын хүч сул, хяналт тааруу байна, чанга дэглэмтэй байлгах шаардлагатай,

АТГ зэрэг нэг байгууллага үүнтэй тэмцдэггүй. Харин улс төрчид, улс төрийн нам хүчнүүд, засгийн газар авлигын механизмыг хамтарч бүрдүүлж байж өндөр түвшний авлига багасна, алга болж ч болно. Одоогийн тэмцэж байгаа АТГ, ТЕГ мэдээж олон зүйлийг хийж байгаа гэхдээ хүч сул байна гэхүү дээ.

Өндөр түвшний авлигатай тэмцэх тогтолцоог бий болгох шаардлагатай харин яаж энэ олон луйварчдыг гаргаж ирэх ухаан сийлэх

хэрэгтэй. Гол нь “хүчний байгууллага - хүчгүй байна” гэдэг үнэхээр муу талтай. Маш чанга дээлэмтэй байлгах хэрэгтэй.

Төрийн байгууллагын экспертийн ярилцлагаас

- АТГ-ын боловсон хүчнийг чадавхижуулах хэрэгтэй,

Одоо байгаа суурь “ялзарсан” тул шинэ өөрчлөлт шинэчлэлтэнд орж чадахгүй, шинээр орсон боловсон хүчинг бас адилхан “ялзаруулж” орхидог тул үндсээр нь солих хэрэгтэй. АТГ-ын боловсон хүчний чадавхийг дээшлүүлэх мөн АТГ-ыг хянадаг тусдаа байгууллага байх шаардлага ч гарч мэднэ.

Төрийн бус байгууллагын экспертийн ярилцлагаас

зэргийг онцлохын дээр авлигатай тэмцэх газар байгуулагдсанаар тодорхой үр дүн гарсан бөгөөд авлигатай бүх түвшинд хамтарч тэмцэх нь илүү үр дүнтэй болохыг санал нэгтэй дурджээ.

Өндөр түвшний авлигатай хүн бүр тэмцэх хэрэгтэй, жишээ нь эрэн сурвалжлах сэтгүүл зүй хөгжих хэрэгтэй байна хүн бүхэн хэвлэлийн бага хурал, сонин сэтгүүл гээд ганц АТГ-ын ажил биш шүү дээ боломжтой бүх аргаар тэмцэх хэрэгтэй.

АТГ тодорхой үр дүн өгсөн гэж боддог. Үүнээс гадна Монгол Улс иргэнээ бүр багаас нь, цэцэрлэгээс эхлүүлэн ёс суртахуун хүмүүжлийг төлөвшүүлэх, соёлыг бий болгох нь чухал байна.

Төрийн байгууллагууд, олон нийтийн байгууллагууд бүгд л тэмцэх ёстой.

Долоо. Улс орнуудын туршлагад тулгуурлах, авлигатай тэмцэх сайн туршлагыг нэвтрүүлэх байдлаар тэмцэх боломжтой.

Экспертүүдийн санал болгож буй тэмцэх аргын нэг бол гадаад улс орнуудын туршлагыг судалсаны үндсэнд авлигатай тэмцэх явдал нэн чухал юм. Ялангуяа олон улсын байгууллагад ажиллаж буй экспертүүд авлигатай тэмцэг олон улсын хууль тогтоомж, арга хэрэгслийг өөрийн улсдаа нийцүүлэн буулгаж, авлигатай тэмцэх

тогтолцоог бий болгох хэрэгтэй гэдгийг энд дурдаж байна.
Хүснэгт Гадаадын улс орнуудын зарим туршлагаас

<p>Япон</p>	<p><i>"Японы засаглал бол их өндөр түвшинд гарсан улс. Дотоод хяналтыг их сайн хөгжүүлж байгаа. Өөрөөр хэлбэл тухайн газраа дотроос нь хяналт тавих, дотоод аудит хийх гэх мэт дотроос нь тавих хяналтаа сайн хөгжүүлсэн. Хэрэв хувь хүн, албан газар авлига авсан нь тогтоогдвол хамтарч үйл ажиллагаа явуулж байсан бол гэрээг нь зогсоож дахиж хэдэн жилээр хамтарч ажилладаггүй. Хар жагсаалтанд оруулдаг гэсэн үг".</i></p>
<p>Герман</p>	<p><i>"Германы жишээн дээр үзэхэд төрийн албан хаагч цалингийн 80 хувьтай тэнцэх тэтгэвэр авдаг. Мөн төрийн байгууллага болгонд авлигатай холбоотой нууц мэдээллийг авдаг тусгай хэлтэс байдаг. Германы нэг "явган шог" байдаг, Германы төрийн албан хаагчийг хахуульдахын тулд амьдарч байгаа байр, унаа тэрэг зэрэг ахуйн хэрэгцээнийх нь мөнгө болон авах ёстой тэтгэврийн бүх мөнгийг нь өгч байж авлигад гэсэн байдаг. Манайд энэ төрийн албан хаагчийн халаа сэлгээг болих хэрэгтэй тэгэхгүй бол авлига байсаар байна."</i></p>
<p>Хятад, ОХУ</p>	<p><i>"Тэмцэхдээ дан ганц орлогын мэдүүлгээр хандах нь формаль, ямархуу зүйл хийхээ цогцоор нь сайн бодох. Өөрийн улс орны нөхцөл байдалтай ойр улс Орос, Хятад гэх мэт орнуудын жишээг судлах хэрэгтэй. Хятад улсад гэхэд нэг удаа авлигад холбогдоод тэрийгээ өөрөө үнэн зөвөөр нь тухайн газраа хэлж мэдүүлэхэд хариуцлагаас нэг удаа өршөөдөг. Орос бол гадаадад байгаа үл хөдлөх хөрөнгө, данс, том корпорацийн зөвлөлд байгаа эсэхийг нь харгалзан үздэг. Мөн адил эхний удаагаа энэ асуудлаа үнэ зөвөөр нь гаргаж тавьбал асуудлаа шийдэх хугацааг нь өгч байна".</i></p> <p><i>"Манай орноос бусад нь бараг энэ асуудлаа шийдсэн байдаг жишээ нь: БНХАУ саяхан төрийн маш том өндөрлөгөө хэрхэн шийдсэн билээ шүүх хяналтын байгууллага нь үнэхээр шударга хатуу байж чадаж байна. Манайх яагаад болохгүй гэж учир нь хууль гарна хэрэгжүүлэх хүн байхгүй сая тамхины хууль гарлаа одоо оюутанууд татаад л зогсож байна энэ байдлыг болуулах хэрэгтэй байна".</i></p>
<p>Солонгос</p>	<p><i>Солонгос улсын жишээг авч үзэхэд: Шүүх засаглал нь хамгийн их эрх мэдэлтэй шүүхээсээ ч их айдаг мөн иргэдийнхээ дуу хоолойг тусгаж, гомдолыг нь хянаж үздэг, иргэд нь ч их санаачлагатай нэгдэж чаддаг, тэмцэж чаддаг. Бас Аудитын байгууллага нь санхүүгийн бүх үйлдэлийг хянаж байдаг. Өөрөөр хэлбэл шүүх нь ёс зүйг нь хянаж аудит нь санхүүг нь хянах зэргээр салбар салбараар нь хяналт хийж чаддаг".</i></p>

“АВЛИГА ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛД НӨЛӨӨЛӨХ НЬ”

Англи	<p>“Миний хамгийн сайн мэдэх Англи улс л гэхэд авлигалтай тэмцэх хууль 2011 оны 1 сараас хүчинтэй болж эхэлсэн. Англи улс өөрсдийн нэр хүндийг өсгөхийн тулд авлига өгөх, авах үйлдлийг хууль эрх зүйн хүрээнд маш чанга шийдэж чадсан байдаг. Бүр үүнийг ажлын хэлбэрт оруулж хэвшүүлж өгсөн байдаг. Жишээ нь нэг хүнээс набор чихэр өгөх авах төдийд заавал мөнгөн дүнгээр бичиж тухайн иргэнээс бэлэг гэдэг утгаар нь авсанаа бичгээр үйлдэж дээд холбогдох албан тушаалтанд өгдөг буюу бүртгүүлдэг”.</p>
Турк	<p>“Турк улсын хувьд хууль нь чанга, авлигын хэрэгт холбогдвол дахин төрийн албанд орж ажиллах эрхгүй болдог. Ер нь эхнээс нь буюу хүүхэд байхаас нь хууль тогтоомжийг дагаж мөрдөж сахихын ач холбогдолыг ухуулан таниулж сайн бэлдэх хэрэгтэй”.</p>
Польш	<p>“Польшид, төрийн үйлчилгээний унааг бүгдийг нь ижил өнгөөр будсаны дараагаар шатахууны зардал эрс багассан жишээ бий. Энэ нь олон нийтийн хяналтын механизмыг хоосон уриагаар бус энгийн бөгөөд бодитой аргаар өгөөжтэй ашигласан хэрэг”. Түүнчлэн энэ улс төрийн албыг байгуулахдаа боловсрол, төрийн албаны ёсзүйг төлөвшүүлэхийг голлодог.</p>
Ботсван	<p>“Та авлигагүй бүсэд нэвтэрч байна” хэмээн Ботсван улсын нэгэн сайд хаалган дээрээ бичсэн явдал бол энэ үзэгдэлтэй ил цагаан тэмцэж буй хэрэг юм. Бид ч мөн ингэж тэмцэж болох шүү дээ.</p>
Бусад	<p>“Авлигатай тэмцэхийн тулд авлига авахыг урдчилсан сэргийлэх тогтолцоог сайжруулах хэрэгтэй. Ж нь: JICA-гийн төслөөр хэрэгжсэн татварын нэг цонхны үйлчилгээний систем, мөн ажилтнуудаа нэг дор удаан байлгалгүй байрыг нь сольж ажиллуулж байгаа нь үр дүнгээ өгч байгаа гэж бодож байна.</p> <p>Яг одоо эдийн засаг хямарч байгаа ч ойрын үед уул уурхай буцаж сэргэнэ, тийм болохоор мөнгөний эргэлтийг хянаж, зарцуулах чадвартай байгууллага байх нь чухал. Улс орон эдийн засгийн хөгжлөө хангаж чадахгүй бол нийгмийн амар тайван байдал алдагдахад хүрнэ. Мөн монгол улс асар их хэмжээний зээл авч байгаа нь гадаад улс орноос хамааралтай болгож байна гэсэн үг. Эдгээрээс үүдэн үндэсний аюулгүй байдал нөлөөлөх хэмжээний аюул үүснэ. Герман улс гэхэд төсөв нь тогтвортой өр шир бага байх тийм төрийн бодлого явуулдаг”.</p>

Дээр дурдсан саналуудаас гадна авлигатай тэмцэх асуудлаар гутранги шинжтэй хариулт, хүлцэнги шинжтэй үзэл хандлагууд ч иргэний нийгэм, судлаачдын дунд бий болоод байгааг энд дурдаж болох юм. Ялангуяа судалгааны байгууллага, иргэний нийгмийн байгууллагын экспертүүд өндөр түвшний авлигатай

тэмцэх нь бараг боломжгүй, улс орнуудад тэмцсээр байгаа боловч бүрэн шийдвэрлээгүй, шийдвэрлэхэд төвөгтэй хэмээх хариулсан нь анхаарал татаж байна.

Ийнхүү үзсэн байр суурь, шалтгааныг дэлгэрүүлэн авч үзэхэд,

Байр суурь

- Өндөр түвшний авлигатай тэмцэх нь ярвигтай ажил.
- Хариуцлага хүлээлгэж чадахгүй байна.
- ӨТА-ыг багасгана, бууруулна гэсэн итгэл найдвар байхгүй байна.
- Хариуцлага тооцох, илрүүлэхэд төвөгтэй.



Шалтгаан

- төрийн өндөр албан тушаалтнууд бүгд бие биенийхээ барьцаанд байдаг. Тэд бүгд нэг сүлжээнд буюу аалзны торонд орчихсон байдаг...
- Намын тогтолцоо өөрчлөгдөхөд бүх зүйл дагаад өөрчлөгддөг энэ асуудал байсан цагт ӨТА-тай тэмцэнэ гэж ярих хэцүү...
- Тогтолцоо буруу, олон түмний сэтгэл зүй, сэтгэхүйд нь улс орны удирдлага авлига авдаг гэсэн ойлголт тогтсон, үүнтэйгээ эвлэрсэн байдал ажиглагддаг...
- Тэмцдэг байгууллагын “хүч” хүрэхгүй байна, учир нь аалзны төр байгаа болохоор...

Дүгнэлт

Өндөр түвшний авлига ба үндэсний аюулгүй байдлын харилцан нөлөөллийн хувьд,

- Судалгааны үр дүнд тулгуурлан авч үзэхэд авлига бол хавтгайрсан шинжтэй нийгмийн үзэгдэл болсон, үүнийг бууруулах, таслан зогсоох асуудал маш их эрсдэл, хүч шаардсан ажил гэдгийг нийгмээрээ хүлээн зөвшөөрч байна.
- Авлигын олон шатлалт хэлбэрүүд Монголд нэгэнт бий болсон талаар иргэд, судлаачид дүгнэн хэлж байна. Эрх мэдэл, албан тушаал, нам бүлгээрээ хамтран үйлддэг, хамрах хүрээ нь их өргөн, учруулах хохирол нь улам бүр нэмэгдэх хандлагатай болсон байгааг судалгаа харуулж байна. Авлига улам бүр далд, нарийн болж буйг онцолсон байна.
- Өндөр түвшний авлига нь эрх мэдэл, албан тушаалтай холбоотой, хуулийн цоорхойг ашигладаг, маш өндөр зохион байгуулалттай, дээд түвшний, учруулах хор хөнөөл, үр дүнгээрээ нийгэмд асар их хортой зүйл болох нь батлагдаж байна.

- Өндөр түвшний авлига бол улс үндэстний аюулгүй байдалд ноцтой хохирол учруулж болох хүчин зүйл болох нь нотлогдож байна.
- Шинжээчдийн үзсэнээр өндөр түвшний авлига бүлэглэн үйлддэг, цөөн тохиолдолд илэрдэг, доод шатнаас дээд шат хүртэл нарийн шат дамжлагаар үргэлжилсэн, нийгмийн сөрөг үзэгдэл ажээ.

Өндөр түвшний авлигын ойлголт, шалтгаан ба үр дагаварын хувьд,

- Экспертүүдийн үзэж байгаагаар *улс үндэстний нууцтай холбоотой бичиг баримтыг гадагш нь гаргах, ашигт малтмалын лиценз худалдаалах, зарах, уул уурхайд холбогдох тендер, гэрээ хэлэлцээр, төсөл, буцалтгүй тусламж, газар нутгийн худалдаа зэрэг* улс орны хөгжил, нийгэм, улс төр, эдийн засгийн амьдралд үзүүлэх сөрөг үр нөлөө, үр дагаварын хувьд маш хохиролтой, улс орны удирдлагын дээд түвшинд холбогдох авлигыг өндөр түвшний авлигад тооцдог.
- Өндөр түвшний авлигын *цаана улс төрийн болон бизнесмэнүүдийн тохиролцоо явагдахын зэрэгцээ* мөнгөний хэмжээнээс гадна шийдвэрлэгдэж буй асуудлын цар хүрээ, түвшин, ач холбогдол илүүтэй яригддаг аж.
- Өндөр түвшний авлигын хэмжээг шинжээчид үзэхдээ улс орны *эдийн засгийн хөгжилд болон үндэсний аюулгүй байдалд нөлөө үзүүлэхүйц хэмжээний тухай яригддаг бөгөөд нэг болон түүнээс дээш тэрбум төгрөгийн асуудлууд юм гэжээ.*
- Өндөр түвшний авлига нь өргөн хүрээндээ төрийн байгууллагын бүх шатанд, ялангуяа шийдвэр гаргах шатанд, явцуу хүрээндээ улс орны удирдлагын түвшинд, үндэсний аюулгүй байдалтай холбоо бүхий байгууллага, албан тушаалтны түвшинд, улс төрийн шийдвэр гаргах түвшинд шууд хамаатай тул олон нийтийн зүгээс нөлөө үзүүлэх боломж маш бага байдгаар өндөр түвшний авлига нь ялгардаг байна.

- Өндөр түвшний авлига нь эрх мэдлээ урвуулан ашиглах, улс төрийн эрх мэдэл олж авахтай холбоотой байна. Төрийн эрхийг сонгуулийн замаар олж авах үйл ажиллагаа гажуудсан нь өндөр түвшний авилгын нэг эх сурвалж болж байна. Сонгуульд нэр дэвших болон сонгуулийн кампанит ажлын зардал сонгуулиас сонгуульд өсөн нэмэгдсээр байгаа нь улс төрийн намуудыг мөнгөнөөс хараат болгож байна. Энэ байдал нь намуудыг засгийн эрх авсаны дараа эрх мэдэл, албан тушаалаа ашиглан бусдад давуу байдал олгох үүдийг нээж байна.
- Улс төрийн болон сонгуулийн тогтолцоо, засаглалын буруу хуваарилалт, хийрхэл, эрх ашиг, эрх мэдлийн төлөөх шунал, ашиг сонирхол, амбиц, амин хувиа үзэл, ёс зүйгүй байдал зэрэг нь өндөр түвшний авлигын нөхцлийг бүрдүүлж байна. Мөн Үндсэн хууль дээдлэх, хуульт ёсыг удирдлага болгох явдал алдагдаж буй нь өндөр түвшний авлига явагдахад нөлөөлөхөөс гадна энэ нь нэг хүний эрх ашгаар хязгаарлагдахгүй, улс төрийн тодорхой бүлэглэлийн эрх ашигтай холбоотой байгааг экспертүүд онцлон тэмдэглэж байна.
- Хуулиас давсан улс төржилт нь өндөр түвшний авилгыг дэврээх бас нэг хөшүүрэг болж байна. Нийгэмд асар их хор хохирол учруулсан эрх мэдэлтэнгүүдийг намууд, түүний хүрээний улс төрчид хамгаалж өмгөөлдөг байдал нь газар авах хандлагтай байна.
- Өндөр түвшний авлига нь нийгэм эдийн засгийн хөгжил, ард иргэд, хувь хүн, гэр бүл, хамт олон зэрэг нийгмийн бүхий л гишүүд, бүхий л хүрээ хэсэгт хор хөнөөлтэй байна.

Авлига болон өндөр түвшний авлигатай тэмцэх тухайд,

- Авлига, өндөр түвшний авлигатай үр дүнтэй тэмцэх явдал бол эцсийн дүндээ үндэсний аюулгүй байдлыг хамгаалах арга зам мөн.
- Шинжээчид авлига, өндөр түвшний авлигын зааг ялгааг тодорхойлон гаргасны зэрэгцээ авлигын эдгээр төрөл хэлбэртэй тэмцэх хэд хэдэн арга зам, боломжийг санал болгосон.

- Авилгатай амжилттай тэмцэхийн тулд ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах цар хүрээг боловсронгуй болгох, улс төрийн намын санхүүжилт, олон нийтийн мэдээлэл авах боломж зэрэгт гол анхаарлаа хандуулах хэрэгтэй болохыг экспертийн судалгааны дүн харуулж байна.
- Авилгатай тэмцэх сайн бодлого гэж юуг хэлэх вэ гэдэг экспертийн санал бодлын зөрөлдөөн нь асуудлыг цогц байдлаар авч үзэхийг өөрийн эрхгүй шаардаж байна.
- Албан тушаалын томилгоо, улс төрийн засаглалтай шууд холбоотой байх нь 1-рт, төрийн алба ашиг сонирхлын золиос болох, 2-рт, төрийн албан хаагчийн хувьд тухайн албан тушаалдаа ажиллах хугацаа тодорхой бус болж, энэ нь эргээд авилгын орчныг тэтгэдэг хүчин зүйлийн нэг болдог байна.
- Авилгаас хүлээх хариуцлага байхгүй байгаа нь авилгыг дэврээж байна. “Хариуцлагатай удирдлага бол, хэдийгээр бид авилгыг зөвхөн хувь хүний зан суртахууны асуудал гэж үзэхгүй байлаа ч гэсэн авилгатай тэмцэх стратегийн гол хэсэг нь юм” [Moses, M. Towards Understanding Mission and Witness. Delhi, 2002, 50] гэсэн санааг авилгатай тэмцэхэд чухал хэмээн бид үзэж байна.
- Ашиг сонирхлыг хязгаарлах, зохион байгуулалттай гэмт хэргийг илрүүлэх, сонгуулийн авлигатай тэмцэх, албан тушаалын/бялуу хуваах гм/ авлига, тендэрийн будлиан, ашиг сонирхолын түгээмэл зөрчлүүдийг хориглох, илрүүлэх зэрэг нь өндөр түвшний авлигатай тэмцэхэд чухал нөлөөтэй.
- Авилгыг зөвхөн гэмт үйлдэл төдийгөөр хязгаарлан эрүүгийн хууль, төрийн албан хаагчийн хуулийн хүрээнд шийдвэрлэхийг оролдох нь тийм ч өгөөжтэй арга зам биш. Энд авилгыг ихэнх хүмүүсийн ойлгодог шиг тогтсон хууль дүрмийг зөрчих төдийгөөр явцуу хүрээнд ойлгож болохгүй.
- Авилгатай тэмцэх дээр дурдсан арга зам, боломжууд тухайн улс орны болоод салбарын онцлог, авилгын төрөл хэлбэрүүдээс хамаараад үр өгөөж нь харилцан адилгүй байж болох юм.
- Иймд төрийн болоод төрийн бус байгууллага, мэргэжлийн болоод мэргэжлийн бус бүхий л салбар, хувь хүний өөрийнх

нь болоод нийт нийгмийн хувьд хяналтын механизмыг сайжруулж, хариуцлага ёс зүйг дээшлүүлэх явдал ихээхэн чухал юм.

- Авилгыг багасгаж, шударга ёсыг дээшлүүлэхэд авилгатай өөртэй нь төдийгүй, авилгын орчинтой нь тэмцэх хэрэгтэй гэсэн үзэл баримтлалыг гол болгох нь гадаад орнуудын туршлагыг харахад ч, эл судалгааны үр дүнгээс үзэхэд ч илүү үр өгөөжтэй гэдэг нь харагдаж байна.
- Экспертүүдийн ихэнх нь Авилгын эсрэг мэдээлэл, сургалтыг өргөжүүлэх, ингэхдээ ерөнхий боловсролын болон их дээд сургуулийн хөтөлбөрт авилгын эсрэг сэдэв оруулах нь чухал гэж үзэж байна. Үүний дээр аль ч салбарт авилгын эсрэг сургалт сурталчилгаа чухал бөгөөд үнэн зөв мэдээлэл түгээх, хүмүүсийг мэдээ мэдээлэлтэй байлгах нь дээрхээс ч илүүтэй чухал юм.
- Авлигатай тэмцэж, шударга ёсыг бэхжүүлсний үр дүнд нийгэм, хувь хүний хөгжил дэвшил илүү нээгдэх болно.

САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Нэгд. Хууль эрхийн хүрээнд төдийгүй, түүнээс гадуур өргөн хүрээнд тэмцэх

Авлига, өндөр түвшний авилгыг тогтсон хууль дүрмийг зөрчих төдийгөөр үзэж болохгүй. Эл түвшний авлигатай тэмцэхийн тулд нэр томъёог оновчтой болгохоос эхлээд зонхилон үйлдэгдэж буй хэлбэр, хор уршиг, тэмцэх ба илрүүлэх, зохицуулах арга замын талаар холбогдох хуульд зүйл заалт оруулах шаардлагатай.

Хоёрт. Улс төр, эдийн засгийн хандлагаар авлигатай тэмцэх

Авлига, өндөр түвшний авилгаас үүдэн төр засаг “сульдаж”, “хүчгүйдэж” нэг ёсондоо аюулгүй байдлын үндэс алдагдаж байдаг. Төрийн бодлого тодорхой, нэгдсэн үзэл хандлагатай, улс төрийн тогтолцоог шинэчлэх, өөрчлөх явдал хойшлуулшгүй чухал юм.

Дан ганц авилгалтай өөртэй нь тэмцэх бус харин макро орчныг сайжруулах замаар бүхий л түвшний авлигатай тэмцэх хэрэгтэй.

Гуравт. Төрийн албанд захиргааны хяналт тогтоож, хариуцлага, дүрэм журмыг сахиулах байдлаар тэмцэх

Ард түмэн төр засагт итгэхээ болих, авлигыг төрийн албанд, дээд түвшинд, эрх мэдэлтнүүд ихээхэн авдаг хэмээх “сэрдлэг” нь авлигыг нийт нийгэм даяар “дэврээж”, улмаар “хүн бүр байх ёстой ердийн зүйл” хэмээн хүлээн авах явдал хааяагүй байсаар байна. Ил тод, хараат бус, бие даасан байдлыг хариуцлага, ёс зүйтэй зөв хослуулах нь ихээхэн чухал бөгөөд төрийн албанд дээрх нөхцлийг хангаснаар авлигын эсрэг үр дүнтэй тэмцэж болно.

Дөрөвт. Ёс зүй, иргэний нийгмийн ил тод байдлыг хангах замаар авлигатай тэмцэх

Хөрөнгө орлогын мэдүүлгийг(ХОМ)” хянан шалгах ажлыг зохион байгуулах ажил нь ёс төдий бөгөөд, авлигыг илрүүлэх, тэмцэх үндсэн аргачлал болж чадахгүй байна. Улс төр, төрийн албан тушаал, эрх ямба эдэлж буй хүмүүсийн хариуцлага сайжирч, төсвийн зарцуулалтыг ил тод болгох явдал бол авлигыг ихээхэн багасгаж болох арга зам мөн.

Авлигын шинжээчид иргэний нийгмийг хөгжүүлснээр нийгэмд ёс зүйг төлөвшүүлж, шударга ёсыг тогтоох боломжтой гэж үзсэн. Ингэхдээ иргэний нийгмийг бэхжүүлж чадавхижуулах, төсвийн хуваарилалтыг баг, хороо зэрэг төрийн анхан шатны нэгжээс эхлээд дээд түвшинд хүртэл нээлттэй, ил тод болгохын чухлыг тэмдэглэсэн.

Тавд. Өндөр түвшний авлигатай тогтолцоот хандлагаар, цогц хэлбэрээр тэмцэх

Тогтолцоот хандлагаар тэмцэнэ гэдэг нь авлигыг хамрах хүрээгээр нь, авч буй эздээр нь, илрэх хэлбэрээр нь, үйлдэгдэж буй түвшнээр нь нэгэн бүхэл систем хэмээн харж, тэмцэх хэлбэрийг хэлж байна. Тухайлбал, төрийн дээд өндөрлөгөөс дунд, доод

шат хүртэл, хууль эрх мэдлээс ёс зүй, дүрэм журмыг хэрэгжүүлэх хүртэл, төрийн байгууллагаас төрийн бус иргэний нийгэм хүртэл, авлигыг үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх хүртэл, гадаад улс орны туршлагаас өөрийн орны онцлог хүртэл бүхий л түвшин, хүрээнд цогц хэлбэрээр тэмцэх шаардлагатай.

Зургаа. Дагнасан мэргэжлийн байгууллага, түүний үйл ажиллагааг “хүч”-тэй, “далайц”-тай болгох замаар тэмцэх

Авлигын төрөл хэлбэр, хор хөнөөл, үр дагаварыг бууруулахад тухайн асуудлыг хариуцаж буй байгууллагын үйл ажиллагаа хангалтгүй, хүч сул байгаа нь гол асуудал болж байна. Иймд авилгатай тэмцэх газрыг “хараат бус”, “чанга дэглэмтэй”, “боловсон хүчнийг чадавхижуулж”, “ахуй хангамжийг нэмэгдүүлэх” байдлаар тэмцэж болох аж.

Долоо. Улс орнуудын туршлагад тулгуурлах, авлигатай тэмцэх сайн туршлагыг нэвтрүүлэх байдлаар тэмцэх

Авилгатай тэмцэх аргын нэг бол гадаад улс орнуудын туршлагыг судалсаны үндсэнд авлигатай тэмцэх явдал нэн чухал юм. Ялангуяа олон улсын байгууллагад ажиллаж буй экспертүүд авлигатай тэмцэг олон улсын хууль тогтоомж, арга хэрэгслийг өөрийн улсдаа нийцүүлэн буулгаж, авлигатай тэмцэх тогтолцоог бий болгох хэрэгтэй.

V. ХАВСРАЛТ.

ХАВСРАЛТ 1. ЭКСПЕРТИЙН ЯРИЛЦЛАГА ХИЙХ УДИРДАМЖ

СУДАЛГААНЫ ЗОРИЛГО

Үндэсний аюулгүй байдлын байнгын хороо, АТГ-ын захиалгаар “Үндэсний аюулгүй байдал ба өндөр түвшний авлига”-ын талаарх ойлголт, төсөөлөл, нөхцөл, шалтгааныг судлан, зөвлөмж боловсруулах зорилгоор энэхүү судалгааг явуулж байна.

Энэхүү судалгааг УИХ, АТГ, МУИС-ийн Улс төр судлалын тэнхим, Социологи, нийгмийн ажлын тэнхим хамтран гүйцэтгэж байгаа юм. Энэхүү судалгаа бол Улаанбаатар хотод хийгдэж буй сэдэвчилсэн, чанарын судалгаа юм.

ЖИЧ: Таны өгсөн мэдээллийг Монгол Улсын хувь хүний нууцыг хадгалах хуулийн дагуу чандлан хадгална.

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- Ярилцлагыг сонгон авсан эксперт хүмүүсийн(хавсралт.1-д тусгасан)дунд явуулна.
- Судлаач ярилцлага хийхэд анхаарах зүйл болон ёс зүйн дүрэмтэй танилцсан байна.
- Ярилцлагын үргэлжлэх хугацаа 1 цаг орчим байна.
- Ярилцлагыг 2 судлаач явуулах ба нэг нь (модератор) ярилцлагыг удирдаж, нөгөө нь(туслах судлаач) тэмдэглэл хөтөлнө.
- Ярилцлага чөлөөтэй өрнүүлэх боломжтой орчин нөхцөл сонгоход судлаач анхаарна.

СУДАЛГААНЫ ТАНИЛЦУУЛГА

Экспертийн ярилцлага хийхийн өмнө ярилцлага чөлөөтэй өрнүүлж болохуйц байр, өрөөг урьдчилан бэлтгэсэн байх ба цаас, бал, харандаа зэргийг бэлдсэн байна.

Судалгааг эхлэхийн өмнө товч танилцуулга хийнэ. Тухайн судалгаа нь Үндэсний аюулгүй байдлын байнгын хороо, АТГ-ын

захиалга бөгөөд “Үндэсний аюулгүй байдал ба өндөр түвшний авлига” сэдэвтэй болохыг танилцуулна. Судлаачид өөрсдийгөө мөн танилцуулна.

Модератор, тэмдэглэл хөтлөгчийн аль алин нь хэлэлцүүлгийн төлөвлөгөөний дагуу ярилцлагыг явуулах, тэмдэглэл хөтлөхөд сайтар бэлдэж, ярилцлагын бүхий л үе шатанд тусгасан хариулыг нэгбүрчлэн тэмдэглэхэд анхаарна.

Танилцуулгын дараа, ярилцлага эхлүүлэхийн өмнө “нүүр хагарах” зорилгоор асуулт асууж, хариулт авч болно. Энэ нь ярилцлагыг идэвхитэй өрнүүлэх уур амьсгалыг бүрдүүлэхэд чиглэнэ. Тухайлбал, ярилцлагын өмнө экспертээс өөрсдийнхөө санал бодлыг нээлттэй илэрхийлэх, санал бодлыг нь хүндэтгэж сонсох, нууцыг чандлан хадгалах талаар танилцуулж болох юм.

Энэ үед тэмдэглэл хөтлөгч экспертийн ярилцлага хийгдсэн огноо, эхэлсэн хугацааг тэмдэглэнэ. Мөн хаана, хэзээ, ямар хугацаанд хийгдсэнийг тэмдэглэнэ. Үүний дараагаар хэлэлцүүлгийн үндсэн хэсэгт шилжинэ.

СУРВАЛЖЛАГЫН ПРОТОКОЛЫН ДУГААР №.....
СУДЛААЧИЙН ДУГААР №

ЯРИЛЦЛАГА ХИЙГДСЭН ГАЗАР:
ЯРИЛЦЛАГА ХИЙГДСЭН ОГНОО:
ЯРИЛЦЛАГА
ЭХЭЛСЭН.....
ДУУССАН.....

A. СУРВАЛЖЛАГАД ОРОЛЦОГЧИЙН ХУВИЙН МЭДЭЭЛЭЛ

1. Таны нас [.....]

2. Таны хүйс 1.Эрэгтэй 2.Эмэгтэй

3. Таны боловсрол

- | | | |
|-------------------|---------------------------|--------------|
| 1. Дээд | 2. Тусгай дунд | 3. Бүрэндунд |
| 4. Бүрэн бус дунд | 5. Бага буюу боловсролгүй | |

4. Таны боловсролын төвшин дээд бол чухамхүү аль ангилалд багта хвэ?

- | | | |
|--------------|--------------|------------|
| 1. Бакалавр | 2.Магистрант | 3. Магистр |
| 4. Докторант | 5.Доктор | |

5. Таны мэргэжил

- | | |
|--------------------------|----------------------|
| 1. Нийгэм, эдийн засгийн | 2.Техник, инженерийн |
| 3. Улс төр, хууль эрхийн | 4.Байгаль шинжлэлийн |
| 5.Эрүүл мэндийн | 6. Бусад..... |

6. Эрхэлж буй ажил, авлигын чиглэлээр ажилласан туршлага?

B. БҮЛЭГ АСУУЛТУУД

Ярилцлагын үндсэн шатанд тухайн асуудалд чиглэсэн хэлэлцүүлгийн төлөвлөгөөний дагуу ярилцлагыг өрнүүлнэ.

Бүлэг асуулт-1. Үндэсний аюулгүй байдлын тухай:

Үндэсний аюулгүй байдлыг хэрхэн үздэг вэ?, Монгол Улсын үндэсний аюулгүй байдалд нөлөөлөх бодит аюул заналхийлэл таны бодлоор чухам юу вэ?/нэрлэнэ үү/, Авлига хэмээх үзэгдэл үндэсний аюулгүй байдалд хэр зэрэг нөлөө үзүүлэх вэ, санал бодлоо хуваалцана уу?

Бүлэг асуулт-2. Өндөр түвшний авлига(Grand corruption)-ын талаарх ойлголт: Өндөр түвшний авлига гэдэг ойлголтын доор чухам юуг ойлгож байна вэ?, Өндөр түвшний авлига болон авлига хоёрын ялгаа юу вэ?

Зарим улс оронд/Тух-бал ОХУ-;/ өндөр төвшний авлига гэдгийг төр, засгийн өндөр албан тушаалтнуудад хамааруулж ойлгодог. Улс орнуудад харилцан адилгүй нэрлэдэг: их авлига, дээд түвшний авлига гм. Мөнгөний хэмжээнээс, улс орны эрх ашгийг хөндөж байгаагаас, улс төрийн ямар нэг сонирхол агуулж байгаагийн чухам аль нь вэ?*Судлаач эдгээрийг санаа өгөх үүднээс асууна, заавал асуух хэрэггүй.*

Бүлэг асуулт-3. Өндөр түвшний авлигын төрөл хэлбэр юу вэ?. Хаана/ямар байгууллагад/, хэн/ямар албан тушаалтан/ үйлдэж байна вэ?, өндөр түвшний авлига чухам ямар төрөл хэлбэр, хэмжээтэй байдаг вэ?, Монголд өндөр түвшний авлига бий эсэх?, Ихээхэн тархсан хэлбэрүүдээс 3 хүртэлх өндөр түвшний авлигыг нэрлэнэ үү?. Өндөр түвшний авлигын шалтгаан, нөхцөл юу вэ?

Бүлэг асуулт-4. Өндөр түвшний авлигын хор хөнөөл, үр дагаварын талаар өөрийн саналаа хуваалцана уу?. Улс орны болон үндэсний аюулгүй байдалд хэрхэн нөлөөлж болох талаар өөрийн санал бодлоо хуваалцана уу? Өндөр түвшний авлигын хохирогч хэн байдаг вэ? Өндөр түвшний авлигын нийгмийн хор хөнөөл\төр засаг, хувь хүн, гэр бүл гм\-ийн талаар ярина уу?

Бүлэг асуулт-5. Өндөр түвшний авлигатай хэрхэн тэмцэх вэ?: Өндөр түвшний авлигыг бууруулах, тэмцэх талаар улс орнуудын туршлага байдаг эсэх. Өндөр түвшний авлигатай тэмцэх боломжтой эсэх, Монгол Улсад хэрхэн тэмцэх ёстой вэ?, ямар байгууллага/ эсвэл хувь хүн тэмцэх ёстой вэ, тэмцэж чадаж байгаа эсэх? Өндөр түвшний авлигатай тэмцэхэд юу саад болж байна вэ? Өндөр түвшний авлига авсан албан тушаалтанд хариуцлага хүлээлгэж чадаж байгаа эсэх, чадахгүй бол яагаад? Өндөр түвшний авлигатай тэмцэхэд тогтолцоог бий болгох шаардлагатай юу?

6.Нэмэлт мэдээлэл. Хэрэвэкспертэд өндөр түвшний авлигыг бууруулах талаар санал байгаа, эсвэл гадаад улс орнуудын туршлагыг дурдах бол, үүнийгээ тодорхой жишээн дээр тайлбарлахыг хүснэ. Судлаачийн зүгээс дээр дурдсан асуултыг асуухын зэрэгцээ өөр санал, байр суурийг тэмдэглэнэ.

В. СУДАЛГААГ ДУУСГАХ

Судалгаа тавьсан зорилгодоо хүрсэн эсэх, судалгааны асуултад хариулсан байдлыг судлаач шалгаж үзнэ. Эргэлзээтэй, тодруулвал зохих асуултуудыг дахин асууж, лавлаж болно.

Ойлгоогүй, эсвэл нэмэлт санал байгаа эсэхийг дахин лавлаж асууна уу.

Судлаач ярилцлага хийгдсэний дараа ярилцлагын үйл явцыг тэмдэглэж, гол олдворыг сийрүүлнэ. Зөрчилтэй, харилцан адилгүй тэмдэглэлүүдийг ярилцлага хийсэн тухай бүртээ харилцан ярилцаж, дүгнэн, нэгдсэн ойлголттой болоход анхаарч ажиллана.

ТАНД АМЖИЛТ ХҮСЬЕ.
СУДАЛГААНЫ БАГ

ХАВСРАЛТ 2. АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД
ХОЛБОГДОХ ХУУЛИЙН ЖАГСААЛТ

Монгол Улсын хууль:

1. Монгол Улсын Үндсэн хууль /1992/
2. Авлигын эсрэг хууль /2006/
3. Авилгалын эсрэг НҮБ-ийн конвенцийг соёрхон батлах тухай /2005/
4. Төрийн албаны хууль /2002/
5. Эрүүгийн хууль /2002/
6. Эрүүгийн байцаан шийтгэх тухай хууль /2002/
7. Галт зэвсгийн тухай хууль /1997/
8. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль /1997/
9. Гүйцэтгэх ажлын тухай хууль /1997/
10. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль /1995/
11. Байгууллагын нууцын тухай хууль /1995/
12. Төрийн нууцын тухай хууль /1995/
13. Төрийн нууцын жагсаалт батлах тухай /2004/
14. Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хууль /2002/
15. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай /2006/
16. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай /2006/
17. Нийгмийн даатгалын тухай /1994/
18. Төрийн албан ёсны хэлний тухай /2003/
19. Хөдөлмөрийн тухай /1999/
20. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай /1996/
21. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай /2005/

УИХ-ын тогтоол:

1. 2002 оны 41 дүгээр тогтоол, Үндэсний хөтөлбөр батлах тухай
2. 2007 оны 3 дугаар тогтоол, Авлигатай тэмцэх газрын зохион байгуулалтын бүтэц, орон тоог батлах тухай
3. 2007 оны 7 дугаар тогтоол, Авлигатай тэмцэх газрын албан хаагчид зэрэг дэв, нэмэгдэл олгох журам

4. 2007 оны 9 дүгээр тогтоол, Хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт, түүнийг бүртгэх, хадгалах журам батлах тухай
5. 2008 оны 9 дүгээр тогтоол, Авлигатай тэмцэх газрын албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай

Засгийн газрын тогтоол:

1. 2009 оны 143 дугаар тогтоол, Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт батлах тухай
2. 2010 оны 98 дугаар тогтоол, Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм

Авлигатай тэмцэх газрын даргын тушаал:

1. 2008 оны 13 дугаар тушаал, Албан хаагчийн тангараг өргөх журам
2. 2007 оны 25 дугаар тушаал, Авлигатай тэмцэх газрын хөдөлмөрийн дотоод журам
3. 2007 оны 38 дугаар тушаал, Авлигатай тэмцэх газрын албан хаагчийн сахилгын дүрэм
4. 2007 оны 61 дүгээр тушаал, АТГ-ын албан хаагчид өргөдөл, гомдлыг хүлээн авч, шийдвэрлэх журам
5. 2008 оны 39 дүгээр тушаал, АТГ-ын албан хаагчийн ёс зүйн дүрэм
6. 2007 оны 62 дугаар тушаал, АТГ-ын албан хэрэг хөтлөлтийн заавар
7. 2007 оны 71 дүгээр тушаал, АТГ-т иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг бүртгэх, Өргөдөл, гомдлын мэдээ гаргах маягтын хамт
8. 2007 оны 89 дүгээр тушаал, Хөрөнгө, орлогын мэдүүлгийн талаар мэдээлэх, мэдээлэл өгөх журам

ТЭМДЭГЛЭЛ

ТЭМДЭГЛЭЛ
